



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-38</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>39-139</i>
1. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	42-53
2. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	53-94
3. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	94-100
4. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	100-119
5. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	119-120
6. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	120-121
7. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	121-126
8. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	126-128
9. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	128-131
10. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	131-139

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяа, А.Адъяасүрэн, Г.Амартүвшин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Ганбаатар, Г.Ганболд, Б.Жавхлан, Д.Сарангэрэл, Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: П.Анужин, Ё.Баатарбилэг, Д.Батлут, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Ч.Ундрэм, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ш.Раднаасэд;

Хоцорсон: Э.Батиугар-42 минут, Х.Болорчулуун-12 минут, Д.Ганбат-5 цаг 00 минут, Н.Ганибал-44 минут, Т.Доржханд-08 минут, Г.Мөнхцэцэг-19 минут, Д.Өнөрболор-1 цаг 44 минут, Б.Саранчимэг-29 минут, Д.Цогтбаатар-12 минут, Б.Энхбаяр-10 минут, Ж.Эрдэнэбат-4 цаг 05 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханд төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлэв.

Нэг.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, “Ажил олгогчдын нэгдсэн холбоо”-ны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Энхболд /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага, мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбарын мэргэжлийн нэгдсэн холбоонд энэ хууль үйлчилнэ.

3.2.Мэргэжлийн холбоо болон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

3.3.Энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“мэргэжлийн холбоо” гэж салбар, эсхүл мэргэжлийн эрх ашгийг хамгаалах зорилгоор аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, тухайн салбарын мэргэшсэн хүнээс бүрдсэн гишүүнчлэл бүхий холбоог;

4.1.2.“мэргэжлийн нэгдсэн холбоо” гэж тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын гишүүнчлэлтэй, салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий холбоог.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 10
Бүгд: 42
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “Мэргэжлийн нэгдсэн холбооны тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүрэг” гэснийг “Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах, түүнд тавигдах шаардлага

5.1.Мэргэжлийн нэгдсэн холбоог тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоод хамтран үүсгэн байгуулна.

5.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

5.2.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийг батлах;

5.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох;

5.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг батлах;

5.2.4.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.

5.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах шаардлагыг хангасан байна:

5.3.1.тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй байх;

5.3.2.энэ хуулийн 5.3.1-д заасан гишүүд нь тухайн салбарын зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын тавиас дээш хувийг эзэлдэг байх.

5.4.Тухайн салбарын мэргэжлийн холбоо дангаар, эсхүл олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй бол энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн бүртгүүлж, мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 10

Бүгд: 42

76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт

6.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

6.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг Улсын дээд шүүхийн баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд уг холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурна:

6.2.1.хүсэлт гаргасан он, сар, өдөр;

6.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны нэр;

6.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны хаяг;

6.2.4.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээлэл.

6.3.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

6.3.1.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл, уг шийдвэр болон хурлын тэмдэглэлд ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан байна;

6.3.2.мэргэжлийн нэгдсэн холбооны бүтэн болон товчилсон нэр;

6.3.3.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм;

6.3.4.мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдийн бүртгэл, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.3.5.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан гишүүнчлэл, зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтыг нотолсон баримт бичиг;

6.3.6.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

6.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 6.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг энэ хуулийн 6.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 10

Бүгд: 43

76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт, баримт бичгийг нягтлан шалгах

7.1.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн хүсэлт, хавсаргасан баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

7.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 7.1-д заасан баримт бичигт зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгах талаар хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхдээ энэ хуулийн 6.3-т зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

7.4.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт, энэ хуулийн 9.3-т заасан нэрийн санг ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 10

Бүгд: 43

76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, бүртгэхээс татгалзах

8.1.Улсын дээд шүүх энэ хуулийн 6.1, 6.4-т заасан хугацаанд мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргана.

8.2.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хүсэлт гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.3.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхийн Тамгын газар хүсэлт гаргагчид гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгоно. Гэрчилгээ нь цахим хэлбэртэй байж болно.

8.4.Улсын дээд шүүх дараах үндэслэлээр мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхээс татгалзана:

8.4.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

8.4.2.энэ хуулийн 9 дүгээр зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн;

8.4.3.энэ хуулийн 6.3.5-д заасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол.

8.5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг хүртэл мэргэжлийн нэгдсэн холбоо байна.

8.6.Улсын дээд шүүх энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч, улсын бүртгэлийн байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилон ажиллуулж болно.

8.7.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 12

Бүгд: 42

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

10 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гишүүдээс бүрдэнэ.

10.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо мэргэжлийн ангиллаар дагнасан хороотой байж болно.

10.4.Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.5.Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.6.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

“11 дүгээр зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл

11.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодоос бүрдэнэ.

11.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэлийн тоонд хязгаар тогтоохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 15

Бүгд: 43

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

“12 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэг

12.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.гишүүн мэргэжлийн холбоодыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, салбарын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

12.1.2.тухайн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах;

12.1.3.тухайн салбарын хэрэгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнийг олон нийтэд сурталчлах ажиллагаанд гишүүдээ төлөөлөн оролцох, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12.1.4.төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

12.1.5.гишүүн мэргэжлийн холбооны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төрийн аль ч шатны байгууллагад төлөөлөх, өөрийн байр сууриа илэрхийлэх;

12.1.6.тухайн салбарт өндөр технологи, инновацийг хөгжүүлэх, бараа, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12.1.7.салбарын үйлдвэрлэлийн явц, технологийн түвшинг тогтоох, үнэлэх, борлуулалтын зах зээл, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх;

12.1.8.салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

12.1.9.мэргэжлийн үйл ажиллагааны стандарт боловсруулах, нутагшуулахад хамтран ажиллах, хэрэглээний тайлбар зөвлөмж бэлтгэх;

12.1.10.мэргэжлийн нэгдсэн холбооны баримтлах мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

12.1.11.гишүүн мэргэжлийн холбоодыг төлөөлөн гадаад болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

12.1.12.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах, бүх гишүүддээ тайлагнах, аудит хийлгэх, олон нийтэд ил тод, нээлттэй байршуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл.Төрийн байгууллагатай хамтран ажиллах

13.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо төрийн байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллана:

13.1.1.тухайн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стандарт, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, санал, зөвлөмж гаргах;

13.1.2.зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчилж дүгнэлт гаргахад санал өгөх, шаардлагатай тохиолдолд тухайн зөвшөөрлийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээний талаар санал, дүгнэлт гаргах;

13.1.3.хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу шилжүүлэн авах;

13.1.4.тухайн салбарын техникийн нөхцөл, стандартыг боловсруулах, батлах, мөрдүүлэх, хэрэглээний тайлбар, зөвлөмж бэлтгэх;

13.1.5.хуульд заасан тохиолдолд төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

13.1.6.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцох, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

13.1.7.салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтаар суралцагчид эзэмшүүлэх мэргэшлийн түвшинг Хөдөлмөрийн тухай хуулийн 17.2, 17.3-г зааснаар тодорхойлоход оролцох;

13.1.8.хууль болон мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэмд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18

Бүгд: 44

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 23

Бүгд: 45

48.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 45

53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “этгээдэд” гэсний дараа “Эрүүгийн хууль, эсхүл” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 14.1 дэх хэсгийг тус тус нэмэх:

“14.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.1 дэх хэсэг болгох:

“15.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 22
Бүгд: 45
51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Монголбанкны Төлбөр, тооцооны газрын Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал А.Батсайхан,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Т.Доржханд, Г.Дамдинням, Н.Учрал, Ц.Идэрбат, Х.Болорчулуун, Э.Батшугар, М.Оюунчимэг, Х.Ганхуяг, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 43 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхлэв.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “салбарын” гэсний дараа “, авто зам, төмөр замын дэд бүтцийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шууд удирдлага” гэснийг “үйл ажиллагааны удирдлага” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.1, 8.3.1 дэх заалтын “шууд удирдлагыг” гэснийг “үйл ажиллагааны удирдлагыг” гэж тохиолдол бүрд нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Хөгжлийн” гэсний өмнө “Үндэсний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “орон сууц зэрэг суурь хэрэгцээг хангах” гэснийг “орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төрийн сангийн нэгдсэн” гэснийг “Монголбанк дахь төрийн сангийн” гэж өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэд заалтын “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг, мөн 12 дугаар зүйлийн 12.8, 12.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын, авто зам, төмөр замын дэд бүтцийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийн “ордын төрийн эзэмшлийн хувийг” гэснийг “ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “эзэмшлийн” гэснийг “төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

8.1.Сангийн эх үүсвэрийг холбогдох журмын дагуу хуваарилалт хийснээс хойш ажлын таван өдрийн дотор Монголбанк дахь Сангийн дансанд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг, 8.3 дахь хэсгийн, 9¹ дүгээр зүйлийн 9^{1.1} дэх хэсгийн “энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Сангийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 5³ дугаар зүйлийн “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.2-г” гэснийг “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.б-д” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5³ дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “33.2.11” гэснийг “33.2.10” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 33 дугаар зүйлийн 33.2.10 дахь заалтын “33.2.6-д” гэснийг “33.2.6, 33.2.10-д” гэж, мөн зүйлийн 33.2.10 дахь заалтын дугаарыг “33.2.11” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “5.3.27” гэснийг “5.3.26” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт буюу 21.1.16 дахь заалт, 30.14 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчит /өмчийн оролцоотой/” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 30.10.1 дэх заалтын “ашигт малтмалын” гэснийг “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын” гэж өөрчилж, мөн зүйлийн 30.10.2 дахь заалтын “бусад тохиолдолд” гэсний өмнө “энэ хуулийн 30.10.1-д зааснаас” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 14
Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “сангийн” гэсний дараах, мөн зүйлийн “орлого,” гэсний дараах “хөрөнгө оруулалтын орлого” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийн “20-оос” гэснийг “34-өөс” гэж өөрчилж, мөн хэсгийн “эзэмших” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 13

Бүгд: 44

70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5.8 дахь хэсгийн “хуулийн этгээд /төрийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/-ийн” гэснийг “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “гэрээ байгуулсан” гэсний дараа “тохиолдолд тухайн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “5.9.Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан энэ хуулийн 5.7-д заасан хуулийн этгээдийн хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/9 дүгээр зүйлийн 9.1.16, 9.1.17 дахь заалт:

9.1.16.энэ хуулийн 5.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийг удирдах, хуулийн хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхт төлөөлөгчийг томилох;

9.1.17.энэ хуулийн 9.1.16-д заасан бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг энэ хуульд нийцүүлэн батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болох бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 2/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2/8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт:

8.1.7.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох болон ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 3/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

9.1.5.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 13
Бүгд: 44
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 13
Бүгд: 44
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “холбогдуулан” гэсний дараа “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигласны үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр” гэж нэмж, мөн заалтын “2029 оны 1 дүгээр улиралд багтаан” гэснийг төслийн 1 дэх заалтын 1.2 дахь дэд заалтын “боловсруулж,” гэсний дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	30
Татгалзсан:	14
Бүгд:	44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Монгол Улсын иргэн бүрд 2024 оны 2 дугаар улиралд багтаан хуримтлалын нэрийн данс үүсгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	30
Татгалзсан:	15
Бүгд:	45

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Хуримтлалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	17
Бүгд:	45

62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн дансыг Монголбанкна дахь төрийн сангийн дансанд үүсгэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	30
Татгалзсан:	15
Бүгд:	45

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны гишүүн Д.Баатарсайхан, Б.Пүрэвдагва, М.Цэрэнбат, мөн хорооны гишүүн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн Албаны дарга Д.Дуламсүрэн, мөн хорооны Ажлын албаны Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга З.Цэдэнжав, Монгол Улсын Их сургуулийн Нийтийн удирдлагын сургуулийн тэнхимийн ахлах багш Г.Мягмар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт С.Мөнгөнчавхдас нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн тавьсан асуултад Ёс зүйн хорооны гишүүн Д.Дуламсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт Д.Батсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ц.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал С.Цогтсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Д.Тогтохсүрэн, Д.Ганбат, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал, Төсвийн байнгын

хорооны дарга Г.Тэмүүлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг нар хариулж, тайлбар хийв.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Малчин” гэсний дараа “, мал бүхий иргэн /цаашид “малчин” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Д.Ганбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 22
Бүгд: 39
43.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “нөхцөлийг” гэснийг “бодлогын болон эрх зүйн орчныг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.3.бэлчээрийг улирлын онцлогтой уялдуулан ашиглах, хамгаалах, доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх бодлогыг тодорхойлох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “гамшгийн эрсдэлийг урьдчилан тооцох,” гэсний дараа “эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үндэсний чадавхыг бэхжүүлэх,” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг хасаж, 6.1.8 дахь заалтыг 7.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.6.тэжээлийн ургамлын тариалалт, тэжээлийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “төсөв хооронд” гэснийг хасаж, 6.2 дахь хэсгийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон” гэснийг хасаж, дугаарыг 6.3 дахь хэсэг болгон өөрчилж, төсөлд 6.2 дахь хэсэг нэмэх:

“6.2.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “малчдад таниулах, сурталчлах” гэснийг “боловсруулж, батлуулах” гэж, 7.1.4 дэх заалтын “малын үүлдэрээр” гэснийг “бүс нутгийн онцлогт тохирсон, баталгаажсан үүлдэр, омгийн малаар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “нийтлэг стандартыг” гэснийг “талаар байгалийн бүс нутгийн онцлогт тохирсон стандарт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын 9.1.4, 9.1.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.4.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах;

9.1.5.өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “, хяналтыг” гэснийг хасаж, мөн зүйлд дор дурдсан агуулгатай 10.1.5, 10.1.6, 10.1.7 дахь заалт нэмэх:

“10.1.5.өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;

10.1.6.малын гаралтай түүхий эдийн анхан шатын ангилалт, тордолт хийж, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, стандарт техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх;

10.1.7.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталж, үе шаттай хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн Хууль хүчин төгөлдөр болох хугацааг “2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн гарчгийн “Хурлын бүрэн эрх” гэснийг “Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж, 5.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “газрын бүрэн эрх” гэснийг “газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж, 6.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 7.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 8.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 9.1.4 дэх заалтын “малчинд” гэснийг “малчин, мал бүхий иргэнд” гэж өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд болон ажлын хэсгийн гаргасан, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “аж ахуйн нэгж, байгууллагад” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх” гэж, 33.5 дахь хэсэгт “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл” гэж тус тус нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “автомашинь нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэснийг “автомашинь нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13

Бүгд: 39
66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Грандлекс партнерс” ХХК-ийн хуульч Ж.Дамбасүрэн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 12

Бүгд: 39

69.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Арав. *“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, мөн газрын Орон нутаг хариуцсан газрын референт П.Энхсайхан, Хууль, эрх зүйн газрын шинжээч Г.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 17 цаг 47 минутаас хуралдааныг даргалав.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ё.Баатарбилэг, Ж.Сүхбаатар /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 21
Бүгд: 38
44.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 1.1, 1.3 дахь заалтыг нэгтгэн 1.1 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөх:

“1.1 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3 дахь хэсэгт заасан аймаг, сум, дүүрэг /цаашид “нэгж” гэх/-ийг өөрчлөх асуудлыг санаачлах, нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах, иргэдийн санал авах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 2.1.6 дахь дэд заалтын “тухайн орон нутгийн нутаг дэвсгэр (газар, хилийн цэс), хүн ам зүй” гэснийг “өөрчлөлтөд хамрагдах

нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нутаг дэвсгэр, хилийн цэс, хүн ам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 2.1.5 дахь дэд заалтын “зогсоож, өөр нэгжид (аймаг, сум, дүүрэг), нутаг дэвсгэр, захиргааны хувьд харьяалуулахыг” гэснийг “зогсоохыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 2.1.1 дэх дэд заалтын “хуваах” гэсний дараа “, шилжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.5 дахь дэд заалт нэмэх:

“2.1.5.“нэгжийг шилжүүлэх” гэж тухайн нэгжийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөхийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 3.1.1 дэх дэд заалтын “газар зүй” гэснийг “газар зүйн онцлог, орон зайн байршил,” гэж, 3.1.2 дахь заалтын “дэвсгэрийн хувьд” гэснийг “дэвсгэр” гэж, 3.1.4 дэх дэд заалтын “нутгийн” гэснийг “орон нутгийн” гэж, 3.1.5 дахь дэд заалтын “угсаатан зүй” гэснийг “угсаатны онцлог” гэж, 3.1.6 дахь дэд заалтын “ашиг, өгөөжтэй” гэснийг “ашигтай” гэж тус тус өөрчилж, 3.1.6 дахь дэд заалтын “эдийн засгийн” гэсний өмнө “нийгэм,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 3.1.3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 4.1, 4.2 дахь заалт нэмэх:

“4.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.2-т заасны дагуу аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна.

4.2.Нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага өөрчлөлтөд хамрагдах нэгжид нэгжийн Засаг даргын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг боловсруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.4 дэх заалт болох:

“4.4.Ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдээллийг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 4.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 4.1.3 дахь дэд заалтын “хөдөлгөөнийг” гэснийг “хөдөлгөөний хандлагыг” гэж, 4.1.5 дахь дэд заалтын “төрийн” гэснийг “иргэдэд зориулсан төрийн” гэж, мөн дэд заалтын “үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй” гэснийг “үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх түвшнээс дээшилсэн” гэж тус тус өөрчилж, 4.1 дэх хэсгийн “Засгийн газар, түүний харьяа яам, агентлаг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 29
Бүгд: 37
48.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 5.1 дэх заалтын “үнэлгээ” гэснийг “шинжилгээ” гэж, 5.3 дахь заалтын “дүүргийн хувьд” гэснийг “дүүргийг” гэж, мөн заалтын “аймгийн хувьд” гэснийг “аймгийг” гэж, 5.4 дэх заалтын “асуудлын талаар иргэдээс өөрчлөлтийг “дэмжиж байна”, “дэмжихгүй гэсэн томъёоллоор санал” гэснийг “асуудлаар иргэдийн саналыг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан саналын хуудсаар” гэж, 5.5 дахь заалтын “сонгуулийн насны иргэдийн олонх оролцсон бол санал авах ажлын дүнг” гэснийг “сонгуулийн эрх бүхий иргэд оролцох бөгөөд олонх нь оролцсон бол санал хураалтыг” гэж, 5.10 дахь заалтын “санал хураалтын нэгдсэн дүнг санал хураалтаас хойш” гэснийг “санал хураалт дууссаны дараа саналын хуудсыг тоолж, дүнг” гэж, 5.11 дэх заалтын “5” гэснийг “3” гэж тус тус өөрчилж, 5.10 дахь заалтын “нэгдсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 5.4, 5.5 дахь заалт нэмэх:

“5.4.Аймгийг өөрчлөх асуудлаар Засгийн газар, сум, дүүргийг өөрчлөх асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.

5.5.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгжийг өөрчлөх асуудлаар урьдчилан тогтоосон байранд битүүмжилсэн саналын хайрцаг ашиглан нууц санал хураалт явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 5.3 дахь заалтын “арга хэмжээг” гэсний дараа “энэ журмын 4.2-т заасан ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулан хүлээлгэн өгснөөс хойш” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 5.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Өөрчлөлтөд хоёр ба түүнээс олон нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хавсралтын 5.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын 1.4 дэх мөрний “асуудал” гэсний дараа “/өөрчлөх болсон үндэслэл, шалтгаан/” гэж, 1.5 дахь мөрний “хуваах” гэсний дараа “шилжүүлэх” гэж, 3.1 дэх мөрний “Хучилттай” гэсний өмнө “Хатуу” гэж, 4.2 дахь мөрний “Боловсрол” гэсний дараа “Мэргэжлийн сургалтын байгууллагын тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийн “ТАЛААРХ” гэснийг “ТӨСЛИЙН” гэж, 1.1 дэх мөрний “Харьяалал /аймаг, сум, нийслэл, дүүрэг/” гэснийг “Нэгжийн харьяалал /аймаг, дүүрэг/ гэж, 1.2 дахь мөрний “Тухайн нэгж” гэснийг “Нэгжийн нэр” гэж тус тус өөрчилж, 2.1 дэх мөрний “/2010, 2020 он/” гэснийг, тайлбар хэсгийн “агентлаг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20. Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын “...аймгийн ... сумыг /дүүрэг/” гэснийг “... засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21. Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын “хуваах” гэсний дараа “шилжүүлэх” гэж тохиолдол бүрд нэмж, “татан буулгах” гэснийг тохиолдол бүрд хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан учир санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын саналыг дэмжсэнээр тооцож, 54.1 хувийн саналаар дэмжигдсэнд тооцов.

22. Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн болон хавсралтын талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалт, дэд заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулгыг алдагдуулахгүйгээр хүснэгтийн загварыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 03 минут үргэлжилж, 72 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 68.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 оны 04 дугаар сарын 18-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 15 минут

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданишатар: Өглөөний амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Энэ бол асуулт, хариулт явагдаад зөвхөн санал хураалт үлдчихсэн. Өнгөрсөн 7 хоногт хэлэлцээд 5 дахь өдөр бол санал хураалтыг үлдээсэн байгаа. Үргэлжлүүлж хэлэлцэнэ. Тийм учраас эхэнд хэлэлцэж байна.

2 дугаарт, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

3 дугаарт, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална.

4 дүгээрт, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. /Зарчмын зөрүүтэй 15 саналтай/.

5. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

6-д, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /зарчмын зөрүүтэй 1 саналтай/.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

10 дугаарт, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

11 дүгээрт, “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж 2 гишүүн үг хэлэхээр саналаа ирүүлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт үг хэлнэ ээ.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Үндэсний баялгийн сангийн тухай хууль Монгол Улсын Их Хуралд хэлэлцэж байгаа. Өнөөдөр анхны хэлэлцүүлэг хийгдэнэ.

Тэгээд 2019 онд Үндсэн хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулсан гол нэг нөхцөл, гол ард түмний хүсэн хүлээсэн шийдэгдсэн асуудал энэ байсан. Байгалийн баялгийн өгөөжийг Монголын ард түмэнд тэгш иударга хүртэх эрхтэй. Цөөхөн хүн хүртдэг биш Монгол Улсын 3 сая иргэн 3 саяулаа хүртэх

боломжийг бид нар Үндсэн хуулийнх нь нэмэлт, өөрчлөлтөөр нээж өгсөн. Ингээд Үндэсний баялгийн сан байгуулна. Иргэн болгондоо байгалийн баялгийн өгөөжөөс тэгш шударга хүртээнэ гэж оруулсан. Үүний дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хууль орж ирж байгаа. Монгол Улсын Засгийн газар өргөн мэдүүлсэн. Бид одоо бас яаралтай горимоор хэлэлцэж байна.

Гэтэл Засгийн газрын өргөн мэдүүлсэн төслөөс ангид тэс хөндлөн ийм заалтыг бас ажлын хэсэг оруулж ирж байна. Өөрөөр хэлэх юм бол хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй, хуулийн төслийн үйлчлэх хүрээнээс хальж хэтэрсэн, хамрах харилцаанаас бүр одоо халиад явчихсан ийм заалтыг оруулж ирээд үндсэндээ өөрөөр хэлэх юм бол нөгөө хуулийг гууль болгох гэж байна. Бидний одоо хурдан хугацаанд Үндэсний баялгийн санг байгуулмаар байна. Үндэсний Баялгийн сангаасаа байгалийн баялаг, стратегийн ордуудаа Үндэсний баялгийн сандаа хамруулж уул уурхайн орлогоосоо Монгол Улсын иргэн болгон “Эрдэнэс Тавантолгой”-н ноогдол ашиг иргэн болгон 350 мянга авч байгаатайгаа адилхан хүртмээр байна. Ганцхан “Эрдэнэс Тавантолгой” биш олон стратегийн том ордуудаас Монголчууд хүртмээр байгаа. Энэ зорилгоор л энэ хуулийг бид нар оруулж ирж байгаа.

Гэтэл энэ хуулийн зарим заалт нь тэс хөндлөн болчихсон. Нөгөө нуухыг нь авах гээд нүдийг нь сохолж байна л даа. Өөрөөр хэлэх юм бол байгалийн баялгийн өгөөж стратегийн ордуудаас гадна төмөр зам, авто замын одоо төрийн өмчит компаниудын орлогыг нь төвлөрүүлнэ. Тэр удирдлага зохион байгуулалтыг нь тэр “Эрдэнэс Монгол” компани хангана гэдэг заалт тусчихсан. Ийм байдлаар Тогтохсүрэн дарга аа, би нэг үг хэлчихье тэгэх үү.

Ийм одоо чухал хуульдаа бид нар бас хариуцлага хандмаар байна л даа. Тэгээд л одоо хоорондоо ингээд л. Яах гэж байгаа юм. Одоо тэр АЗЗА

компанийг авч яах гээд байгаа юм. Энэ чинь зам засдаг компани. Орлого олдог компани биш. Ард иргэдийн цасыг нь цэвэрлэдэг, замынх нь цоорхойг, нөхөөсийг бөглөдөг, иргэдийг аюулгүй замаар зорчих бололцоо боломжийг бүрдүүлдэг компани. Тэр Гашуунсухайтын замыг өнөөдөр “Эрдэнэс Монгол” компани эзэмшдэг. Өдөртөө мянган машин явдаг. 540 мянган төгрөгийн хураамж төлдөг. Замын хураамж гэж. Өдөртөө 540 сая, жилдээ 350 тэрбум төгрөгийн орлого олдог. Тэгсэн мөртөө замаа засдаггүй. “Эрдэнэс Монгол” компани хэдэн ажилчдын цалинг л тавьдаг. Энэ компанийг авч үлдэж хэдэн саяар нь цалин авахын тулд ингэх гээд байгаа юм уу. Замаа засаж чаддаггүй шүү дээ. “Эрдэнэс Монгол” бөөн осол гарч байдаг шүү дээ. Жолооч, тээвэрчид амь насаа алдаж байдаг шүү дээ. Ерөөсөө нүдээ аньчихсан суудаг шүү дээ. Тэгчхээд одоо бүх замуудыг авч яах гээд байгаа юм. Бүх төмөр замыг авч яах гээд байгаа юм.

Дээрээс нь Улаанбаатар Төмөр зам Монголын тал 50 хувь эзэмшдэг. Улаанбаатар Төмөр замыг авч чадахгүй байгаа биз дээ. Түүний орлогыг авах уу. Энэ төмөр замын компаниуд гээд. Ийм байдлаар бас асуудал оруулж ирмээргүй л байна л даа. Урьд нь одоо “Си” зөвшөөрлийн асуудал ярьсан бас. Ерөөсөө л АТҮТ дээр байхад болохгүй байна авлига аваад байна гэсэн. Уул уурхайн компаниуд авсан. Өнөөдөр “Си” зөвшөөрлийн авлига урьд нь 1, 2 сая гэж яригддаг байсан бол одоо 20-30 сая болсон. 20-30 сая. Би бас энэ Их Хурлын индэр дээрээс шүгэл үлээж байна. Энэ 20-30 саяын авлига уул уурхайн компаниуд дээр “Си” зөвшөөрөл өгдөг болсноос хойш бий болсон. Бий болсон. Өмнө ч би бас шүгэл үлээж байсан. Төмөр зам дээр Халтар сайд аа нэг вагон тавихад 500 сая авлига аваад байна шүү гэж сайд биш, гишүүн байхдаа би шүгэл үлээж байсан. Үнэхээр тийм байсан. Батдөл баригдсан. Нүүрсний хулгай байна шүү гэж Хууль зүйн байнгын хорооны дарга байхдаа шүгэл үлээж

байсан. 2 сая тонн нүүрс хилээр нууцаар гарчихсан байна шүү гэж. Өнөөдөр нүүрсний хулгай ямар байсныг бүх ард түмэн бүгд мэддэг болсон. Үүнтэй адилхан “Си” зөвшөөрлийн 20-30 саяын шүглийг хүлээж байна. Үүн дээр ажлын хэсэг гарч ажиллах ёстой. Тээврийг нь аваад ийм болчихсон. Одоо авто замыг нь аваад яах юм. АЗЗА-ууд замаа засаж чадахаа болино. АЗЗА орлого олдог компани биш. Ард иргэдийг хурдан шуурхай, аваар осолгүй зорчих бололцоог бүрдүүлэх ийм зорилготой компани. Гэтэл түүнийг авна гэгчихсэн. Төмөр замуудыг авна гэгчихсэн. Одоо энэ ЗТЯамыг нэртэйгээр нь татан буулгах. Ганцхан Зам тээврийн яам биш Агаарын тээврийн яам болгочих. Ийм байдлаар одоо бид байгалийн баялгийн өгөөжийг ард иргэддээ хүртээе, стратегийн ордуудыг эзэмшье. Төр эзэмшье. Тэгээд эндээсээ ард иргэддээ бас хувь хишиг хүртээе. Ноогдол ашиг өгдөг болгоё, хувьцаа эзэмшүүлье гэсэн энэ том бодлого, том зорилгыг гацаах гэсэн, унагаах гэсэн тийм чононд хонины арьс нөмрүүлсэн ийм байдлаар бас ажлын хэсэг ажиллаж болохгүй. Энийгээ бас анхаарах ёстой. Энийг өнөөдөр бас гишүүд бас анхаар.../минут дуусав/

Г.Занданиатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Би хөдөөгүүр иргэдтэй маш их олон уулзалт хийсэн. Тэр уулзалт дээр гарч байсан гол асуудал бол 1072 хувьцааны ноогдол ашигийг өгч байна. Энэ бол сайн байна. Тэгэхдээ маш их олон хүмүүс хохирч үлдэж, 1072 хувьцаандаа ноогдол ашиг авч чадахгүй байна гэж ярьж байна. Тэгэхээр ахмадууд гэхэд 322,767 хүн гарсан. Өчигдөр би тэгээд энэ асуудлаар энэ хүмүүсийн ноогдол ашигийг буцааж, хувьцааг буцааж өгөх талаар би Байнгын хороо дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан юм. Монгол Улсын иргэдийн эзэмшиж байсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаанаас хасагдсан, суутгагдсан хувьцааг тухайн иргэн хүсвэл 1072 хүртэлх нэгж хувьцааг 933

төгрөгөөр буцаан худалдан авах арга хэмжээг 2026 оны 12 сарын 31-ийг дуустал хэрэгжүүлнэ гэдэг ийм санал гаргасан боловч харамсалтай нь Байнгын хороо санал хураалгаж өгсөнгүй.

Гэхдээ ер нь бол энэ 1072 хувьцаагаа сая төгрөгөөр өгчихсөн олон ахмадууд байгаа юм. 322,767 ахмад байна. Энэ хүмүүс ерөөсөө ямар ч мэдээлэлгүй байсан. Дээрээс нь учрыг нь олохгүй энэ нөгөө нэг баярын амласан 1 сая төгрөг өгч байгаа юм болов уу, зарим нь сонгуулийн мөнгө өгч байгаа юм болов уу гээд ингээд л авцаачихсан ахмадууд маш их байна. Дээрээс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1721 байна. Эрүүл мэндийн даатгал би огт сонирхоогүй байж байхад ЭМД-ын төлбөр гээд Засгийн газрын тогтоолоор баахан юм аваад явчихсан байж. Оюутнууд мөнгөгүй юм чинь яадаг юм 500 мянган төгрөг өгсөн байна лээ. Тэнд 133,819 мянган оюутан байна. ЭМДаатгалд 615 мянга. Сайн хувьцаа нэрээр 1 сая 295 мянган хүнд өгсөн байна. Тэгээд энэ хүмүүс чинь ерөөсөө учраа ололгүй байж байгаад ингээд хувьцаагаа суутгуулчихсан ийм нөхцөл гарч ирж байгаа.

Тэгэхээр ер нь иргэд бол ихэнхдээ бүгдээрээ асууж байгаа нь бид нар бол 1 сая төгрөгөө авсан. Ахмадууд бол голцуу асууж байна. Бид нар 1 сая төгрөгөө авсан. Одоо буцаагаад сая төгрөгөө төлөөд тэр 1072 хувьцаагаа авъя. Тэгээд бид нар энэ өнгөрсөн ноогдол ашиг энэ тэр яах вэ, ирээдүйн ноогдол ашиг энэ тэрээ аваад явъя гэдэг ийм саналыг хөдөөгүүр явж байхад маш их гаргаж байна. Тэгээд ер нь бол энэ бол зөв зүйл. Яагаад гэвэл төрөөс хүчээр энэ асуудлыг шийдсэн ийм тохиолдол байгаа. Жишээ нь хамгийн их хохирсон иргэд бол Дархан, Завхан аймгийн иргэд байна. Яагаад гэвэл тухайн үед Сангийн сайд байсан Хаянхярваа өөрийнхөө тойргийн болон өөрийнхөө аймгийнхаа хүмүүст хамгийн их сая төгрөгийг нь тараасан байх жишээтэй. Үүнээс болоод өнөөдөр тэр хүмүүс хохирчихсон байж байна. Тэр

хүмүүс бид нар 1 сая төгрөгөө авсан. Одоо ярих тэр сая төгрөгийг нь буцааж өгөөд, буцаагаад тэр 1072 хувьцааныхаа эзэн болчихъё. Тэгээд энэ нь бол тухайн компани ч гэсэн орлого орно. Тухайн компанидаа ч ашигтай, иргэндээ ч ашигтай. Дээрээс нь төсвөөс ямарваа нэгэн төлбөр мөнгө гарахгүй ийм л зүйл болж байгаа. Ингэсний үр дүнд иргэн өөрөө л хүснэ шүү дээ. Хүсэхгүй бол тэгээд тэр хувьцаа нь төрдөө үлдэж, хэвээрээ байж байх боломжтой. Тэгэхээр ийм байдлаар бас тодорхой асуудлыг шийдвэрлэхгүй бол ерөөсөө болохгүй байна.

Ер нь бол 2022, 2023 оны ноогдол ашигийг энэ жил тараасан. Тэндээ 380 орчим мянган төгрөг тарааж байх шиг байна лээ. 280 мянга орчим. Гэтэл энэ 2020, 2021 оны ашгууд яагаад тараагдахгүй байгаа юм. Энэ чинь нэгэнд нь 180 тэрбум, нөгөөдхөд нь 200 гаруй тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Энэ ноогдол ашгуудаа яагаад тараахгүй байгаа юм. Тэгээд зарим хүмүүс бол ноогдол ашгаараа олон юм хийж бүтээх байсан, иргэдэд мөнгө тараалаа гэж ярьж байгаа юм. Энийг бол ингэж ярьж байгаа нь буруу гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл иргэдэд хувьцаа тараагаад өгчихсөн бол тэр ноогдол ашгаа авах ёстой. Иргэдийн эрх нь байгаа. Тэр том том бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлыг хиймээр байгаа бол “Эрдэнэс Тавантолгой” нь өөрөө тэндээсээ том мега төслүүдийг санхүүжүүлэх боломжтой шүү дээ. Засаг тэндээс санхүүжүүлэх боломжтой. Тэгээд харамсалтай нь санхүүжүүлж байгаа юм нь дандаа мухар төмөр зам, оффтейк гэрээнүүд. Тэр нь хэд дахин даблдсан үнэтэй ийм зүйлийг хийж байгаа нь маш хариуцлагагүй байна.

Тийм учраас энэ “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг иргэдэд бүгдэд нь олгоод, дээрээс нь иргэдийн төлөөллийг тэнд заавал оролцуулж байж 21 аймаг, 9 дүүрэгтээ тэндээс 1, 1 ТҮЗ-ийн гишүүнийг томилдог болгож,

тэндээсээ хамгийн сайн менежерүүдийг томилох замаар энэ компанийг ашигтай ажиллуулах ийм шаардлага гарч ирж байгаа. Тийм учраас 1072 хувьцааг заавал өг гэж шаардаж байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ 1072 хувьцааны асуудлаар би нэг тодорхой чиглэл өгсөн байгаа. Тэрийг хууль дээр танилцуулъя.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 25 санал байгаа. Санал хураалтад бэлдэнэ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналууд байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага, мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Нямаагийн Энхболд /цаашид “ажлын хэсэг” гэж/ явна. Санал хураалт. Булгантуяа, Идэрбат гишүүд санал хураалт.

Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулъя. Доржханд гишүүн ээ, Доржханд

гишүүн нааш ир дээ. Одоо санал хураалт явуулна. Доржханд гишүүн ээ нааш ир дээ. Сая бүртгэлийн санал хураалт явсан. Саяын ажлын хэсгийн саналаар санал хураалт явууллаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Байнгын хорооны саналыг. 28 гишүүн дэмжиж 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбарын мэргэжлийн нэгдсэн холбоонд энэ хууль үйлчилнэ.

3.2.Мэргэжлийн холбоо болон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

3.3.Энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 27 гишүүн дэмжиж 64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“мэргэжлийн холбоо” гэж салбар, эсхүл мэргэжлийн эрх ашгийг хамгаалах зорилгоор аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, тухайн салбарын мэргэжсэн хүнээс бүрдсэн гишүүнчлэл бүхий холбоог;

4.1.2.“мэргэжлийн нэгдсэн холбоо” гэж тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын гишүүнчлэлтэй, салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий холбоог.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 76.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “Мэргэжлийн нэгдсэн холбооны тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүрэг” гэснийг “Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах, түүнд тавигдах шаардлага

5.1.Мэргэжлийн нэгдсэн холбоог тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоод хамтран үүсгэн байгуулна.

5.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

5.2.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийг батлах;

5.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох;

5.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг батлах;

5.2.4.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.

5.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах шаардлагыг хангасан байна:

5.3.1.тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй байх;

5.3.2.энэ хуулийн 5.3.1-д заасан гишүүд нь тухайн салбарын зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын тавиас дээш хувийг эзэлдэг байх. 50-аас дээш юм уу. Энийг найруулга дээрээ 50 хувиас дээш гэж, 50

хувиас дээш эзэлдэг байх гэж найруулахгүй бол 50-аас дээш гэдэг чинь.

5.4.Тухайн салбарын мэргэжлийн холбоо дангаар, эсхүл олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй бол энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн бүртгүүлж, мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт

6.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

6.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг Улсын дээд шүүхийн баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд уг холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурна:

6.2.1.хүсэлт гаргасан он, сар, өдөр;

6.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны нэр;

6.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны хаяг;

6.2.4.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээлэл.

6.3.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

6.3.1.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл, уг шийдвэр болон хурлын тэмдэглэлд ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан байна;

6.3.2.мэргэжлийн нэгдсэн холбооны бүтэн болон товчилсон нэр;

6.3.3.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм;

6.3.4.мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдийн бүртгэл, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.3.5.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан гишүүнчлэл, зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтыг нотолсон баримт бичиг;

6.3.6.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

6.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 6.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг энэ хуулийн 6.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт, баримт бичгийг нягтлан шалгах

7.1.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн хүсэлт, хавсаргасан баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

7.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 7.1-д заасан баримт бичигт зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгах талаар хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхдээ энэ хуулийн 6.3-т

зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

7.4. Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт, энэ хуулийн 9.3-т заасан нэрийн санг ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, бүртгэхээс татгалзах

8.1. Улсын дээд шүүх энэ хуулийн 6.1, 6.4-т заасан хугацаанд мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргана.

8.2. Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хүсэлт гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.3. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхийн Тамгын газар хүсэлт гаргагчид гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгоно. Гэрчилгээ нь цахим хэлбэртэй байж болно.

8.4. Улсын дээд шүүх дараах үндэслэлээр мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхээс татгалзана:

8.4.1. мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

8.4.2. энэ хуулийн 9 дүгээр зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн;

8.4.3. энэ хуулийн 6.3.5-д заасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол.

8.5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг хүртэл мэргэжлийн нэгдсэн холбоо байна.

8.6. Улсын дээд шүүх энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч, улсын бүртгэлийн байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилон ажиллуулж болно.

8.7. Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

10 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гишүүдээс бүрдэнэ.

10.2. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахтай

холбогдсон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо мэргэжлийн ангиллаар дагнасан хороотой байж болно.

10.4.Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.5.Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.6.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

Н.Энхболд: Баярлалаа. Бид нарыг энэ ажлын хэсэг бэлдэж байх хооронд Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо гээд нэг байгууллагаас саналууд ирсэн юм. Энэ дотор хэд хэдэн санал байна лээ. Тэгэхдээ 1 зүйлийг одоо эцсийн хэлэлцүүлгийн өмнө анхаарах боломж байна уу, үгүй юу. Бодмоор санал байна лээ. Энэ дээр нөгөө Их Хурлаасаа сонгогдчихсон удирдлага, тэр удирдах зөвлөл, байгууллага нь ашиг сонирхлын зөрчилтэй ямар нэгэн шийдвэр гаргаад эс үгүй бол тэр бүрэлдэхүүнд орсон хүмүүс нь тухай тухайн төлөөлж ирсэн байгууллагуудынхаа эрх ашгийн үүднээс хандаад бусдыг хавчих, шахах, хууль бус шаардлага хүлээх зэргээр үйл ажиллагаа яваад байвал тэрийг нь бас тодорхой хэмжээгээр зохицуулж байх нэг заалт энэ дотор байх хэрэгтэйг санасан. Тэгэхгүй бол дараагийн Их Хурал хүртэл нь нэг тийм ажиллагаа яваад байвал энэ мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулсны төр засагтай хамтарч ажиллах ач холбогдлын тал дээр нь буруу зөрүү юм гараад байх вий дээ л гэж бодогдсон. Тэгэхээр энийг би энэ ажлын хэсэг эцсийн хэлэлцүүлэгт бэлдэхдээ бас нэг хараад үзчихээрэй гэсэн санал оруулж байгаа

юм. Та нэг чиглэл өгчихвөл гэж бодож энэ саналыг хэлж байгаа юм.

Г.Занданшатар: Эцсийн хэлэлцүүлэг дээр Баттөмөр гишүүн энийг гүйцээн боловсруулах уу. Энэ саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Тэр холбоодын саналыг.

9.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

“11 дүгээр зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл

11.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодоос бүрдэнэ.

11.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэлийн тоонд хязгаар тогтоохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12. Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

“12 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэг

12.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.гишүүн мэргэжлийн холбоодыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, салбарын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

12.1.2.тухайн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах;

12.1.3. тухайн салбарын хэрэгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнийг олон нийтэд сурталчлах ажиллагаанд гишүүдээ төлөөлөн оролцох, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12.1.4. төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

12.1.5. гишүүн мэргэжлийн холбооны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төрийн аль ч шатны байгууллагад төлөөлөх, өөрийн байр сууриа илэрхийлэх;

12.1.6. тухайн салбарт өндөр технологи, инновацийг хөгжүүлэх, бараа, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12.1.7. салбарын үйлдвэрлэлийн явц, технологийн түвшинг тогтоох, үнэлэх, борлуулалтын зах зээл, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх;

12.1.8. салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

12.1.9. мэргэжлийн үйл ажиллагааны стандарт боловсруулах, нутагшуулахад хамтран ажиллах, хэрэглээний тайлбар зөвлөмж бэлтгэх;

12.1.10. мэргэжлийн нэгдсэн холбооны баримтлах мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

12.1.11. гишүүн мэргэжлийн холбоодыг төлөөлөн гадаад болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

12.1.12. санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах, бүх гишүүддээ тайлагнах, аудит хийлгэх,

олон нийтэд ил тод, нээлттэй байршуулах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Учрал гишүүн үг хэлнэ. Ням-Осорын Учрал гишүүн. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: 2019 онд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хуулийг өргөн барьж байсан. Ингээд одоо бол бараг 5 жилийн дараа хэлэлцэж байна. Тэгээд Баттөмөр гишүүн бас ажлын хэсгийг ахлаад энэ хуулийг бол нэлээн боловсронгуй болгож бас өнөөдөр анхны хэлэлцүүлэг хийж байгаад би баяртай байна.

Нэг үндэслэлийг бас хэлье. Манай Улсын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 460 гаруй хуулиас нийт 44 хуульд мэргэжлийн холбоо гэдэг үг орсон. Нэг ёсондоо төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлнэ гэж. Гэсэн хэдий ч өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аль ч хуульд мэргэжлийн холбоо гэж юу вэ гэдгийг томъёолоогүй. Дээрээс нь мэргэжлийн холбооны чиг үүргийг бас томъёолоогүй. Тэгэхээр энэ хуулиар мэргэжлийн холбооны чиг үүргүүдийг яг энэ олон улсын сайн харьцуулалтуудыг хийгээд ингээд чиг үүргүүдийг нь тодорхой болгож байгаа нь маш сайн дэвшил гэж бодож байна. Зүгээр маш энгийн жишээ хэлэхэд сая хэд хоног эмийн сонсгол явагдлаа. Эмийн сонсгол дээр харж байхад жишээ нь тэр АТГ-ын комиссоор бол хэлж байна. Тэр эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүмүүс бүгдээрээ бизнесийн эрх ашигтай гээд: Өнөөдөр энэ орж ирж байгаа 4, 5 мянган эмийг Эрүүл мэндийн яамны 3, 4 мэргэжилтэн, эмийн агентлаг дээр байгаа хэдэн мэргэжилтэн судлаад шинжлээд дүгнэлт гаргана гэвэл тэр боломжгүй юм байна. Тэгээд тэнд ажиллаж байгаа хүмүүс нь бизнесийн ашиг сонирхлын зөрчилтэйгөө хуулийн байгууллага хэлээд байхад тухайн хүмүүсээр нь энэ 4, 5 мянган эмийг

судлаад тодорхой болгооч ээ гэж ингэж шаардлага тавих бол маш хэцүү.

Тийм учраас энэ ажлыг бол цаашидаа мэргэжлийн холбооны хууль гарснаараа эрүүл мэндийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулагдаад, тэгээд тус холбоо өөрөө тэр тусгай зөвшөөрлүүдийг олгодог, тэр зөвшөөрлийг нь олгодог, тэр судалгаануудыг хийдэг, хуулийн төсөл дээр ажилладаг асуудлуудыг өөрсдөө ингээд авч хэлэлцэх бололцоо бол бүрдэж байгаа юм. Дээрээс нь одоо жишээ нь энэ Улаанбаатар хотод гэхэд л төрийн байгууллагууд энэ хувийн байгууллагууд дээр маш олон шалгалт шүүлэг хийдэг. Тэгээд зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн хууль гэж байхад түүнийг бас барьдаггүй. Тийм ч учраас энэ мэргэжлийн холбоонуудыг нь байгуулаад, тэр мэргэжлийн холбоо нь өөрөө зарим чиг үүргээ хэрэгжүүлдэг болох юм бол энэ улс төржилтөөс бол холдоно гэж ингэж л ойлгоод байгаа юм.

Одоо жишээ нь сонгодог мэргэжлийн холбоо бол Хуульчдын холбоо байна. Өмгөөлөгчдийн холбоо байна. Барилгын салбарт Барилгын хөгжлийн ассоциаци тусгай зөвшөөрлүүдийг олгоод л явж байна. Тэгээд хурлаа хийгээд дундаасаа ерөнхийлөгчөө сонгоод, хяналтын зөвлөлөө байгуулаад ингээд хаана хаанаа хариуцлагатай ажилладаг. Тэгээд төрд ч гэсэн салбарын сайн мэргэжилтэн экспертүүд орж ирж ажиллахаар шууд ажилд авахад маш их бэрхшээлтэй байдаг. Мэргэжлийн холбоо байгуулагдсанаар бол мэргэжлийн холбоонд гадна, дотно төгссөн тухайн салбарт ажиллаж байсан тэр мэргэжлийн экспертүүдийг оруулаад, тухайн тэр мэргэжлийн холбоонд зарим чиг үүргээ өгөөд ингээд явах нөхцөл бололцоо бол бүрдэнэ гэж бид бол харж байгаа. Тийм учраас мэргэжлийн холбооны хууль бол салбар болгонд шинжлэх ухаанч хөгжлийг авчрах нь байна.

2-т бол авлига, ашиг сонирхлоос хол ажиллах бололцоог бүрдүүлэх нь байна. Салбарт мэргэжлийн экспертүүдийн санал, дүгнэлтийг тусгаснаар төрийн шийдвэр гаргалт өөрөө амьдрал дээр байгаа болоход ийм бололцоотой болж байгаа учраас энэ мэргэжлийн холбооны хууль бол нэлээд чамбай боловсруулагджээ. Тэгээд Баттөмөр гишүүн, Мөнх-Оргил гишүүн нарын ажлын хэсэгт бас талархаж байна.

Г.Занданшатар: Энх-Амгалан гишүүн. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хууль гарч байна. Энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны хууль гарах нь бол зөв зүйтэй. Энийг бол хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Сая бид нар Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэгтэй холбоотой асуудлыг Их Хурлын дарга уншаад танилцуулчихлаа. Энэ дээр нэг хэдэн ийм юм байгаа юм.

12.1.3 дээр та нар тухайн салбарынхаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд сурталчлах, хэрэгжилтийг нь зохион байгуулах ийм ажлыг хариуцна гэж байгаа юм. Энэ нэг ёсондоо төрийн чиг үүргийг хийх гээд байна л даа. Тэгээд бодлогыг боловсруулж гаргана гэдэг ийм юм ярих гээд байна. Тэгээд нөгөө хууль боловсруулах энэ юм чинь тэгээд Их Хуралд хадгалагдах уу, холбоонд хадгалагдах уу гэдэг асуудал цаашидаа яригдана. Төрийн байгууллагын зарим чиг үүргийг биелүүлнэ, хэрэгжүүлнэ. Салбарынхаа үйлдвэрлэлийн явц, технологийн түвшинийг тогтооно, үнэлнэ. Борлуулалтын зах зээлээ тодорхойлно. Бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварын үнэлгээ өгнө гэхээр нөгөө нэг үнэ тогтоодог юм та нар дээр явчих гээд байна шүү дээ. Тэгээд л тэдээр зарна, эдээр зарна, мэргэжлийн холбоо тэгж үзсэн гээд л ингээд л хэвтчихвэл нөгөө бензиний үнэ буудаггүй гэдэг шиг, гурилын үнэ буудаггүй гэдэг

шиг нэг ийм юмыг мэргэжлийн холбоо шийдвэрээ гаргаад удирдах зөвлөлөөрөө шийдчихсэн, манайх ингээж зарах ёстой, тэгж үнэлэх ёстой гээд яваад өгөх вий дээ. Энийг бас нэг анхаараарай.

Мэргэжлийн үйл ажиллагааны стандарт боловсруулна, нутагшуулна. Хэрэглээний тайлбар зөвлөмж гаргана гэдэг ийм юм явж байна. Энэ нөгөө стандарт боловсруулдаг юм чинь бол нь бол Стандарт, хэмжилзүйн газар төрийн байгууллагад л байсан санагдах юм. Одоо тэгээд бид нар ийм стандартаар үйлдвэрлэнэ гэдэг юмыг холбоо шийдээд эхэлбэл энэ маань эрх зүйн чадамжийн хувьд ер нь хэр болох юм. Тэрийг хэр биелүүлэх юм бол доо. Би бол тэр дээр бас жоохон эргэлзэж л байна.

Гишүүн байгууллагууд мэргэжлийн холбоогоо төлөөлж Олон Улсын байгууллага гадаадын байгууллагуудтай хамтран ажиллана. Гэрээ хэлэлцээр байгуулах юм руу л орох юм байна л даа. Тэгэхээр энэ асуудал өөрөө тэгээд нөгөө гадаад харилцааны нэгдсэн бодлогынхоо хүрээнд бас яаж явах юм бол. Ийм нэг хэдэн асуудал дээр та хэд маань ажлын хэсэг дээрээ дахиж ярьж нэг анхаараарай. Нөгөө төрийн чиг үүргээ тэр чигт нь буулгаад авчихдаг. Тэгээд сүүлд нь нөгөөдхөө засаж болдоггүй, яаж ч болдоггүй тэгээд мэргэжлийн холбоо ингээж үзсэн юм гээд үнэ нь ч буудаггүй тогтчихдог ийм рүү орчих вий дээ гэж би бас жоохон санаа зовж байгаа юм. Энэ дээр та бүхэн анхаараарай гэж хүсэж байна.

Г.Занданишатар: Ням-Осорын Учрал гишүүн, хууль санаачлагч үг хэлсэн Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн үг хэллээ. Энэ хуулийг Ням-Осорын Учрал гишүүн санаачилсан. Энэ Ажил олгогч эздийн холбооны манай Ганбаатар гуай ажлын хэсэг дээр их сайн ажиллацгаасан. Тэгээд энэ яг заалт дээр нэг юм анхаараад дэмжихийг хичээгээрэй. Энэ холбооны хуулийн чинь бас нэг ач холбогдол нь байна шүү дээ.

Ерөөсөө салбар, мэргэжлийн холбоогоо төлөөлж, төрийн бүх үйл ажиллагаа болон бүх үйл ажиллагаанд оролцоход л чиглэж байгаа юм. Зохион байгуулалттай. Төр засаг, Улсын Их Хурал бол хувийн хэвшилээ сонсдоггүй биш сонсдог. Тэгэхдээ нэгдсэн дуу холбоо бодлого дутагддаг. Энийг л нэгтгэж байгаа юм. Тэгээд энэ боловсролын хуульд ч гэсэн суулгасан юм уг нь. Нөгөө дөрвөлсөн холбоо /quadruple helics/ энэ тэр гээд байгаа. Тэр чинь ажил олгогчдын холбоо. Жишээлбэл юу байдаг юм. Инженерүүдийн холбоо ч гэдэг юм уу тэр бол Техникийн Их сургуулийн удирдах зөвлөлд байх ёстой байхгүй юу. Тэд нар чинь нөгөө гол худалдан авагч, хэрэглэгч нь. Тэгээд тэдний эрэлт хэрэгцээ шаардлагатай нөгөө боловсролын байгууллага уялдаж байх ёстой. Яг энд тийм бодлого хэрэгжүүлнэ гээд л ерөнхий заалтуудаас гадна холбогдох сургуулиудын Удирдах зөвлөлд орж байна ч гэдэг юм уу. Тэгж байж энэ их, дээд сургуулиуд чинь академик бас зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлж үйлдвэрлэх бодлого нь уялдаж байх ёстой юм байгаа юм.

Ингээд санал хураалт явуулъя. Гишүүд Ганбаатар гишүүн. Манай Ганбаатар гишүүн чинь Эдийн засгийн байнгын хорооны дарга байхдаа энэ хуулийг бас их.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Энэ яагаад дуугарч барихгүй явж байна. Энийг шалга. Дуугарч зарлаж байж явагдах ёстой. Сая бол техникийн шалтгаанаар энийг хүчингүйд тооцно. Ингээд санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. 27 гишүүн дэмжиж, 62,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ хонх нь их чангахан дуугардаг байвал зүгээр байгаа шүү.

10.Төслийн 8 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал

хураалт. 59,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 9 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 11 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 27 гишүүн дэмжиж, 62,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 12 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Учрал гишүүн их сайн хууль санаачилсан юм. Тэгээд даанч ажлын хэсэг энэ дээр 2 жил саатаж байгаа даа. Энэ чинь 5 жил билүү. 58,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Их Хурлын даргын зүгээс нэлээн шахаж байж оруулж байгаа юм шүү. Сая ч бас. Баттөмөр гишүүн бид 2 л.

15.Төслийн 13 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 22 гишүүн дэмжиж, 51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүд анхааралтай байгаарай. Одоо санал хураалт явна шүү. Энэ хууль тэгэхдээ Учрал гишүүн ээ, танхимын хууль өргөн барьчихлаа гээд танхимын хуультай хамт хэлэлцэнэ гээд саатчихсан байхгүй юу. Танхимын хууль нь байдаггүй. Сая л өргөн баригдлаа. Өчигдөр л өргөн баригдлаа.

16.Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл.Төрийн байгууллагатай хамтран ажиллах

13.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо төрийн байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллана:

13.1.1.тухайн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг,

стандарт, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, санал, зөвлөмж гаргах;

13.1.2.зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчилж дүгнэлт гаргахад санал өгөх, шаардлагатай тохиолдолд тухайн зөвшөөрлийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээний талаар санал, дүгнэлт гаргах;

13.1.3.хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу шилжүүлэн авах;

13.1.4.тухайн салбарын техникийн нөхцөл, стандартыг боловсруулах, батлах, мөрдүүлэх, хэрэглээний тайлбар, зөвлөмж бэлтгэх;

13.1.5.хуульд заасан тохиолдолд төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

13.1.6.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцох, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

13.1.7.салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтаар суралцагчид эзэмшүүлэх мэргэшлийн түвшинг Хөдөлмөрийн тухай хуулийн 17.2, 17.3-т зааснаар тодорхойлоход оролцох;

13.1.8.хууль болон мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэмд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болголоо. Санал хураалтыг хүчингүй болгосон. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн хууль санаачлагч. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн Учрал гишүүнтэй хамт санаачилсан.

Г.Мөнхцэцэг: Энэ хууль ч бас нэлээн хүлээгдсэн. Асуулт бас байна. Тэгэхдээ юу яаж байгаа юм. Ер нь эдийн засгийн чиглэлээр холбоодын зүйлүүдийг тусгасан нэлээн ийм бас дэлгэрэнгүй хууль. Дээрээс нь гадна талд чинь зөндөө олон мэргэжлийн холбоод гэж байж байна л даа. Зохиолчдын эвлэл, Хөгжмийн зохиолчдын холбоо гээд ингээд энэ одоо яг мэргэжлийн байгууллагууд холбоод мөн үү мөн. Одоо зарим нэг нь холбоод биш эвсэл гээд явж байгаа. Монголын Зохиолчдын эвлэл энэ тэр гэдэг гэдэг ч юм уу. Хөгжмийн зохиолчдын эвлэл ч гэдэг юм уу ингээд явж байгаа л даа. Тэгэхээр энэ хуулиар яаж бас зохицуулалтууд энэ дотор туссан юм бэ. Жишээлбэл төртэй яаж холбогдох юм. Би энэ хууль санаачлаагүй л дээ энэ.

Г.Занданишатар: Асуулт байхгүй. Хууль санаачлагч биш юм байна. Учрал гишүүн санаачилсан. Асуулт байхгүй. Байнгын хороо дээрээ энийгээ ярилц. Тодорхойлолт нь байгаа. Тодорхойлолт нь байгаа. Тэр тухайн салбарын тодорхойлолт байгаа шүү дээ. Тэрийгээ эхлээд уншъя. Уни. Тэгээд санал хураалтаа явуулъя.

Баттөмөр гишүүн ээ, харин Учрал гишүүн ээ, нөгөө талдаа төрийн байгууллагуудыг үүрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Сургууль, төрийн байгууллага Удирдах зөвлөлдөө оролцуулна, сонсдог байна. Тэгээд дагах хуулиудад хууль санаачилж болно шүү дээ. Тийм ээ. Засгийн газар болон бусад холбогдох хуульд өөрчлөлт оруулж болно. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ер нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хуультай бас уялдуулах шаардлагатай байх. Саяын энэ саналаа Мөнхцэцэг гишүүн.

17.Төслийн 15 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 22 гишүүн юу вэ энэ. Жамбалын

Ганбаатар сайд, Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая.

Н.Энхболд: Би уг нь сая дэмжсэн санал өгсөн юм. Тэгээд кнопоо буруу дарчхав уу яав. Энэ эсрэг гарчихлаа. Санал хураалтыг хүчингүй болгож өгөөд дахиж санал хурааж өгөхийг хүсэж байна.

Г.Занданишатар: Санал хураалтыг хүчингүй болгох Нямаагийн Энхболд гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Оюунчимэг гишүүн ээ. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 53,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалт дахиж явуулна.

17.Төслийн 15 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 53,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ ерөөсөө ингээд дараалаад 15, 16, 17, 18 дугаар зүйлийг хасах гэсэн санал хураалт байгаа юм л даа. Нийлүүлээд хураачихмаар байна.

Төслийн 18 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ахиад тодруулаад протоколд тэмдэглэхье. 17, 18, 19, 20 дахь саналууд буюу төслийн 15, 16, ,17 18 дугаар зүйлийг хасах

саналууд дэмжигдлээ. Энэ заалтууд хасагдлаа.

Одоо 21.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “этгээдэд” гэсний дараа “Эрүүгийн хууль, эсхүл” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 14.1 дэх хэсгийг тус тус нэмэх:

“14.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 57,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ гэмт хэргийн шинжгүй гэж бичдэггүй шүү. Хууль зүйн техникийн хувьд энийг нягтлаарай Тамгын газар. Эрүүгийн хариуцлага тооцохооргүй бол энэ тэр гэж найруулаарай.

Гэмт хэргийн шинжтэй, шинжгүйг чинь. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны хууль. Тэгэхгүй бол гэмт хэргийн шинжтэй, шинжгүйг чинь шүүх тогтоодог болохоос биш.

22. Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.1 дэх хэсэг болгох:

“15.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Мэргэжлийн мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх санал хураалт дууслаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр санал хураалт явуулна. 4 санал байгаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Нямаагийн Энхболд /цаашид “Ажлын хэсэг” гэнэ/. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж хууль баталлаа.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 57,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тухай:

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ ажиллахаа больчихлоо шүү. Бүх хуруу уншихаа больчихлоо. 51,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Би дэмжсэн юм байгаа юм. Хурууны хээ уншихаа больчихлоо.

Ингээд Эдийн засгийн шинжлэх ухааны доктор Баагаагийн Баттөмөр эдийн засагч, Цэндийн Мөнх-Оргил одоо манай Харвардын хуульч 2 ажлын хэсэг сайн ажиллаж энэ хууль эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Ганбаатар гуай бас сайн ажилласан.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Эцсийн хэлэлцүүлэг маргааш хийж чадвал тэгээд.

11.08 цаг.

Дараагийн асуудалд орно. Үндэсний баялгийн сангийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 55 дугаар захирамжаар Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын

төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Доржханд, Оюунчимэг, Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллууллаа.

Байнгын хороо 2024 оны 4 сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дээрх санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ундрэм төрөлжсөн сангуудын хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг арвижуулах, менежментийн багийг бүрдүүлэх, хяналт тавих, зарцуулах, хуваарилалт болон хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батлут баялгийн сангийн асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд тавигдах шаардлага, тэдгээрийг томилох, баялгийн сангуудын нээлттэй, ил тод байдлыг хангах талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг санал тус бүрээр хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ. Тухайлбал, хуулийн төслийн зарим хэсэг заалт бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, нэр томъёог жигдлэх, дэс дарааллын өөрчлөх зарчмын зөрүүтэй саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хоорондын нийцлийг хангах, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийн эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 20-оос дээш хувийг аливаа этгээд дангаар болон харилцан хамаарал бүхий этгээд хамтран эзэмшихийг хориглохоор тусгасныг 34 болгон өөрчлөх, түүнчлэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглах тохиолдолд төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохтой холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулах саналыг хуулийн төсөлд шинээр нэмж тусган зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлд Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, 2024 оны хаврын нэгдсэн чуулганд багтаан Улсын Их Хуралд танилцуулж, Монгол Улсын иргэн бүрд 2024 оны 2 дугаар улиралд багтааж хуримтлалын нэрийн данс үүсгэх, Баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан хуримтлалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон заалтууд шинээр нэмж тусгах зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар авах арга хэмжээний талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Тэр хооронд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Тасаллаа. Алга байна. Ням-Осорын учрал гишүүнээр тасаллаа. Сандагийн Бямбацогт, Хассуурийн Ганхуяг гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат.

С.Бямбацогт: Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Монгол Улсын Засгийн газар өргөн барьсан. Үндэсний баялгийн сангаасаа байгалийн баялгийнхаа өгөөжөөсөө ард иргэддээ бас тэгш шударга хүртээх, хүн болгон хувьцаа эзэмших, ноогдол ашиг авах бололцоо боломжийг бүрдүүлэх гэж 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Энэ хүрээндээ ч энэ асуудлыг ярьж байгаа. Гэтэл одоо нөгөө хуулийг гууль болгох гээд, энэ хуулийг хэрэгжүүлэхгүй байх гээд ард иргэдийн хүсэн хүлээж байгаа 3 сая 500 мянган иргэн хувьцаа эзэмшиж, ноогдол ашиг авах энэ хүлээлтийг нураах гэж байгаа юм уу, яах гэж байгаа юм. Ийм одоо асуудал орж ирэх юм. Аль болох хурдан баталмаар байна. Энэ хууль хэрэгжээд, байгалийн баялгаасаа Монгол Улсын иргэн болгон хувь хүртмээр байна.

Гэтэл энэ дээр ингээд Засгийн газрын өргөн барьсан төслөөс тэс өөр орлого төвлөрүүлэгч этгээд нь уур уурхайн олборлолт ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангана гэсэн заалт Засгийн газраас өргөн барьсан.

Гэтэл энэ дээр авто зам, төмөр замын дэд бүтцийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангана гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол авто замын бүх АЗЗА-ууд. Монгол Улс 14 мянган км замтай. Энэ 14 мянган км замыг хариуцаж, зам засвар ашиглаж байгаа компаниуд орлого олдоггүй. Ард иргэдийг л аятай тухтай зорчуулах. Энхийг “Эрдэнэс Монгол”-д мэдэх юм байна. Улаанбаатар төмөр зам, Тавантолгой төмөр зам, Монголын төмөр зам, энэ төмөр замын бүх компаниудыг “Эрдэнэс Тавантолгой” мэдэх юм байна. Улаанбаатар Төмөр замыг одоо яаж мэдэх юм болоо. Ийм хачин заалт оруулаад ирэх юм. Үүний цаад талд ерөөсөө л Гашуунсухайтын авто зам гэж “Эрдэнэс Монгол” компани жилдээ 350 тэрбум төгрөгийн орлого олдог. Өдөртөө 540 сая төгрөгийн орлого олдог. Замаа засдаггүй. Түүгээр зорчиж байгаа, тээвэр хийж байгаа жолооч тээвэрчид байнга амь нас, эрүүл мэндээрээ хохирдог. Аваар осол хийж. Яагаад гэвэл зам засдаггүй. “Эрдэнэс Монгол”-ын ажилчдын цалинг тавьдаг. Үүнд л зарцуулагддаг. Үүнтэй адилхан юм хийх гээд байна шүү дээ. Үгүй ээ, одоо Гашуунсухайтын замаа засахгүй байж орлогыг нь цалинг нь тавьж байж бүх төмөр замыг, бүх авто замыг мэдэж яах гээд байгаа юм чадах юм уу. Наранцогт дарга энэ дээр хариул. Чадах уу.

Өнөөдөр “Си” зөвшөөрлийн авлига байна гэсээр байгаад “Си” зөвшөөрлийг уул уурхайн компаниуд авсан. Өнөөдөр урьд нь 1 сая, 2 сая гэж яригддаг байсан бол 20-30 сая төгрөгийн авлига яригддаг болсон. Өнөөдөр Монгол тээвэрчид 10 хоногт ганцхан удаа маш бага тарифаар тээвэр хийж байгаа. Хятад тээвэрчид, Хятад жолооч, Хятадын компаниуд өдөр болгон өндөр ханшаар тээвэр хийж байгаа. Үүнээсээ болоод тээвэрчид чинь жагсаал цуглаан хийгээд, ажил хаялт хийгээд зам хаагаад боогоод байж байгаа. Ийм байдлаар үндсэндээ “Си”

зөвшөөрлийг жишээ нь уул уурхайн компаниуд авснаас болж тэр авлига нь 20-30 сая болсон. Монгол тээвэрчид нь харьцангуй өндөр орлоготой байсан бол өнөөдөр банкны зээлээ төлж чадахаа больсон, амьдралаа авч явж чадахаа больсон. Аргаа барчхаад жагсаал цуглаан хийж байна. Ийм л болчихоод байгаа шүү дээ.

Энэ мэргэжлийн байгууллага нь салбарын яам нь яагаад энэ асуудлаа хариуцаад явж болдоггүй юм бэ. Яагаад ийм асуудлыг ингэж хөндөөд яриад байгаа юм бэ. Үгүй ээ, урьд нь хэллээ шүү дээ би. Гашуунсухайтын авто зам дээрээс өдөрт 540 сая төгрөгийн орлого олж байгаа. Жилдээ 350 тэрбум. Түүгээрээ “Эрдэнэс Монгол”-ын цалин тавигдаж байгаа юм. Тэгчхээд ийм байдалтай асуудал яриад сууж байдаг. Өнөөдөр “Си” зөвшөөрөл нь 20, 30 сая болчихсон. Монгол тээвэрчид нь орлого байхгүй. 10 хоногтоо 1 удаа арай чүү тээвэр хийдэг. Маш бага тарифаар. Амьдрахын эрхэд банкны зээлээ төлөхийн эрхэд. Гэтэл Хятадын жолооч нар, тээвэр тээврийн компаниуд нь өндөр тарифтай өдөр болгон тээвэр хийдэг. Монгол хүн чинь Монгол Улсдаа бас эзэн шиг амьдармаар байна шүү дээ. Яагаад Монгол тээвэрчид нь ахиу орлоготой байж болдоггүй юм. Яагаад Монгол тээвэрчид нь өдөр болгон тээвэрээ хийж болдоггүй юм. Өнөөдөр Гашуунсухайтын замаа засаж чадахгүй өдөр болгон аваар осол гаргаж байж Монгол Улсын энэ 14 мянган км замыг мэдэж яах гээд байгаа юм энэ “Эрдэнэс Монгол”. Ингээд хуулийг гууль болгож яах гээд байгаа юм. Ямар санаатай юм, ямар зорилготой юм.

Г.Занданшатар: Байнгын хороо, ажлын хэсэг Баагаагийн Баттөмөр гишүүн хариулна.

Б.Баттөмөр: Энэ Монголын бүх замыг авна гэсэн юм бол энд байхгүй ээ Бямбацогт сайд аа. Зүгээр ажлын дэд хэсгээс ямар санал оруулж ирсэн гэхээр энэ Гашуунсухайтын авто зам бол 100

хувь “Эрдэнэс Тавантолгой”-н мэдэлд байна. Гашуунсухайтын тэр төмөр замын 66 хувь нь бас “Эрдэнэс Монгол” компанид байна. Ийм учраас энэ технологийн зам дээрээ энэ одоо “Эрдэнэс Тавантолгой”-н зам байх нь зөв юм уу гэсэн ийм саналыг ажлын дэд хэсгээс оруулж ирээд, ингээд дэмжигдээд явж байгаа юм. Зүгээр ер нь бол уул уурхайн том том компаниуд бол “Эрдэнэс Монгол” дээр байна. Бодлого нь Уул уурхайн яам дээр явж байгаа. Энэ зам бол “Эрдэнэс Монгол” компани дээр очсоноороо энэ бодлого бол би алдагдчихгүй байх гэж бодож байгаа. Энэ зөвхөн удирдлага гэсэн нэг юм дээр сайд эмзэглээд байх шиг байна л даа. Тэгэхээр энийг нэмээд манай Наранцогт захирал хариулчихъя.

Г.Занданшатар: 4 номер Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал хариулна.

С.Наранцогт: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Сайдад жоохон буруу мэдээллүүд очсон бололтой байна.

1-д энэ ажлын хэсгийн үед баялгийн сангийн орлогыг тогтвортой байлгах тухай асуудал бүлэг дээр энэ уул уурхайн ТӨК-ууд, тэдгээрийн удирдлага зохион байгуулалт нэгдмэл байж ингээд орлого, хувьцаа, ноогдол ашиг ингээд нэгдсэн байдлаар төвлөрч иргэдэд хуримтлалын сангийн орлого бүрэлдэх энэ ерөнхий концепцын хүрээнд тодорхой салбаруудын нэр орж явсан. Энэ үед бол ажлын хэсгийн дарга, бусад ажлын хэсгийн гишүүдийн хүрээнд ярьж байгаад энэ бүрэлдэхүүн компаниудын асуудал ярьж байх үед бол манай өөрийн хөрөнгө оруулсан Хөгжлийн банкны өрийг 239 тэрбум төгрөг төлсөн Гашуунсухайт авто зам, бүх хөрөнгө оруулалтыг нь оруулсан Тавантолгой төмөр зам гэдэг 2 байгууллага байгаа. Үүний чинь үг, үсэг алга байна гэдэг утгаар авто зам, төмөр зам гэсэн ийм үг орсон юм. Энийг ингээд бүх зам, бүх авто тээврийн зам орох гэж

байна, бүх төмөр зам орох гэж байна гэдэг ийм ойлголт явсан байна. Ингээд сая бол бас бүлгийн дарга энэ тэр дээр энийг нэмэлт найруулгаар тодруулаад, хөрөнгө оруулсан гэдэг асуудлыг нь тодотгож өгөх нь зүйтэй байх гэдэг ийм зүйлийг ярьсан. Тэгэхээр бол энэ мэдээллийг бас зөв зүйтэй ойлголцох асуудал 1 дүгээрт байна гэж ингэж үзэж байна.

2 дугаарт бол салбарын сайдад Гашуунсухайт замын талаар маш их буруу арай тэнгэр, газар шиг зөрүүтэй тоо явдаг юм байна. Жилдээ дунджаар 60 орчим тэрбум төгрөгийн орлого олдог зам. Үүний мөнгө Хөгжлийн банкны өрийг төлөөд замын зардалд бол нийтдээ 9 жилийн хугацаанд 169 сая төгрөгийг замын зардалд зарсан байдаг. 87 тэрбум төгрөгийн зам засварын ажил хийсэн. Ноднин жил бол бид орлого сайтай учраас 25 тэрбум төгрөгийн засвар хийсэн. Энэ нь бол бараг нийт улсын хэмжээнд энэ АЗЗА-уудын зардлаас ч хамаагүй илүү тавигдаж байгаа байх. Энэ жил мөн тэр хэмжээний зам засварын ажил хийгдэнэ.

Гашуунсухайт замын хувьд бол орсон орлогын 10 хувь нь л “Эрдэнэс Монгол” болоод охин компаниудын санхүүжилтэд зарцуулагддаг ийм байдалтай байгаа. Сая замын хувьд бол би тодорхой хариулаа. 2 л авто зам, 1 төмөр замын компанийн л асуудал байгаа. Энэ дээр өөр бусад бүх зам гэсэн ойлголт байхгүй ээ.

Г.Занданшатар: Байж байгаарай. Би энэ ажлын хэсгийг танилцуулчихъя. Даишэвэгийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Лхамсүрэнгийн Баярмандал Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Алтантулгын Батсайхан Монголбанкны Төлбөр тооцооны газрын бодлого

зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Батмөнхийн Агиймаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер.

Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууна.

С.Бямбацогт: Энэ Засгийн газрын өргөн барьсан хуулийн үзэл баримтлал, хуулийн үйлчлэх хүрээ, хамаарах харилцаанаас хальсан асуудал ороод байгаа байхгүй юу. Энэ хуулийн зорилго дээр биччихсэн байна шүү дээ. Энэ хуулийн зорилт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сан байгуулна гэж. Газрын хэвлийн баялаг, байгалийн баялгийн үр өгөөжөөс тэгш шударга иргэн бүрд хүртээе. Гэтэл энэ дээр авто замын, төмөр замын, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бүх компаниуд ингээд орлогоос бүрдүүлнэ. Ингээд орчихсон. Дараа нь одоо эрчим хүчний компаниудын, мөн нефтийн компаниудын, цаашиад юу гэдэг юм архины компаниудын орлогоос бас ийш нь бүрдүүлье гээд ингээд л нэг цоорхой гаргачхаад, энэ цоорхойгоор чинь гооожоод үндсэндээ энэ хууль чинь гууль болчих юм биш үү. Байгалийн баялгийн өгөөжөөс л бид нар ард иргэдээ хүртээх гээд байгаа болохоос тэр нефтийн, эрчим хүчний, авто замын, төмөр замын.../минут дуусав/

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт. Байнгын хороон дарга хариулах юм бас. 4 номер Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Бямбацогт гишүүний асуултад тодруулж хариулъя. Энд 2-т хуулийн яг ингээд төслийг нь унших юм бол 2 зүйл байгаа. Та энийг

анзаарвал. Орлого бол хамаарахааргүй уншигдана. Төмөр зам. Удирдлага, зохион байгуулалт гэдэг хэсэг дээр тэр авто зам, төмөр зам гэдэг үг нэмэгдсэн юм. Тэгээд тэр нь бол би сая 2 компанийн тухай л ярилаа. Тэрийгээ тодруулаад найруулах засварыг оруулъя гэдэг асуудлыг бас танд тодруулж хэлсэн. Энэ удирдлага зохион байгуулалтын хувьд бол ерөөсөө баялгийн сангийн орлогыг тогтвортой байлгах тухай л асуудал. Энэ бол Засгийн газрын өөрийн одоо энэ Засгийн газрын барьж байгаа тов тодорхой бодлого. Яг энэ хүрээндээ бол жишээлбэл уул уурхайн ТӨК-уудыг “Эрдэнэс Монгол”-д яг энэ компанийн тухай хуульд заасан удирдлага, зохион байгуулалтын ажлыг нь бол Уул уурхайн яам бүрэн шилжүүлж өгсөн. Уул уурхайн яам бол салбарын бодлогоороо бид нарт чиглэл өгөөд, салбарынхаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг Эдийн засгийн байнгын хорооны дарга гүйцээж хариулна.

Ц.Цэрэнпунцаг: Бямбацогт сайдын асуусан асуултад гүйцээгээд хариулчихъя. Энэ бас Байнгын хороо дээр дэмжигдээд явсан 2 үндэслэл байгаа юм.

Нэг.Ер нь энэ яамдад компаниуд байдаг бол зарчмын хувьд бол буруу гэж ер нь бид нар үзээд байгаа юм. Өнөөдөр энэ жишиг байна. Уул уурхайн яам хэрвээ бүх компаниудыг дороо авчраад байлгая. Ингээд бидэнд байх ёстой, бодлого алдагдаад байна гэвэл Эрдэнэт, төрийн өмчийн оролцоотойгоор Оюутолгой хүртэл гээд л энэ бүх л том компаниуд Уул уурхайн яаманд байж болно л доо. Тэгэхдээ өнөөдөр Уул уурхайн яам бодлогоо бариад, энэ компаниуд нь өөрөө аж ахуй тэр бизнесийнхээ үйл ажиллагааг бие даан шийдвэр гаргаад явуулах энэ нөхцөлтэй ажиллаад болоод байгаа зарчим бол ер нь цаашидаа бусад энэ яамнуудад үйлчлэх ёстой гэдэг нэг ийм зарчмын үүднээс бол энэ төмөр замын асуудлууд бол байж болох нь ээ. Тэгэхдээ 1 ойлголт байх ёстой.

Г.Занданшатар: Гүйцээж хариулъя гэж үү. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн гүйцээж хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Энэ компаниуд энэ яам дээр байдаг нь л бол зарчмын хувьд буруу юм. Уул уурхайн яам бол жишигээр энэ жишиг сайхан ажиллаж байна. Ганбаатар сайд бол энэ дээр сайхан жишиг тогтоож ажиллаж байна гэж харж байгаа юм. Тэгээд энэ чиглэл рүү бас явбал зүгээр байна гээд.

2 дугаарт ерөнхийдөө ойлголт бол одоо бид нар энэ чуулган дээр явж байна протоколд одоо үлдээх хүсэлтэй байгаа юм. Ер нь энэ агуулга цаанаа ямар ойлголттой яваа юм гэхээр зэрэг энэ бол Тавантолгой компанийн хөрөнгө оруулсан энэ хөрөнгө оруулалтаар хийсэн хөрөнгө оруулалтаа энэ Тавантолгой компани олж авах ёстой. Энэ 3 сая 400 гаран мянган хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг. Эдний 3,8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ. Энд компани бүрэн үнэ цэнтэй болно. Та нарын хувьцааны чинь үр ашиг нэмэгдэнэ гэж хэлээд аваачаад хөрөнгө оруулалт оруулчихсан компаниуд өнөөдөр Тавантолгой Гашиунсухайт гээд ажиллаж байгаа. Энэ компаниудыг үр ашиг шимийг нь хувьцаа эзэмшигчид хүртэх ёстой. Энэ боломжийг хангаж энэ төмөр замын компаниуд бол өнөөдөр Тавантолгой компанийн бүрэлдэхүүн “Эрдэнэс Монгол” компанийн бүрэлдэхүүнд байх ёстой. Ялангуяа “Эрдэнэс Тавантолгой” гэж энэ охин компанийнх нь энэ хөрөнгө мөнгө, хөрөнгө оруулалт хийчихсэн учраас энд байх ёстой гэдэг агуулга цаанаа юу байгаа юм. Тэгэхдээ бид нар одоо бол энэ чигээр нь энэ төсөл дээр байгаа агуулгаар нь явахад ойлголт бол цаанаа энэ бусад хот хоорондын, улс хоорондын, төрийн өмчтэй төрийн төсвөөс хөрөнгө оруулалт хийж баригдсан авто зам, төмөр замуудыг бүгдийг нь энэ “Эрдэнэс Монгол” компанийн бүрэлдэхүүнд оруулна гэсэн агуулга байхгүй юм. Энийг та бүхэн сайн ойлгоорой. Тэгэхдээ бид нар өнөөдөр зөв жишиг тогтоож явах

ёстой. Өнөөдөр яамнууд бодлогоо гаргаад явахад заавал компани төрийн өмчтэй компаниудыг энэ яам шууд удирддаг энэ жишиг бол буруу. Энийг больё. Цаашидаа ийм чиглэл, ийм зарчимтай явж болохгүй ээ л гэсэн агуулга энд байгаа юм. Ийм шалтгаануудаар Байнгын хорооноос тэмдэглэж гарч явсан юм шүү.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Цэрэнпунцаг гишүүний бас хариултаас харахад ерөөсөө яам байх шаардлагагүй ээ. Ерөөсөө л тэр “Эрдэнэс Монгол” гэж ганц компани, Төрийн өмчийн хороо байхад ерөөсөө тэгээд л бүх одоо компаниудыг удирдаад аваад явчихна гэж хариулж байна л даа. Яах гэж Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийг баталдаг юм. Яах гэж түүн дотор нь ингээд эрчим хүчний асуудлыг Эрчим хүчний яам, түүн дотроо тог цахилгаантай байх асуудлыг Чойжилсүрэн сайд хариуцна гээд. Иргэн болгон тог тасрах юм бол Чойжилсүрэн сайдаа тог яагаад тасрав гэж гүйдэг юм бэ.

АЗЗА компаниуд замаа засахгүй бол Бямбацогтоо тэр замаа засаач гэж яагаад над руу гүйгээд байдаг юм бэ. Энэ чинь мэргэжлийн удирдлагаар хангаад, салбарынхаа бодлогыг тодорхойлоод, ард иргэдэд төрийн үйлчилгээ, салбарын үйлчилгээг барилгын, эрчим хүчний, замын асуудлыг чинь л иж бүрнээр нь хүргэх гэж л энэ яамнууд байдаг юм. Гэтэл нөгөө талд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гээд тэр дээр ашиг ол гэдэг АЗЗА-ууд дээр бид нар ашиг олох чухал биш ээ. Зам засах ёстой, зам цоорхойгүй байх ёстой, зам халтиргаагүй байх ёстой гэдэг асуудал ярьдаг. Ийм эсрэг тэсрэг байдаг юм аа. Ийм учраас мэргэжлийн яам бодлогоор хангаж.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг Эдийн засгийн байнгын хороон дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Бямбацогт сайд та бас зөв ойлгоорой. Ингээд намайг мушгихгүй шиг хоёулаа ингээд зөв ойлголттой явбал бас зүгээр байх. Ер нь тэгээд л энэ Бямбацогт сайдын сая хэлж байгаа логикийн ард байгаа байхгүй юу. Хэрвээ бодлого гаргаад тэр салбарын бодлогыг авч явахад яаманд энэ яамны бодлого, чиглэлд хамаарч байгаа үйл ажиллагаа явуулдаг компаниуд орох юм бол ард нь дахиад тэгвэл танай яам энэ бүх хувийн компаниудыг энэ зам, авто зам, төмөр зам эзэмшдэг хөрөнгө оруулалт хийсэн энэ дээр үйл ажиллагаа явуулдаг бүх компаниудыг танай яам бас оролцох доороо шууд удирдлагадаа авах шаардлага гарна шүү дээ. Үгүй ээ, харин тэгээд бодлогоор хангаад та нар өнөөдөр тэр шууд удирдлагад нь ордоггүй биз дээ. Яваад л болдог биз дээ. Тэгэхээр зэрэг өнөөдөр төрийн өмчтэй компаниудыг нь ялгаж аваад, бид нар энэ дээр шууд бид нарын яам доор байгаа учраас бид нарын бодлого сайн хэрэгжиж байна гэж бол тайлбарладаг бол ард нь буруу логик явж байгаа байхгүй юу.

Г.Занданишатар: Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Би өөрөө энэ ажлын хэсгийн гишүүн байгаа. Тэгэхдээ эрүүл мэндийн шалтгааны улмаас бас ажлын хэсгийн хуралд оролцож чадаагүй юм. Тэгэхдээ бид нар ХҮН намын зүгээс бол тодорхой саналуудаа ингээд тавьсан байгаа. Тэгээд тэрэнтэй холбоотойгоор тодорхой 3 зүйл асууя.

Бидний хувьд бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт тогтоцооны өөрчлөлтийг бол хийнэ гээд 2 жил ярьсан. Ард нь бол бүгдээрээ хамтдаа гарсан. Үүний дараа бид нарын хамгийн том реформ бол энэ эдийн засгийн реформ байгаа юм. Тэгээд эдийн засгийн

реформ дээрээ бол яг бодитой прагматик байдлаар бид нар зохицуулалтаа хийх ёстой. Тэгээд тэр агуулгаар бол энэ хуулийн төслийг бол дэмжсэн. Намуудын удирдлагуудын хувьд бол гарын үсгээ зурсан. Тэгээд энэ дээрээ бол хамтарч цаашаагаа явна гэсэн ийм байр суурь дээр хатуу байгаа шүү. Тэрийгээ бас хэлчихье. Энэ хүрээнд бол бид нар нөхцөлөө ингээд тавьсан. Тухайлбал 3 сан байх юм байна. 3 сан догтроо болохлоороо хөрөнгө оруулалтын сан гэж байх юм байна. Хөрөнгө оруулалтын сан нь юу вэ гэхээр дэлхий дээр юу болоод байгаа юм бэ гэхээр өнөөдөр хөрөнгө оруулалт татарчихсан юм шүү дээ. Энэ бүс нутагт чинь ингээд байхгүй болчихсон. Тэгээд сүүлийн 50, 60 жилийн хугацаанд бол ингээд шууд хөрөнгө оруулалт орж ирдэг байсан. Бизнесүүд хурч ирээд эрсдэлээ үүрээд ордог байсан. Одоо тэр чинь зогсчихсон шүү. Одоо яадаг болчихсон бэ гэхээр төр нь тодорхой хэмжээнд баталгаа гаргаж байж эх үүсвэрээ ингээд оруулсны үндсэн дээр хөрөнгө оруулалт орж ирдэг болчихсон. Одоо яг ийм загвараар ингээд баялгийн сан анх байгуулагдаж явсан байхгүй юу. 2000 оноос хойш амжилттай явж байгаа загвар нь бол энэ.

Өөрөөр хэлэх юм бол *асго- investment* гэж ярьдаг. Засгийн газрын тодорхой эрсдэлээ ингээд үүрээд 10-15 хувийг нь оруулаад өөрийнхөө коммитмент буюу баталгаагаа ингээж оруулсны үндсэн дээр гаднын хөрөнгө оруулалтууд том төслүүд дээр орж ирдэг. Энэ загвар бол маш амжилттай явж байгаа. Энийг л бид нар хийхгүй юм бол энэ хууль маань үр дүнгүй болох юм. Тэгээд тийм болохоор бид нар энэ зохицуулалтыг оруулъя гэсэн байдлаар саналаа өгсөн байгаа. Энэ туссан уу. Нэг.

2-т нь болохоороо энэ хуримтлалын сан гэж байгаа. Хуримтлал нь болохлоороо ирээдүйн хуримтлал одоогийн хуримтлал гэсэн байдлаар. Одоогийн энэ хуримтлалыг нь болохоор ХҮН намын зүгээс бид нар энийг

тэтгэврийн реформоо цогц хийх байдлаар шийдэх нь зүйтэй байна. Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр 17 хувийн шимтгэл төлдөг бол 10 хувийг нь эндээсээ санхүүжүүлчихье. Тэгээд тодорхой өмчлөлийн хэлбэр бүхий ийм тэтгэвэр сангуудыг үүсгэх байдлаар урт хугацааны хөрөнгө оруулалтыг хийгээд явдаг байя гэсэн ийм байдлаар бид нар ингээд саналаа өгсөн. Энэ маань туссан байна уу.

3 дугаарт болохоор Ирээдүйн өв сан гэж байгаа. Ирээдүйн өв сан гэдэг хуулийг бол бид нар 2015 онд бол хийж байсан. Энд сууж байгаа мэргэжилтнүүдтэй би бол яг техникийн ажлын хэсгийг нь ахлаад Сангийн яам дээр өөрөө удирдаж хийж байсан л даа. Ирээдүйн өв сан гэдэг дээр бүгдээрээ гар хүрэхээ больё. Энэ болохоор өнөө үед байгаа хүмүүс, ирээдүй үед байгаа хүмүүс бүгдээрээ ижилхэн Монгол Улсын иргэд. Тэгээд өнөөдрийн баялаг бол зөвхөн өнөө үеийнхэн хэрэглэж болохгүй ээ. Энийг бол хадгалаад ирээдүй үедээ бас хэрэглүүлэх боломжийг нь өгөх хэрэгтэй гэдэг ийм агуулгаар хийсэн. Тэгэхээр энэ дээр бол хуулийн ямар нэгэн өөрчлөлт байхгүйгээр тэр бүтцээрээ авч үлдэж байгаа гэдэг ийм сан үлдэх нь зүйтэй гэсэн байдлаар бид нар саналаа өгсөн. Энэ дээр та бүгд бас тэр санал маань ямар байдлаар туссан юм бэ гэдэг дээр хариулт авмаар байна.

Тэгээд эцэст нь бол хамгийн чухал юм бол Засаглал юм аа. Дэлхий дээр амжилттай явж байгаа баялгийн сангуудын хамгийн давуу тал бол ямар нэгэн шийдвэр гаргагчаас, төр засгаас, улс төрчөөс хамааралгүйгээр мэргэжлийн баг л тэнд орж ирж шийдвэрээ гаргаж чадах юм бол энд амжилт яваад байгаа юм шүү. Тэгэхээр засаглалын хувьд өнөөдөр бид нар Ирээдүйн өв сан нь Сангийн яам дээр ингээд байгуулаад явчихсан. Уг нь корпорац байгуулагдах ёстой. Тэр нь байгуулагдаагүйгээс болоод өнөөдөр сангийн зарцуулалт нь тодорхойгүй, ил тод биш, мөнгө нь бас байгаа үгүй нь

мэдэгдэхгүй ийм байдалтай байгаа. Цаашидаа бол энэ бол ингээд тов тодорхой биеэ даасан хараат бус ийм бүтэц ажиглах ёстой. Гаднын менежмент байна уу, дотоодын менежмент.../минут дуусав/

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Баттөмөр: Доржханд гишүүн маш чухал асуудлуудыг хөндөж тавьж байна. Маш олон асуудлаар бид санал нэг байдаг. Таны энэ тавьж байгаа асуудлууд бол бүгд санал нэг байна. Монгол Улсад эдийн засгийн эрс шинэчлэлүүдийг хийх ёстой. Реформуудыг хийх ёстой. Энэ хүрээнд хийх гэж байгаа ажлын нэг нь энэ баялгийн сан юм. Баялгийн санг өргөн барьсан субъект бол Засгийн газар байгаа. Засгийн газар өргөн барихынхаа урд талд бол “Эрдэнэс Монгол” компани захиалга хийгээд, судалгаанууд хийсэн юм байна лээ. Тэгэхээр тэр судалгааны үр дүн юу гэж гарсан гэхээр энэ Баялгийн сан бол Монгол Улсын хувьд бол бараг анхдагч сан юм. Яах вэ, Ирээдүйн өв сан байсан. Одоо энэ бүгдийгээ нийлүүлээд Баялгийн сан гаргаж байгаа нь анхдагч учраас энийг тийм тооцоотой алгуур хийх нь зүйтэй. Шууд Temosek-ийн хувилбар ч юм уу тэр Норвегийн тэтгэврийн сангийн тэр загваруудаар аваачаад хийх юм бол үр дүн гарах нь бол бага.

Тийм учраас эрх мэдлийг бол Улсын Их Хурал дээрээ авах нь зүйтэй гэсэн ийм зөвлөмж гарсан юм байна лээ. Тэгээд үүний дагуу бол энэ Засгийн газраас өргөн баригдсан. ХҮН намын зүгээс Засгийн газраас өргөн барьсан энэ саналыг бол дэмжсэн гэж манай намын дарга бол надад бас хэлсэн байгаа. Бидэнд хэлсэн байгаа. Тэгээд энэ дээр юу гэж хэлэх гэж байна гэхээр энэ хөрөнгө оруулалтын сан гэдэг маань хөгжлийн сан байгаа. Хөгжлийн сан бол юу вэ гэхээр улсын төсөв ашигтай гарсан тохиолдолд Тогтворжуулалтын сангаас

жилд 370, 380 тэрбум төгрөг гарч байгаа шүү дээ. Доржханд гишүүн маш сайн мэдэж байгаа. Үүний 50 хувийг энэ хөгжлийн сандаа байгуулъя, хөгжлийн сандаа нийлүүлбэ гэж, эх үүсвэрийг нь үүсгэе гэж.

Та бас мэдэж байгаа. Нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 17.33-д байх аа, тэр 2024 оноос эхлээд энэ маань бол юу вэ гэхээр зэрэг "А" зэрэглэлийн үнэт цааснуудад хөрөнгө оруулна. Тогтвортой хөгжлийн санг. Мөн тэгээд цаашидаа хөрвөх чадвартай байна гээд хуульд заачихсан юм байна лээ. Урьд нь. Тэгээд энэ хүрээнд бол Хөгжлийн сангийн хөрөнгө ингээж арвижиж явах ёстой юм гэж орж ирж байгаа. Хуримтлалын сангийн хувьд бол мэдээж нөгөө төрийн өмчтэй компаниудын 34 хувийг энд нийлүүлбэ гэж байгаа шүү дээ. Үүнээс эх үүсвэрийг нь үүсгэе гэж байгаа юм. Тэтгэврийн реформтойгоо бол цогц яг хийх юм бол энд хуулийн төсөлд тусгагдаагүй явж байгаа юм. Энийг судалгааг нь сайн хийе. Өнөөдөр тэтгэврийн сан маань өөрөө алдагдалтай. Яах вэ, улсын төсвийн орлогын хувьд бол тодорхой хэмжээнд аваад явж байгаа. Сан маань бол цаашидаа эрсдэлтэй байгаа. Тийм учраас энэтэй нь уялдуулж тооцоо судалгааны үндсэн дээр нэмэгдэл байдлаар хийе гэсэн ийм зүйл явж байгаа юм.

Ирээдүй өв сангийн хувьд бол 2016 онд бол гаргасан юм байна. Одоо Доржханд гишүүн бас санаачлагчийн 1. 2016 оноос эхлээд хэрэгжээд явж байгаа. Өнөөдөр тэр сан маань 3,3 их наяд төгрөг. Монгол Улс Ирээдүй өв сандаа 1 тэрбум доллартой болж байгаа юм. Энэ жил дахиад 1 их наяд төгрөг нэмэгдэнэ. Ингээд 1,3 орчим их наяд төгрөг юу 1,3 орчим тэрбум долларын нөөцтэй болох нь. Энэ бол Монголбанкны Төрийн сангийн дансанд валютаар хадгалагдана гэж ингээд явж байгаа юм. Засаглалын хувьд бол гадна дотноос ч юм уу янз бүрийн хүмүүс авчраад янз бүрийн хүмүүс томилоод байх нь эхний ээлжид бас буруу юм. Энэ сангийнхаа тодорхой

хэмжээнд ингээд голдиролд нь ортол нь энийг бол шийдвэрийг Улсын Их Хурал гаргая. Салбарын яамнууд, Хөгжлийн яам бол тэр хөгжлийнхөө бодлоготой холбоотой асуудлыг, Сангийн яам Ирээдүйн өв сантай холбоотой асуудал. Тэгээд мөн Сангийн яам нь тэр хуримтлалын санд орох тэр хуримтлалын тооцоогоо гаргаад Засгийн газар оруулаад, Засгийн газар нь Их Хуралдаа оруулаад, Их Хурал шийдвэрийг нь гаргана. Их Хурлын гаргасан шийдвэрийг бол Засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газар буцаж тайлагнана. Тэгээд ил тод байна. Бүх мэдээллүүд байна. Шилэн байна гээд. Өөрөөр хэлбэл энийг буруу замаар Хөгжлийн банкны тэр буруу замаас л.../минут дуусае/

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууна.

Т.Доржханд: Баттөмөр дарга аа, тэгэхээр зөв зөв. Олон зүйл дээр бол бас тантай санал нэг байдаг аа. Гэхдээ нөгөө ХҮН намын хувьд бол бид нар маш олон энэ чиглэлийн экспертүүдтэй. Тэгээд саналуудаа бол өгөөд, тэгээд дэмжээд явж байгаа байхгүй юу. Энэ Монгол Улсын эрх ашиг юм аа. Бид нар ингээд маш их баялагтай юм. Баялгаа ингээд хуваагаад тараагаад өгнө гэдэг чинь өөрөө манай эдийн засгийг өсгөхгүй юм. Баялгийг л тэгш хуваарилна гэдэг бол биш юм аа. Энэ баялгаа ашиглаад илүү их хөрөнгө оруулалтыг гаднаас яаж татаж эдийн засгаа 2 дахин, 3 дахин, 5 дахин болгох вэ гэдэг бодлого чинь эндээс л гарна. Баялгаа менежмент хийсэн улсууд, хөгжсөн улсууд дандаа ингэж л явсан байгаа. Гэтэл энэ зохицуулалтыг бид нар оруулж ирэхгүй байх юм бол зүгээр ингээд л олоод л тараадаг юм руу орчих гээд байгаа юм.

2 дугаарт шийдвэр гаргах нь Их Хурал дээр байж болно. Гэхдээ менежмент хийдэг баг нь дандаа хөндлөнгийн мэргэжлийн баг байх ёстой. Энийгээ харин яаж хийх юм бэ. Эргээд

тэтгэврийн реформ гэдэг чинь өнөөдөр бид нар.../минут дуусав/

Г.Занданишатар: *Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч асуултад хариулна.*

Б.Баттөмөр: *Энэ гаднаас хөрөнгө оруулалт татах юуг бол яг энэ хууль дээр бол тодорхой тусгаагүй байгаа. Хөрөнгө оруулалтынхаа хуулиудаар ингээд тусгаадаад явна гэж ингэж тооцож байгаа. Улсын Их Хурал дээр ирчихсэн байгаа, маргаантай байгаа. Энэ маргаан энэ тэр нь гаргаад ингээд хийгдээд явах байх. Энэ бол юу гэхээр та бид нарын ярьдаг энэ баялгийн менежментээ зөв хийх энэ хүрээнд цөөхөн хэдэн хүмүүсийн карманд ордгийг ард иргэдийн карманд орёе гэдэг энэ санаа бол Засгийн газраас орж ирсэн санаа. Энэ концепцыг бол бид нар ерөөсөө эвдээгүй юм аа Доржханд гишүүн ээ. Энэ бол анхдагч ингээд гарч байгаа хууль учраас бүгдийг нь хамруулаад бүгдийг нь ингэх боломж бол алга. Шаардлагатай бол Засгийн газар бол өөр дээрээ орон тоо нэмэхгүйгээр Засгийн газрын түвшинд мэргэжлийн багаа ажиллуулж болно гэж байгаа. Тусад нь тэнд аваачиж мэргэжлийн хүнийг бол маш сайн тооцож байж ингэж хийхгүй бол болохгүй байгааг нь ингэж тооцсон юм Засгийн газраас. Тийм учраас Засаг.../минут дуусав/*

Г.Занданишатар: *Ажлын хэсэг дээрээ ярьцаагаарай. Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.*

Г.Дамдинням: *Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл нэлээн удаан яригдаж байж орж ирж байгаад их баяртай байгаа. Ер нь энэ баялгийн менежмент бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөс хойш бол нэлээн сайн хийгдэж байна. Баялгийнхаа үр өгөөжийг ард иргэддээ хүртээнэ гээд бид нар маш их олон жил ярилаа. Хамгийн наад захын жишээ бол энэ уул уурхайн бирж байна. Уул уурхайн бирж гаргаснаар одоо өнөөдрийн байдлаар бид нар 5,2 тэрбум долларын валютын*

нөөцтэй болчихсон. Баялгийн үнэ дэлхий дахинд өсчихсөн байгаа үед бид нар яг л олны нүдэн дээр нээлттэй өрсөлдүүлээд, ингээд зардаг нэг ийм хуримтлалаа үүсгэж чаддаг, ард иргэддээ хувьцаагаа өгч чаддаг ийм байдал руу орж байгаа юм.

Дараагийн хамгийн том хуулийн өөрчлөлт одоо энэ манай Үндсэн хуулийн өөрчлөлт, тэгээд сүүлийн энэ баялгийн менежмент ард иргэдийнхээ гэр лүү, хөргөгч рүү, гал тогоонд, нь дансанд нь мөнгө оруулах хууль бол энэ Үндэсний баялгийн хууль орж ирж байгаа юм. Баялгийн сангийн тухай хууль. Энэ дээр нэг хамгийн сайн үзэл санаа бол энэ Үндэсний баялгийн сангийн зохион байгуулалт, бүх одоо шийдвэрийг Улсын Их Хурал дээр хэлэлцэнэ гэдэг энэ зохицуулалт бол ерөөсөө л бидний амин сүнс нь юм байгаа юм. Хүссэн, хүсээгүй ард түмнээс төлөөлж энэ парламентад сонгогдож байгаа байдалтай энэ ардчилсан улсын амин сүнс дээр бид нар өөрсдийнхөө баялгийг эндээ нээлттэй, нээлттэй микрофонтой яг ингээд ярина. Энэ хамгийн зөв юм байгаа юм. Энэ байхгүй байсны үр дүн юу болсон бэ гэхээр “Эрдэнэс Тавантолгой” тэр нүүрс тойрсон хулгай улсын төсвөөсөө том хөрөнгө оруулалтыг хэн юу хийж байгаа нь мэдэгдэхгүй хийдэг ийм л байсан. Энд бид нар 76 Улсын Их Хурлын гишүүн 200 тэрбум төгрөгийн л хөрөнгө оруулалтыг жилдээ хуваарилах гээд л улсын төсвийн шинэ хөрөнгө оруулалт гээд яриад явж байдаг. Тэнд 1 их наядын хөрөнгө оруулалтыг хэдхэн хүн ард түмний мандат байхгүй хүмүүс хаалттай, нууцтайгаар хэрэглээд, хулгай хийгээд идэж ууж байсныг бид нар нүүрсний хулгайгаар харцагасан. Тэгэхээр энэ Их Хурлаар орж ирж хэлэлцэгддэг болсон энэ заалт бол маш авууштай, сайн заалт байгаа юм.

Зүгээр одоо ажлын хэсгийнхнээс 1 асуулт байна. Энэ ил тод байдлыг нь Их Хурлаар орж ирэхээс гадна одоо энэ улсын төсөв, тэгээд л энэ төсөв, хөрөнгө оруулалтыг ойлгож унидаг ард иргэд бас

байгаа байх. Тэгэхдээ массаараа бол яг бүрэн хэмжээнд ойлгож байгаа нь хэд юм бол мэдэхгүй байна. Тэгэхээр яг ард иргэдэд, хүн нэг бүрд энэ баялгийн сангийн менежментийн ил тод байдлыг яаж хангах юм. Их Хурлын гишүүд чуулган дээрээ ярих нь байна. Тэрнээс өөрөөр ер нь яаж хүн болгонд хүргэх юм. Норвегууд бол хүн болгон аппликэйшнтэй байгаа. Баялгийн сангийнхаа аппликэйшнтэй байгаа. Ямар үйлдлүүд хийж байгааг нь өдөр тутам мэдээллээр аваад явж байгаа. Энэ нь бол өөрөө хуультай. Тэгэхээр ард иргэдийгээ соён гэгээрүүлэх, энэ хувьцаагаа ашиглах хөрөнгө оруулалт гэж юу байдаг энэ баялгийн сангийн менежмент хаана явж байгааг нь заадаг, сургадаг энэ ажлыг энэ хуульдаа ер нь та нар тусгасан уу. Ил тод байдлынх нь талаар нэг хэлээд өгөөч.

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Манай Дамдинням гишүүн бас уул уурхайн чиглэлээр судалгаа хийдэг хүний хувьд бас чухал чухал асуудлуудыг хөндөж тавилаа. Ер нь Монгол Улсын хөгжлийн гарц бол баялгийн менежментээ л зөв хийх асуудал байгаа шүү дээ. Үүний нэг тод жишээ нь бол “Эрдэнэс Монгол” дээр “Эрдэнэс Монгол” компани, “Эрдэнэс Тавантолгой” компани. Энэ дээр БЭТ томилоод өнгөрсөн жилийн хугацаанд тэр хулгайг дараад, тэгээд дээрээс нь тэр оффтейк гэрээгээ дараад 2022 онд 1,2 их наяд, 2023 онд 3,2 их наяд. Ингээд 4,5 их наяд төгрөгийн ашигтай ажиллаад, Монголын ард түмэнд тэр хишгийг нь тараалаа шүү дээ. Тэгээд энэ юу харуулж байна гэхээр баялгийн менежментээ зөв хийж чадах юм бол Монголын ард түмэн ядуурлаас гарах ийм их өргөн боломж байна гэж. Яагаад өнөөдөр ард түмэнд ингээж өгөх гээд байна гэхээр ард иргэдийн маань 28 хувь нь ядуурчихсан байгаа. Дээр нь 15 орчим хувь нь ядуурах магадлалтай болчихсон. Ийм учраас бол энэ баялгийн энэ менежментийг зөв хийж, сангаа үүсгэж,

ард иргэдийнхээ амьдралыг дээшлүүлэх, Монгол Улсаа хөгжүүлэх, тодорхой ирээдүй болон ирээдүйдээ тодорхой хуримтлалтай болох ийм зарчмаар ингээж явж байгаа гэдгийг хэлье.

Хүн болгон баялгийн аппликэйшнтай болно. Сая Дамдинням гишүүний хэлж байгаа данс нээнэ. Тэгэхээр зэрэг дансны мэдээллүүд нь бүгд ороод ирнэ. Тэгээд ер нь энэ аппликэйшныг бүх ард түмэнд мэдээлж байдаг. Энэ хуульд заачихсан байгаа л даа. Энэ баялгийн сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлж байна гэж. Төрөлжсөн сангийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас гарсан шийдвэрийг албан ёсоор нийтэлснээс хойш ажлын 10 хоногийн дотор ард түмэнд мэдээлнэ. Ийм шийдвэр гарлаа. Төрөлжсөн сангийн болон санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайлан болон хөндлөнгийн аудитын дүгнэлт гарснаас хойш 10 хоногийн дотор ард түмэнд бас мэдээлнэ. Төрөлжсөн сангуудын удирдлага болон сангийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн дагуу тухайн шийдвэр гаргасан сард нь олон нийтэд мэдээллийг нэгтгэн тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасны дагуу шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлж байна гэсэн заалт байж байгаа. Тэгээд төрөлжсөн сангуудад жилийн эцсийн тайланд төрийн аудит хийнэ. Төрийн аудитын тайланг бас ард түмэнд ил тод мэдээлнэ гэсэн ийм заалтууд явж байгаа юм аа.

Г.Занданишатар: Одоо Ням-Осорын Учрал гишүүн асуулт асууна.

Н.Учрал: Энэ уул уурхай салбарын ил тод байдлыг хангуулж, Засгийн газрын авлигатай тэмцэж байгаа бодлого бол энэ далд эдийн засгийг бий болгосны үр дүн бас амьдрал ахуйд мэдрэгдэж, цалин хөлс бас нэмэгдлээ. Тэгэхээр энэ дээр уул уурхай салбарын ил

тод байдлыг хангуулахад өнгөрсөн жил авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, тэр уул уурхайн салбарын нөгөө биржийг цахимжуулсан гээд ажлууд бол бас үр дүнгээ өгсөн. Одоо сая тэр “5Ш” ажиллагааны хүрээнд энэ shilen.gov.mn дээр орохоор хиймэл оюун ухаан дээр чат ажиллаж байгаа. Энэ аймагт аль компани хэдэн лиценз эзэмшиж байгаа вэ гэдгийг шууд түс тас хариулж байгаа юм. Иргэд shilen.gov.mn гээд ороод үзвэл хиймэл оюун ухаан дээр суурилсан чат ажиллаж байна. Тэр нь салбарын ил тод байдалд хяналт тавих бололцоог иргэдэд олгосон. 2020 онд Занданшатар дарга ажлын хэсэг байгуулаад, тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Баттөмөр гишүүн бид бол хамтарч ажилласан. Үүний үр дүнд хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг өргөн барьсан. Одоо бас хав дарчихлаа. Хэн нэгэн хүн. Одоо энэ хуулийг оруулмаар байгаа юм.

Тэгээд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл хийгдсэн. Энэ нийгмийн даатгалын багц хуулиар хуваарилалтын тогтолцооноос хуримтлал суурьтай болгох алхам хийгдсэн байхгүй юу. Нэг ёсондоо НДШ төлж байгаа 17 хувийн 2 хувийг хуримтлал суурьтай болгосон. Монгол Улс түүхэндээ анх удаа. Энэ 2 хувийн хуримтлал гэдэг бол өөрөө хөндлөнгийн менежментийн компани удирдаад, дээрээс нь хэрвээ тэр 2 хувийг мөнгөжүүлж чадах юм бол түүнийг санхүүгийн хэрэгсэлд зарцуулах ийм боломжийг нээсэн шиг энэ Үндэсний баялгийн сангийн хууль дээр ч гэсэн тэр төрөлжсөн сан дотор байгаа хуримтлалын санг өөрөө санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах бололцоог эрх зүйн боломжоор нь нээчихсэн. Гэтэл яагаад өнөөдөр энэ 2 хувийн хуримтлал дээр тэр хуримтлалын сантай нь энэ нийгмийн даатгалын санг энэ хуулиар холбож өгөхгүй байгаа юм бэ гэдгийг л би байнга яриад байгаа юм. Тэгээд тэр хуримтлалын сан чинь өөрөө тэр орон сууцад үнэхээр зарцуулах гээд байгаа бол, иргэд үнэхээр өөрөө нэрийн данстай болох гээд байгаа бол яагаад өнөөдөр энэ дээр энэ хуримтлал суурьтай тэр 2

хувийг холбож болохгүй байгаа юм бэ. Энэ чинь нэг ёсондоо яг л адилхан л тэтгэврийн л сан шүү дээ. Тэгэхээр Үндэсний баялгийн сан бол тэтгэврийн сантай заавал уялдах ёстой. Тэгж байж ард түмний амьжиргаанд шууд нөлөөлнө. Тэгж байж тэр орон сууцтай болно. Тэгж байж тэр хувьцааныхаа ноогдол ашгийг хүртдэг болно л гэдэг асуудлыг л яриад байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг яагаад шийдвэрлэхгүй байгаа юм бэ.

Үндэсний баялгийн сан дотор орж байгаа Энэ хөгжлийн сан. Хөгжлийн сангийн санхүүжүүлэх зорилтот чиглэлүүд хуулиар тодорхой болбол сайн байна. Ялангуяа сая Монгол Ардын нам Үндэсний аудитын байгууллагад мөрийн хөтөлбөр хүргүүлэхдээ Баялгийн сангийн 1-ээс доошгүй хувийг инновац технологийн салбарт зарцуулна гэдэг үгийг бүр мөрийн хөтөлбөрт тусгасан. Аудитын байгууллагаас энэ мөрийн хөтөлбөрийн зорилтыг зөвшөөрсөн байна лээ. Тэгвэл өнөөдрийн энэ Үндэсний баялгийн сангийнхаа хууль дээр Үндэсний баялгийн сангийн 1-ээс доошгүй хувийг, Хөгжлийн сангийн 1-ээс доошгүй хувийг инновац технологийн салбарт зарцуулна буюу ирээдүйдээ зарцуулна гэдэг үгийг л хийж өгөхгүй бол дахиад л иргэдийн зүгээс энэ чинь нөгөө хулгай дээрэмд бас баригдах вий гэдэг дээр санаа зовж байна шүү дээ. Тэгээд 1 ийм заалт хийгээд өгчхөөч л гэж хүсмээр байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулна.

Б.Баттөмөр: Хуримтлалын санг нь манай ажлын хэсгийн гишүүд хариулаадхаарай. Тэр тэтгэвэртээ холбох яагаад ороогүй байна. Энэ яах вэ, зүгээр Засгийн газраас орж ирээгүй л дээ. Тэгээд ер нь өөрөөр хэлбэл тэтгэврийн сан маань өөрөө их эмзэг байгаа тийм ээ. Ер нь бол цаашидаа тэтгэврийн сан дээрээ тодорхой шинэчлэлүүдийг хийх, тэр хуримтлагдаж байгаа мөнгийг тодорхой хөдөлгөөнд

оруулах, өсгөх, үржүүлэх, тэгээд өөр ямар эх үүсвэрүүд байна ингэхгүй бол тодорхой хугацааны дараа манай тэтгэврийн сан хүнд байдалд орж болзошгүй болчихсон байгаа. Тэгээд Засгийн газраас энэ асуудлыг оруулж ирээгүй учраас ингээд явж байгаа юм гэдгийг би Учрал гишүүнд тайлбарлая.

Хөгжлийн сангийн тэр ямар хөгжилд ямар арга хэмжээнд хөрөнгө оруулах вэ гэдгийг бол нөгөө Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн дагуу бид хийсэн шүү дээ Учрал гишүүн бид нар хамт хийсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар жил болгон хөгжлийн төлөвлөгөөгөө батална. Одоо ингээд миний ойлгож байгаагаар бол Хөгжлийн яам санал асуулга хийгээд явж байгаа. 2024 оныхыг нь бид нар баталсан шүү дээ. Тэгэхдээ анхных байсан учраас тэр төсөвтэйгөө уялдаагүй байсан. Энэ жилийнх бол төсөвтэйгөө нэлээн уялдаж орж ирэх байх гэж ингэж бодож байгаа. Тэр хөгжлийн сандаа одоо бүгдээрээ тэр инновац, технологи, шинэ технологи, хиймэл оюун ухаан энэ чиглэл рүүгээ би санал нэг байна Учрал гишүүнтэй. Ерөөсөө энэ эдийн засгийн өсөлтийг чинь бий болгодог, шинжлэх ухаан технологийн ололтыг амьдралд нэвтрүүлэх тодорхой тийм эдийн засгийн өсөлтийг чинь хаана бий болж байна. Оюун ухааны бизнес гэж байна шүү дээ. Тийм учраас миний ойлгож байгаагаар бол энэ Хөгжлийн сангийн жилд 300 орчим тэрбум төгрөг төвлөрдөг шүү дээ нөгөө тогтворжуулалтын сан маань. Тэрнээс илүү гарсных нь 50 хувь гэж байгаа юм. Тэгээд энэ мөнгөөр бол тодорхой одоо бол яг хуримтлагдаагүй байна. Цаашидаа бол хуримтлагдана. Тэр нөгөө Тогтворжуулалтын хуулийн 17.13 билүү тэрүүгээр чинь заачихсан байж байгаа шүү дээ. Нөгөө хөрвөх чадвартай "А"-ээс дээш тэр үнэт цаасанд хөрөнгө оруулна, хөрвөх чадвартай байна гээд. Өөрөөр хэлбэл энэ хөгжлийн сангийн мөнгө өсөж, үржих тэр эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгчихсөн байгаа. Тийм учраас өөрийн чинь одоо ярьж байгаа

энийг бол энэ 2025 оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлбэ. Би бас Их Хурлын гишүүний хувьд энийг дэмжиж дэмжиж байна. Эдийн засгийн байнгын хороогоор орж ирнэ. Ямар ч байсан инновац технологийн энэ чиглэлд тодорхой мөнгийг зарах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн тодруулж асууя.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хуулийг боловсруулахад нэлээдгүй олон орны судалгаануудыг хийсэн байна лээ. Тэгээд ер нь Баялгийн сангийн хууль дотор бол энэ заалт бол заавал байдаг юм байна лээ. Үндэсний баялгийн сангийн 1-ээс доошгүй хувийг инновац, технологийн салбарт зарцуулна гэдэг. Тэгэхгүй бол жил болгоны хөгжлийн бодлого батлаад, тэгээд түүгээрээ шийдээд явна гэж юу байх вэ дээ. Тэр бол бас тийм үр дүнд хүрэхгүй. Тэгэхээр Их Хурлын дарга бас өөрөө үүнийг их сайн дэмждэг. Тийм учраас бас чиглэл өгөөд энэ Баялгийн сангийнхаа хууль дээр 1 ийм заалт оруулаад өгөөч. Ирээдүйд хэрэгтэй юм даа гэж л одоо хэлж байгаа юм. Тийм учраас 1 ийм заалт оруулмаар байна. Тэр нийгмийн даатгалын сантай холбогдуулаад бас ажлын хэсэг хариулчихвал тодруулчихмаар байна.

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт 4 номер.

С.Наранцогт: Учрал сайдын асуултад тодруулж хариулъя. 1 дүгээрт бол яах вэ хэдүүлээ энийг Засгийн газар дээр 3, 4 ярьсан. Тэгээд концепцоо эцэслээд оруулаад ирсэн шүү дээ. Тэгээд сая бол Баттөмөр гишүүн үндсэндээ хариулчихсан. Юу гэхээр ер нь ингээд баялгаас Үндсэн хуулийнхаа агуулгын хүрээнд жосохон хуримтлал үүсгэх ийм ингээд сан үүсгэх гээд энэ сангаа бол тэр хөгжилтэй, нийгмийн даатгалын сан нь өөрөө үр ашигтай ажилладаг, өөрөө өөрийгөө аваад явдаг орнуудад бол энийгээ уясан ийм туршилага байгаад

байгаа юм. Яг манай нөхцөлд бол манай нийгмийн даатгалын сан бол үндсэн реформоо хийгээгүй тохиолдолд юуг ч уяад энэ бол сэхэхээргүй байдалтай байгаа. Төсвөө татаж унагах түвшинд оччихсон. Тэгээд ийм юм руу нь аваачаад энэ баялгаас орох орлогоо иргэддээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ Баялгийн сангийн хуулийг бол сая бас орон нутгаар явлаа. Иргэд олон нийт маш их сонирхож, анхаарч байгаа. Үнэхээр бас энэ өнгөрсөн хугацаанд Монгол Улсын томоохон ордууд “Эрдэнэс Тавантолгой” гэхэд л нэг гаднын компанид 100 жилээр явчих шахсан. “Оюу толгой” гэхэд ашигт малтмалаас ашгаа хүртээгүй байхдаа асар их хэмжээнд өрөнд орчихсон. “Эрдэнэт”-ийн үйлдвэр гэхэд түрж үхэж байгаа үнээтэй зүйрлэгдээд бас алдчих шахсан гээд ингээд ер нь ордуудаасаа ашиг хүртэх магадлал их л бүрхэг байсан ийм цаг үе ард үлдэж. Харин одоо Монголчууд энэ “Эрдэнэс Тавантолгой” гэдэг уурхайг бүгд мэддэг болж. Хувьцаанаасаа хувь хүртэж эхэлсэн энэ цаг үед одоо бас Баялгийн сангийн хууль орж ирж байгаад их баяртай байгаа. Гэхдээ баялгийн сангийн хууль дээр тэр стратегийн орд гэж 16 орд байдгаас өнөөдөр яг өөрсдөө мэдээд зарцуулах нь бол 7 байгаа юм байна гэж бас би ойлгосон. Тэгэхээр энэ хууль хэлэлцэгдэж байгаа энэ цаг үед ер нь бусад 9 орд нь ямархуу шалтгаанаар, яагаад гадна, дотнын компани, аж ахуйн нэгжүүдэд очсон юм бэ гэдгийг бас ард түмэнд нэлээн сайн мэдээлэл өгмөөр санагдаж байгаа юм. “Эрдэнэс Тавантолгой” талаар огт мэддэггүй байсан шүү дээ иргэд. Мэддэггүйгээсээ болоод өнөөдөр хувьцаагаа хүртэл зарчхаад, эргээд хувьцаагаа худалдаж авмаар байна гэдэг хүсэлтүүдийг ард иргэд маш ихээр ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь Монголын ард түмний газрын доорх баялаг ямархуу замаар яаж

яваад 8, 9-өөрөө өөр газар оччихсон юм бэ гэдгийг 1 дүгээрт би тодруулмаар. Энийг тэр хяналтын сонсгол дээр Цэрэнпунцаг гишүүн ахалж байгаа юм байна лээ. Хамгийн түрүүнд бас гаргаж ирж ярих ийм шаардлага байна гэж харж байгаа юм.

Одоо харин энэ Баялгийн сангийн хууль дээ, Ашигт малтмалын хууль дээр ажлын хэсгээс орж ирсэн 2 санал байна л даа. 5.4, 5.5 дээр. Тэгээд 5.4 дээр бол ер нь зүгээр улсын төсвийн хөрөнгөөр хайгуулаа хийгээд нөөцийг нь тогтоочихсон ордын 50 хүртэл хувийг төр эзэмшиж болох бөгөөд тэгээд үүний ард болохгүй байсан ч болох тийм утга санаа бас давхар агуулагдаад байгаа юм. Төрийн хувь хэмжээ эзэмшлийг нь тогтоож болно гэсэн ийм нэг болно гэдгийн ард бас хууль зүйн юугаараа бас болохгүй ч байж болно. 50 хүртэл хувь гэдэг чинь 1, 2 хувийг ч тогтоочхож болно. Тэгэхээр ялангуяа улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоочихсон ордуудын 50 хүртэл хувийг төр үнэ төлбөргүй эзэмшинэ гэсэн ийм шулуун, 2 салаа утгагүй оруулчхаж болохгүй юу. 1 дүгээрт.

5.5 дээр бол улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын 34 хувь хүртэл тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болно гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь энэ Улсын Их Хурлаас гарах хууль бол тийм салаа утгагүй, тодорхой байвал яасан юм бэ. 34 хувь гэдэг чинь магадгүй 3.4 хувийг нь ч ашиглах бололцоог энэ хуулиар нээгээд өгчхөж байгаа юм биш үү. Яахаараа байгалийн баялаг энэ Монголын ард түмний энэ улс орны байгалийн баялгийнхаа 34 хүртэл хувь гэдэг энэ тоог ер нь заавал тавих ёстой юм бэ. Хүртэл гэдэг энэ үг чинь бол хууль зүйн үр дагаврын хувьд бол нэлээн алдаатай үг юм биш үү. Ажлын хэсэг энэ дээр юу гэж үзэж байгаа юм бэ. Миний санал бол 50 хувийг гээд ингээд заагаад өгчихмөөр. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулаа хийснийг нь. Хувийн хөрөнгөөр

хийснийг нь 34 хувь гээд ингээд бүүр тодорхой заагаад өгч болдоггүй юм уу. Тэгээд энэ дээр би ажлын хэсгээс асууя гэж бодож байна.

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Баттөмөр: Би нэг хэсгийг нь хариулъя даа. Манай нөхдүүд бас үргэлжлүүлээд хариулаарай. Идэрбат гишүүний хэлж байгаа энэ асуудал бол яах аргагүй л чухал асуудал л даа. 2007 оны Улсын Их Хурлын 27 дугаар тогтоолоор стратегийн ордод 16 орд газрыг л хамруулсугай гээд 1 дүгээр хавсралтаар нь баталчихсан байгаа. Яг энэ байдлаар энэ 16 ордоос өнөөдрийн байдлаар 7 нь төрийн мэдэлд байна гэж. Тийм ээ. Одоо 100 хувь, 50 хувь гээд ингээд байна л даа. Тэгээд үлдсэн нь дандаа аж ахуйн нэгж рүү орчихсон. Ийм л байдалтай байгаа. Энэ тогтоол бол хэрэгжээгүй. 2 дахь заалт нь хавсралт нь бол энэ стратегийн ордууд дотор дахиад 39 орд байгаа юм. Энэ 2 дугаар хавсралтад заасан 39 ордыг стратегийн ордод хамруулах эсэх талаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлж байхыг тухайн үеийн Засгийн газарт даалгачихсан бас хэрэгжилт байхгүй. Тэгэхээр энэ 2 тогтоолын 2 хавсралтыг энэ хаврын чуулганд багтааж Улсын Их Хуралд танилцуул гэсэн чиглэлийг Засгийн газарт өгч байгаа юм. Ингээж хариулъя 1 дүгээрт.

2 дугаарт энэ 5.4, 5.5 гэдэг заалт бол цоо шинэ заалт. Ажлын хэсгээс оруулсан юм. Цоо шинэ заалт. Засгийн газраас оруулж ирсэн хуулийн төсөлд энэ заалт бол байхгүй. Өнөөдөр Менделеевийн үелэх систем Монголд тэр чигээрээ байна. Харамсалтай нь юу вэ гэхээр лиценз хэлбэрээр төлбөрийн чадваргүй ийм хүмүүст одоо очоод, тэр нь наймааны хэрэгсэл болоод дандаа гаднын компаниуд худалдчихсан ийм тохиолдлууд бол асар их байгаа. Тоо

баримтууд нь байгаа шүү. Энийг цаг бага учраас бүгдийг хэлэх боломж алга.

Тийм учраас одоо нэгэнт стратегийн ордод авчихсан энэ 16 ордыгоо 50 хүртэл хувийг одоо 100 хувь авчихсан тэр хувийн компаниуд авчихсан байна шүү дээ. Үүний 50 хүртэл хувийг нь авъя л гэсэн ийм санаа. Ингэсэн юм. Одоо ажлын хэсэгтээ яриад авч болно гэдэг томъёоллоор оруулъя гэж олонх нь яриад ингэж авсан юм. Уг нь бол авна гээд оруулчихад бас болохгүй юм байхгүй. Яагаад гэхээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1 дүгээрт, 2 дугаарт энэ баялаг чинь бол Үндсэн хуулиараа ард түмний мэдэлд байдаг баялаг шүү дээ. Тэгээд төвөгтэй байдал үүсгэчихсэн. Өнгөрсөн 30 жилийн энэ алдаа энэ дээр ингээд үүссэн байгаа байхгүй юу. Тэгээд энийг л засаж залруулъя гэдэг байдлаар энэ 2 заалтыг ажлын хэсгээс санаачилж оруулж ирсэн юм шүү. Мөн энэ 2007 оны 27 дугаар тогтоолын биелэлтийг хаврын чуулганд багтааж танилцуул гэж. Энэ дээр бас янз янзын санаанууд гарч ирж байна лээ. Тэгээд бид нар бол олонхоороо энийг дэмжээд ийм заалтууд явсан. Тэр болох бөгөөд гэдэг юмнуудыг манай мэргэжлийн хүмүүс нь хариулъя. Яг ямар утгаар явсан болсон явдлуудыг ярь л даа. Тийм ээ. Наранцогт захирал энэ оруулсан юугаа тайлбарлая.../минут дуусав/

Г.Занданишатар: Санжаагийн Наранцогт дарга хариулна. 4 номер.

С.Наранцогт: Саяын тэр Ашигт малтмалын хуульд оруулсан 2 заалтын гол агуулга нь ийм байгаа юм. Идэрбат гишүүнд тодруулж хариулахад. Өмнө байгаа хуулийн заалт нь болохоор төр үнэгүй авах боломжгүй байсан юм. Мэдээж энэ ордууд бол тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардана. Заримд нь 34 хувиа шууд үнэгүй авчихаар тийм хөрөнгө оруулалт бага шаардахаар сайн ордууд байхыг бол үгүйсгэхгүй. Тэгэхээр энэ тэгж авах бололцоо байна гэсэн үг бидэнд өмнө нь бол байгаагүй. 50 хувь хүртэлх нь ч гэсэн авах боломжгүй

заавал төр хөрөнгөө гаргах ийм заалттай байсан учраас одоо энэ компаниуд бас яриад байгаа шүү дээ. Төр ингээд мөнгөө гарга гэсэн чинь мөнгөө гаргаагүй ээ. Тийм учраас бид нар аваад ингээд ашиглаад байгаа юм гэж. Одоо энэ бид нарын оруулж ирж байгаа өөрчлөлтөөр төр 34 хүртэл үнэгүй авч болно гэдэг нь бид нар бас хөрөнгө оруулалт оруулах зай үлдээхгүй бол зарим энэ ордууд чинь өөрөө нөхцөл байдлаасаа маш их хөрөнгө оруулалт шаардах, үр ашиг нь бас тийм сайнгүй байхаар ордууд бас гарч ирэх магадлалтай шүү дээ. Тэр үед хөрөнгө оруулагчтайгаа л тохирох юм. Та хэд хөрөнгөө гарга. Бид нар тэгэхдээ үнэгүй тодорхой хувийг нь авна. Ордын эдийн засгийн нөхцөл байдлыг нь тооцож үзээд бид нар санхүүгийн модельд оруулаад сайн орд байх юм бол бид нар 34 хувиа, 50 хувиа үнэгүй аваад явна гэдэг ийм л зүйл хийнэ.

Тэгэхээр энэ бол их сайн заалт орж ирж байгаа гэсэн үг. Бид нар үнэгүй эзэмшихийгээ хаачихсан байснаа одоо бол бид нар нээгээд төр өөрөө үнэгүй эзэмших бололцоотой болж байна л гэсэн үг. Ийм зарчмын ялгаатай зүйл байгаа юм аа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Тэгэхээр ажлын хэсгийн ахлагчийн хувьд бол энэ 50 хүртэлх хувь болно энэ тэр гэсэн энэ салаа утгатай, яаж ч мушигж болох ийм зүйлүүдээ бол танайхны оруулж ирж байгаа л энэ санал гэж ингэж тайлбарлаж байна шүү дээ. Таны хэлж байгаагаар бол энэ чинь 16, дээр нь дахиад 39 орд нийт 55 ордын асуудлыг бас ярих хууль чинь энэ болох гээд байна шүү дээ. Тэгэхээр та ганц нэг орд дээр ийм нөхцөл байдал үүсэж магадгүй гэж хэлээд өнөөдөр энийг тайлбарлаад сууж байна гэдэг чинь бас буруу. Би бол буруу гэж хэлэх гээд байна. Бид наад хувилбараар чинь яваад олон зүйлүүдээ алдаад, энэ бас цоо шинэ хууль ч бас биш

шүү дээ. Энэ чинь хувьцаа гэсэн үг л орж ирсэн юм байна лээ шүү дээ. Энэ Ашигт малтмалын хууль дээр 2006 оны нэмэлтээр орж ирсэн юм байна лээ шүү дээ. Тэгээд тэрнээс хойш яг энэ хуулийн заалтыг ер нь ашиглаад энэ ашигт малтмалын салбар дээр нь төрийн оролцоо 50 хувиа, тэгвэл 50 хүртэл хувиа авчихсан юмнууд байгаа юм уу, байхгүй юм уу. Тэгэхээр ер нь бол төрийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн хариулна.

Б.Баттөмөр: Өнөөдрийг хүртэл газар доорх баялаг үнэ нь 0 гэдэг ийм юм яригддаг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийчихсэн их олон орд байдаг. Бүгд хувийн хэвшилд шилжээд оччихсон. Энийг л бид зориглож оруулж ирж байгаа юм даа. Та бол хууль санаачлах эрхтэй. Зарчмын зөрүүтэй санал оруулах эрхтэй. 50 хүртэл байна гэдэг саналыг та бас оруулж болно шүү дээ. Тийм ээ. Энийг судалгааны үндсэн дээр олон талаас нь ярьж байгаад энэ асуудлыг анх удаа ингэж хөндөж оруулж ирж байгаа юм шүү. Түүнээс биш тэдэнд нэг их айхтар тал засаад яваад байгаа юм алга. Бидний хувьд бол юу вэ гэхээр газрын баялаг ард түмний мэдэлд байна. Нэгэнт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийгдсэн бол тодорхой хувийг төр ард түмэн эзэмших ёстой гэдэг дээр бол санал нэг байгаа. Энийг бол олон талаас нь энэ ажлын хэсэгтэй ярьсан л даа. Тэгээд маргаантай асуудлууд их байдаг юм байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт 4 номер.

С.Наранцогт: Би нөгөө ганц нэг ордын тухай яриагүй л дээ. Бүх л ирээдүйд үүсэх, одоо тэр жагсаалтад байгаа ордуудад бас тогтоолоор үүрэг өгөөд, ахиад энэ ордуудын нөхцөл байдлыг Их Хуралд танилцуулахаар ийм тогтоолын заалт явж байгаа. Яг хатуу 34, яг хатуу 50 гэж заах юм бол хөрөнгө

оруулалт орж ирэх бололцоо маш их хаагдана гэсэн үг. Бид нар энэ ордын нөхцөл байдал дээр л үндэслэж үнэхээр түрүүний хэлдэг шиг сайн орд хөрөнгө оруулалт бага шаардах орд байвал төр 34 хувиа, 50 хувиа асуудалгүй эзэмших боломж үүгээр үнэгүй гэдэг үгийг нь бид нар байхгүй байсан үгийг нь нэмж оруулсан. Яагаад гэвэл энэ нь тодорхой бус байна гэж хүмүүс үзээд, өмнө нь бол хуулийн заалт бол болно гэсэн үг байгаа л даа. Гэхдээ тодорхой бус байна гэж үзээд ингээд төр мөнгө гаргаагүй гэдгээр авсан учраас одоо бид нар үнэгүй төр авах боломжийг нь нээж өгч байгаа юм. Энэ нь хамгийн чухал заалт.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн асуулт асууна.

Х.Болорчулуун: Баялгийн сангийн тухай хууль орж ирж байна. Ерөнхийд нь бол дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ баялгийн тухай хууль сан бүрдүүлэх, нөөц бүрдүүлэх, урьд өмнө Ирээдүйн өв сангийн тухай хууль гээд л гарч байсан. Ирээдүйн өв сангийнхаа хуулийн тэр нөөцөлсөн хэдэн төгрөгөөс төсвийн цоорхойг нөхөөд л хаячхаж байсан. Ингэж энэ хууль дээрээ төсвийн цоорхойг нөхөхгүй хаалтыг хэрхэн хийж өгсөн бэ гэдгийг бас 1 дүгээрт асууя.

Ер нь бид нар Баялгийн сангийн хууль гаргаад, хуулийн хэрэгжилтийг хангаж энэ сангаа авч явах менежмент маш сайн байх ёстой. 2 дугаарт хяналт маш сайн байх ёстой. Энэ тал дээр хуульдаа хэрхэн оруулсан бэ гэдгийг асууя. Ер нь баялгийн сангийн сав бол дүүрэн байх ёстой байхгүй юу. Тэрнээс нэг хууль гаргаад орхичих биш. Хэн нэгний олз болгочих биш. Одоо хамгийн мундаг баялгийн сан бүрдүүлдэг улс Норвеги. Гишүүд бүгд мэдэж байгаа. 6, 7 жилийн өмнө 900 гаруй тэрбум байсан. Өнөөдөр 1,6 триллион болчихсон байна. Норвегийн баялгийн сан нэрээ өөрчлөөд тэтгэврийн сан болгосон. Тэгэхээр жилд Норвегийн тэтгэврийн сан 100 гаруй тэрбум доллароор өсдөг гэж байгаа байгаа дунджаар. Ингэж өсгөх боломж

энэ хуульдаа хэрхэн зааж өгсөн бэ. Энэ талаар бас асууя. Өсөхөөсөө өмнө бид нар энэ сангаа баян байлгах, дүүрэн байлгах, өөрийн дотоод нөөц боломжоо ашиглаж ажиллах нь хамгийн чухал. Ганцхан Тавантолгойг хулгай худлаас салгаад л ингээд л зөв явуулаад ирэхэд л өнгөрсөн 2023 онд Монгол Улсын төсөв 1,4 их наядын ашигтай ажиллаж байна шүү дээ. Оюутолгой бол зүгээр Монгол Улсын төсвийн 3-хан хувийг бүрдүүлж байна. 6 “Эрдэнэт”-тэй тэнцэх том орд. Бид энэ Оюутолгойн ордоо өшөө цаашаа сайжруулж, зайлшгүй өөрчлөх ёстой. Энэ хулгай луйвар авлигаар байгуулагдсан. Одоо татварын асуудлууд Лондоны шүүх дээр явж байгаа. Энэ дээр хэдэн хүмүүс л нэг дуугардаг, хэлдэг. Тэр хэдэн хүмүүсийн өмч эрх ашиг юм шиг л зарим хүмүүс боддог. Тийм биш ээ, бүгдээрээ дуугарч, нэгдэж энэ “Оюутолгой”-г бол зайлшгүй засах ёстой шүү. Тэрнээс биш ийм дээрмийг хүлээн зөвшөөрчхөөд өрлүүлсэн хонь шиг дуугүй байж хэрхэвч болохгүй гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд эрсдэл энэ баялгийн сангууд дээр гардаг. Эрсдэлийг хэрхэн хааж өгсөн. Энэ талаар хууль дээрээ хэрхэн зохицуулсан бэ. Энийгээ бас хариулж өгөөч ээ гэдгийг хэлэх байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуултад хариулъя.

Б.Баттөмөр: Болорчулуун гишүүний асуултад хариулъя. Ирээдүй өв санг бол 2030 он хүртэл зарцуулахгүй гээд хуульд заагаад явж байгаа. 2025 он байсан. Энийг 2030 болсон. Хуримтлал үүсгэе гэж. Манай Засгийн газраас оруулж ирсэн саналд бол 2030 он гэхэд 6,8 их наяд төгрөгтэй болно гэж тооцсон байна лээ. Өнөөдөр бол ирээдүй өв сан бол 3,3 их наяд буюу 1 тэрбум доллартой тэнцэх хэмжээний. 2024 онд дахиад 1 их наяд. Ингээд цаашаа нэмэгдэхэд бол энэ бол 8, 9 орчим их наяд орчим төгрөгийн хуримтлал бий болно гэж. 3 сан байгаа. 3 сангийн зарцуулалт бол шууд ингээд тэр Хөгжлийн банк шиг

тэгээд өгөөд байна гэж байхгүй. Энийг бол Засгийн газар Улсын Их Хуралд яг зориулалт зориулалтаараа Ирээдүй өв сан төчнөөн төгрөг төвлөрнө. Тэр хөгжлийн санг иймд төвлөрнө. Хуримтлалын санд ийм төвлөрүүлнэ гэж төлөвлөгөөгөө батлуулна. Зарцуулалтууд ялангуяа тэр хөгжлийн сангаас, тэр хуримтлалын сангаас үүсэх тэр зарцуулалтуудыг Засгийн газар оруулж ирж, Улсын Их Хурлаар батлуулна. Тэр батлагдсанаас өөр ямар нэгэн санхүүжилт хийхгүй. Тийм учраас энд бол ямар нэгэн хууль бус зүйл дээр зарцуулах барих энэ бол хаалттай гэж ингэж үзэж болно гэж.

Энэ өсгөх асуудал зүйтэй. Одоо энэ дээр Ирээдүйн өв сан бол мандат гээд байгаа шүү дээ. Тэр мандатынхаа дагуу өсөөд явах боломжтой гэж үзэж байгаа. Харин мандатыг жоохон тийм бас дахиж эргэж үзэх шаардлага бол байна уу гэж би хардаг.

Дараагийн асуудал бол зүгээр хөгжлийн санг бүрдүүлж байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тэр 17.13-д заачихсан байгаа. Тэр нь юу вэ гэхээр 2024 оноос эхлээд “А” зэрэглэлийн үнэлгээтэй тэр хувьцаанд үнэт цаасыг бол худалдаж авна. Мөн дараагийнх нь заалт нь бол тэр хөрвөх чадвартай байна гэсэн заалтууд нь бол байгаа. Тийм учраас энэ 2 сангийн хувьд бол өсөж үржих ийм боломж нь хуулийн хувьд нээлттэй байна гэж. Тэр сая эрсдэлийн талаар Болорчулуун гишүүн маш чухал асуудал асуучихлаа. Ерөөсөө аливаа зүйл бол бүгд эрсдэлтэй байдаг.

Дэлхийн хэмжээнд гэхэд л одоо 456 баялгийн сан, Баялгийн гэж ярьж л даа ер нь сан үүссэн. Өнөөдрийн байдлаар 178 нь ажиллаж байгаа. 178 баялгийн санд бол 8 их наяд доллар цугласан байгаа. Үүний одоо 5,4 их наяд нь тэр нефть, химийн, газрын тос, байгалийн хийгээс олсон байна гэсэн ийм тоо байна. Мэдээж манай баялгийн санд эрсдэл бол байгаа. Хамгийн 1 дүгээрт нь бол юу гэхээр зэрэг энэ баялгийн санг үүсгэсэн

амжилттай явсан Норвег эд нарт гадаад өр их бага байдаг. Манай гадаад өр 33,8 тэрбум доллар байгаа. Үүнээс бол хамгийн том нь ААН-ийн 23,1 тэрбум доллар байгаа. Засгийн газрын өр 7,7 тэрбум доллар байгаа. Тэгэхээр өр багасгах чиглэлээр л одоо бид анхаарах ёстой. Их өртэй байх юм Баялгийн санд эрсдэл учирна гэж үзэж байгаа юм.

2 дугаарт нь бол манайх түүхий эдийн хараат ийм улс. Тийм учраас түүхий эдийн үнэ маш чухал. Түүхий эдийн үнэ, үнийн хэлбэлзэл, түүхий эдийн үнэ буурах юм бол Ирээдүйн өв санд үүсэх бусад газруудад үүсгэх, бусад сангуудад үүсгэх тэр эх үүсвэр бол багасна гэж үзэж байгаа юм.

Дараагийн асуудал энэ гадаад валютын хангалттай нөөцтэй байх ёстой. 5,2 бол тийм их том тоо биш шүү дээ. Тийм учраас нөөцөө бол нэмэгдүүлэх ёстой. Хани бол унахгүй байх ёстой. Монгол төгрөгийн хани. Энэ бол их чухал. Инфляц бол үнэхээр инфляцыг бага түвшинд барих ёстой. Менежмент бол зөв менежмент явах ёстой. Төсвийн алдагдлыг ихэсгэхгүй байх ёстой гэсэн ийм шаардлагуудыг одоо хэрэгжүүлж байж энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхбаярын Батишугар гишүүн асуулт асууна.

Э.Батишугар: Баярлалаа. Байгалийн баялаг ард түмний өмч байх ёстой гэдэг концепт бол маш зөв концепт. Яагаад гэвэл Монгол Улсад заяасан байгалийн баялгийг яг хэн нэг нь бүтээгээгүй. Энэ бол цэвэр байгаль дэлхий Монголчуудад бүгдэд нь л өгсөн. Энэ утгаараа Монголчууд бүгдээрээ өгөөжийг нь хүртэх ёстой. Энэ хамгийн зөв механизм бол байгалийн баялгийн сангаараа дамжуулж Монгол Улсын иргэн бүр хүртэх ёстой юм. Ингэснээр бас дээрээс нь нэмээд нөгөө баялгийн хараал аль эсвэл Голланд өвчнөөс ангижруулна гэсэн үг. Мөн эдийн засгийн өндөр өсөлтийн статистикийн тоог өрхийн хаалгаар

шууд оруулах бололцоо нээгдэж байгаа юм аа.

Энэ өнөөдрийн оруулж ирсэн хуулийг бол би маш зөв ялангуяа Засгийн газар болон боловсруулсан хүмүүс нь бол их юм судалж уншсан гэж харж байна. Яагаад гэвэл бүх дэлхийн хамгийн сайн практик болон жишигүүдийг яг Монгол Улсын одоо хууль тогтоомжид нутагшуулсан байна. Жишээлбэл юу гэж харж байгаа юм. Төрөлжсөн сангууд нь их зөв механизм. Ирээдүйн өв сан бол яг л харахад Норвегийн тэтгэврийн сантай адилхан боловсруулагдсан байна. Хуримтлалын сан нь яг өнөөдөр ярихад Кувейтийн хөрөнгө оруулалтын сан болон Саудын Арабын сантай адилхан концепт байна. Хөгжлийн сан нь нөгөө Темосек болон Катарын хөрөнгө оруулалтын сантай яг адилхан концепт орж ирж байна л даа. Тэгэхээр нэг ёсондоо бол энэ хуулийг баталснаар 1 сумаар 3 туулай буудаж байна гэж ойлгож болно. Энэ хууль батлагдахад бас нийгэм, эдийн засагт эерэг нөлөө нь бол мэдээж том макро түвшинд бол манай эдийн засгийн дархлаа сайжирч дээшилнэ. Зээлдэх зэрэглэл сайжирна. Төгрөгийн хани улам баталгаатай болж бас төгрөг чангарах бололцоог нь нээгдэнэ. Мөн эдийн засгийн хэт халаалтаас ангид байж инфляцыг ч гэсэн нам түвшинд барих бололцоог нь нээгдэх юм. Яах вэ, өсөлтүүдийг нь харахад бас би түрүүн хэлсэн. Энэ Кувейтийн сан, Сингапурын Тамасек болон Катарын сангууд бол сүүлийн 10 жилийн цууд активын өсөлтийг нь харахад бол ийм байгаа юм л даа. Норвегийн сан бол 14,5 хувиар өссөн жил болгон. Катарын сан 19 хувиар жил болгон актив нь нэмэгдсэн. Кувейтийн сан бол 11 хувиар, Темасек Сингапурын сан бол 15 хувиар өссөн гэх мэтчилэн зүйлүүд харагдсан. Тэгэхээр энэ сангуудаа бид нар бас арвижуулаад зөв менежмент хийгээд өсгөвөл бас 15 хувиар ч гэсэн жил болгон өсгөөд явах бололцоо нь бүрэн байгаа. Энэ 15 хувиар жишээлбэл 10 жилээр өсвөл 1 сая төгрөг гэхээр чинь 4 дахин өсөх том бололцоо нь бүрэн хангагдана.

Тэгээд хамгийн чухал зүйл нь би бас асуух гээд байгаа нь юутай холбоотой вэ гэвэл яг энэ сангийн сангийн менежментээ бид нар хийхдээ хүний нөөцөө яаж бэлдэх вэ. Энэ сангийн менежмент ч юм уу яг одоо үндсэн санхүүгийн өндөр шинжээчид болон гадаадад банкнуудад ажилладаг тийм хүмүүс байдаг. Аналистууд гэх мэтчилэн. Тэгээд өөрсдөө өнөөдрөөс эхлээд энэ үндсэндээ гадаад, дотоодод сурсан болон гадаадын том бас хөрөнгө оруулалтын санд ажиллаж байгаа Монголчуудаа эргэж татаад оролцуулах нь бас зүйтэй юм уу гэж харж байгаа юм.

2-т нь эрсдэлийн менежмент гэж бас манай гишүүд асууж байна. Энэ бол маш чухал зүйл. Маш олон сангууд бас дампуурсан байгаа. Тэгэхдээ эрсдэлийн менежментийн тогтолцоогоо ямар байдлаар менежмент хийх вэ гэдгийг нь бас, ямар байдлаар энэ параметрийг нь тодорхойлох вэ гэдгийг нь л бас асуумаар байна л даа. Яагаад гэвэл маш их хэмжээний мөнгө энд нь эргэлдэнэ. Тэр өгөөжийг яг тогтвортой авах нь бас чухал. Мөн Хэйжинг эд нар гэх мэтчилэн маш олон санхүүгийн хэрэгслүүд бид нар хэрэглэж болно л доо. Тэгэхдээ яг үүн дээр суурилчихсан хүний нөөцийн асуудал яригдаад байгаа юм л даа. Энийг асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Манай Батшугар гишүүний сая ярьж байгаа баялгийн сангуудын талаарх мэдээлэлтэй бол санал нэг байна. Ер нь бол санг цаашаа авч явахад бол баялгийн санг нь жинхэнэ утгаар нь ажиллуулахад улс төрчдийн мэдлэг чадвар, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хууль дээдлэх, тэгээд олон түмний дэмжлэг ил тод байдал гэдэг олон зүйлээс шалтгаалах юм байна лээ. Бидний хувьд бол анх удаа, зүгээр Ирээдүй өв санг эс тооцох юм бол анх удаа Баялгийн сантай болоод ингээд явж байгаа. Маш их эрсдэлүүд байгаа. Тэр эрсдэлүүдийн нэгэн туршилага бидэнд

одоо яг энэ хуримтлуулсан туршилага алга. Ирээдүйн өв санг байгуулаад дунд нь бас эрсдэлүүд гарсан. 700-аад тэрбум төгрөгийн ханшийн алдагдал гарчихсан. Хэрвээ тэр ханшийн алдагдлыг зөв удирдаж чадсан бол өнөөдөр 3,3 биш 4 их наяд төгрөгтэй болох байсан. Ийм эрсдэлүүд бол байгаа. Тэгээд сая эрсдэлийг бол би ерөнхийд нь хэлчихсэн. Хамгийн гол нь юу вэ гэхээр зэрэг энэ гадаад өрнийхөө хэмжээг бууруулах хэрэгтэй.

Дараагийн асуудал бол энэ түүхий эдийн үнийн хэлбэлзэлтэй холбоотой асуудлуудыг биднээс хамаарах ч юм бий, хамаарахгүй ч юм бий. Би нэг ярьчихъя даа. Хамаарах ч юм бий, хамаарахгүй ч юм байгаа. Тийм учраас энийг одоо бид их сайн анхаарах ёстой юм. Гадаад валютын нөөцийг бол 5,2 болчихлоо, их мундаг болчихлоо гээд л бол бид нар рекламдаад байгаа. Монгол Улсын эдийн засаг, Монгол Улсын хөгжлийн потенциал, газрын баялаг, боломжуудыг ашиглах юм бол харьцуулах юм бол энэ бол их бага тоо шүү. 10 тэрбум доллар хүрч байж цаашидаа бид энэ ханшийн тогтвортой байдал энэ бүх зүйлээ бол бас нөөцтэй боллоо гэж үзнэ шүү.

Тийм учраас эдгээр зүйлүүд дээр анхаарах ёстой юм байгаа юм. Өнөөдөр ханиш тогтвортой байна. Яах вэ нүүрсний мөнгө орж ирээд л, гол нь ханиш тогтвортой байна шүү дээ. Энийг нэг их том менежмент хийгээд хийчихсэн юм алга. Тийм учраас юу гэхээр зэрэг ханшийг бол тогтвортой барина. Тэр ханиш чангараад бол хэрэггүй. Ханиш тогтвортой л байх хэрэгтэй. Одоо өнөөдөр 3376 төгрөг байна шүү дээ. 3376 тэр 3380 хавьдаа л одоо ингээд тогтмол барьж чадах юм бол бас одоо үр ашигтай. Ханиш сулрах, чангарах хоёулаа сайн тал ч байдаг. Энэ сөрөг тал ихтэй шүү. Тийм учраас тогтвортой барих нь зүйтэй. Баялгийн сан цаашидаа явахад ханшийн асуудал маш чухал гэдэг.

Дараагийн асуудал бол би түрүүн ярьсан инфляц. 7 хувийн инфляц гэж

байгаа юм. Бас л одоо их сайн болж байгаа л гээд байгаа байхгүй юу. Өнгөрсөн жилийн 12 хувийн инфляц дээр нэмэх нь 7 хувь шүү дээ. Тэгэхээр зэрэг инфляц их өндөр байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ баялгийн сан энэ Норвег, Темасек, тэр Катар гээд энэ яагаад ийм амжилтад хүрсэн гэхээр сая ярьж байгаа энэ нөхцөлүүд бүгд бүрдээд, эдийн засагт нь таатай нөхцөл бүрдсэн. Өөрөөр хэлбэл төсөв нь алдагдалгүй ийм газрууд их амжилттай хэрэгжсэн байна. Тийм учраас бид нар эдийн засгаа зөв удирдах ёстой. Тэр менежментүүдийг нь сайн хийх ёстой. Энэ улс авч явж байгаа, авч явах энэ Засгийн газрын энэ чиглэлийн хүмүүсийн үүрэг, хариуцлагыг их тодорхой болгох ёстой. Шилэн байх ёстой үйл ажиллагаа нь. Хууль, тогтоомжид өөрчлөлтүүдийг нь оруулах ёстой. Ийм зүйлүүд хийгдэж байж энэ эрсдэлийн асуудал бол бид нар эрсдэлийн асуудлыг шийдэж чадна гэдгийг хэлье. Төсвийг алдагдалгүй батлах ёстой. Бидэнд бол маш их боломжууд байгаа. Далд эдийн засгаа ил болгоод байх юм бол төсөв алдагдалгүй батлах боломж байгаа шүү. Ийм зүйлүүд дээр анхаарч чадах юм бол энэ баялгийн сан жинхэнэ утгаараа.../минут дуусав/

Г.Занданшатар: Батиугар гишүүн тодруулж асууна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Сая ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн бол бас яг тодорхой хэллээ л дээ. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ард иргэд ч гэсэн энэ баялгийн сангийн хууль батлагдаад гарвал нөгөө цөөн хэдэн гэр бүл биш, Монгол Улс нөгөө дунджаас дээш давхарга буюу чинээлэг дундаж давхаргыг бий болгох энэ зорилгод хүрэхэд энэ бол хэрэгтэй. Гэхдээ анхнаасаа юм нь тодорхой нээлттэй байх нь чухал шүү гээд иргэдтэйгээ уулзаж байхад иргэд маань ингээд босоод энэ тухай ярьж байгаа байхгүй юу. Ингэхдээ нөгөө “Оюутолгой” гээд л бид яриад байдаг. “Оюутолгой”-н нөхцөлөөс дордуулахгүйгээр харин ч бүүр

анхнаасаа энэ нь ил тод ашигтай улс орны эдийн засаг ч ашигтай, тухайн хүмүүст яг ашигтай ажилласан тохиолдолд ноогдол ашгаа хүртдэг байх. Зарим нь Ирээдүйн өв сангийн юм уу одоо тэр хөгжлийг дэмждэг энэ сангуудын хөрөнгө нь энэ нь яг энд зарцуулагдах юм. Энэ 30 жилээр ч юм уу зарцуулагдахгүй. Улс орны одоо яг ирээдүйд хадгалагдах, ирээдүйд алт болох валют байх тийм сангийн мөнгө байх ёстой. Тэнд гар хүрч болохгүй гэдгийг маш тодорхой тусгаж зааж өгөхгүй бол нэг л өдөр Засгийн газар хуралдаад шийдчихдэг юм уу, эсвэл Их Хуралд энэ асуудлыг оруулахгүйгээр шийдээд явчихдаг гэх мэт өмнө нь нөгөө тохиолдсон асуудлууд дахиад давтагдахгүй гэх баталгаа хаана байгаа вэ. Тэгэхээр энэ баталгааг маш сайн чагталж оруулж өгөх хэрэгтэй гэсэн саналуудыг бол иргэдтэй уулзаж байхад хэлж байгаа.

Тийм учраас бид нар ажлын хэсэг дээр ч ярьсан. Энэ 3 сангаа маш тод тодорхой менежмент нь яаж явах юм, хэн удирдах юм, хаана байршуулах юм, үйл ажиллагааг ил тод байхын тулд ямар аргачлал энд хэрэглэх юм гээд тэрийгээ бас тодорхой зааж өгөхгүй бол одоогийн бид нарын энэ хууль бол ерөнхийдөө Үндэсний баялгийн сангийн хуулийг гаргачихъя. Энэ хууль гарах нь өөрөө хэрэгтэй. Тэр нарийвчилсан зүйлүүдээ явцын дунд Засгийн газар нь өөрөө тэгээд Их Хуралдаа оруулаад зохицуулалтуудыг хийчих боломжтой гэсэн үүднээс бас яригдсан л даа. Гэтэл бид нар сая яг хэлээд байгаа шиг энэ өөрөө маш сайн ажилладаг тэр Норвегийн баялгийн сан шиг энэ арвижаад явдаг, улс орны хөгжилд нь хэрэгтэй, иргэдэд нь өөрөө энэ бас үр өгөөжөө өгчихдөг ийм сан байх ёстой. Тэгэхээр бид нар энэ баялгийн сангийн хууль дээрээ тэр юуг нь чагтлах вэ, юуг нь ил тод тодорхой, маш тодорхой тусгаж өгөх вэ гэдэг асуудлуудаа энэ чуулганыхаа хуралдаанаар, Байнгын хороодоор ажлын хэсэг дээрээ нухацтай яриад тусгах ёстой юм байна лээ. Тэгэхгүй бол хүмүүс бас ингээд байгаа

юм. Нөгөө нэг Улсын Их Хурлаар баталсан стратегийн ач холбогдол бүхий тэр 34 ордуудаас 34 хувийг нь төр өөрөө аваад одоо хувийн хэвшил юм уу, бусдын хөрөнгөд халдаж байна гэдэг тийм буруу ойлголтууд бас их яваад байна л даа. Тэгэхээр энэ бол тийм биш ээ. Энэ бол бүгдээрээ яг Монгол Улс өөрөө хуультай улс. Энэ дээр хувийн хэвилээ ч дэмждэг байх, томоохон төслүүдийг хэрэгжүүлбэл хувийн хэвшилтэйгээ хамтраад хэрэгжүүлдэг байх, бас энэ сангуудаа төр хувийн хэвшил нь менежментийн маш мундаг заалтуудаар тусгаад аваад явчихдаг. Алийг нь томоохон төслүүдийг тэр төслөөсөө хэрэгжүүлэх юм, аль нь өөрөө урт хугацаанд Монгол Улсын үнэт валют нь болоод байх юм гээд энэ зүйлүүдээ маш тодорхой бас тусгаж өгөх зайлшгүй шаардлага байна гэдэг ийм заалтууд бол орж ирж байгаа.

Өчигдөр бид нар ажлын хэсэг дээр бас хэлсэн л дээ. Энэ 3 санг мэдээж Монгол Улсын Засгийн газар гээд, тэгээд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр, нөгөөдөх нь Хөдөлмөр, нийгмийн хамгаал, нөгөөдөх нь Сангийн яам ерөнхийдөө зүгээр тодорхой хэмжээгээр тийм эзэнтэй юм шиг энэ хуулийн төсөл дээр заагаад өгчихсөн нь яг тухайн салбарын сайдын багцад орж байгаа юм шиг их том төсөв харагдах тийм буруу ойлголт өгчих вий гэсэн зүйлүүд ярьсан. Энэ бол тэгэхгүй. Энэ чинь Монгол Улсын нэг л сантай нэг л Монголбанк дээр тэгээд байршаад, өөрөө энэ менежмент нь бол өөр яг тэр хуулийн хүрээнд явчих ийм зүйл байгаа гэдгийг бас сайн тусгаж зааж өгөх, бас энийгээ зөв тайлбарлах хэрэгтэй юм байна лээ Наранцогт дарга. Тэгэхгүй бол яг тийм бас буруу ойлголтууд явчхаад, энийг хэзээ ч зарцуулж болох юм байна. Энэ сайдын багцад тусгагдчихаар сайдын багц нь өөрөө маш том тийм харагдаад, эндээс тэгээд зарцуулаад л явчихна шүү дээ. Шаардлагатай.../минут дуусав/

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал хариулна.

С.Наранцогт: Оюунчимэг гишүүний тэр удирдлагатай холбоотой Оюунчимэг гишүүн өөрөө ажлын хэсэгт ажилласан. Бид нөгөө нэр томъёо дээр нь шууд удирдлага гээд яамнуудаа оруулсан маань хүмүүст бас буруу ойлголтыг өгсөн. Тийм учраас уг нь нэр томъёо дээрээ энэ өдөр тутмын үйл ажиллагааг удирдахаар ингээд оруулчихсан байсан. Тэгээд Сүхбаатар гишүүн, Оюунчимэг гишүүн бид нар бас ажлын хэсэг дээр энийг нэлээн сайн ярьж байгаад, энийг бол үйл ажиллагааны удирдлага болгож өөрчилсөн. Тэгэхээр үйл ажиллагааны удирдлага гэдэг маань сая өмнөх энэ гишүүдийн асуултад хариулах үеэр бас манай ажлын хэсгийн ахлагч их тодорхой хариулсан. Энэ баялгийн сантай холбоотой төсөв, зарлага, хөрөнгө оруулалт бүгд бол Их Хурал дээр шийдвэр гарна. Үүний хэрэгжилтийг Засгийн газар хэрэгжүүлэхдээ яамнуудаараа өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлэхээр ингэж ойлгогдож байгаа. Өөрөөр хэлэх юм бол тухайлбал хуримтлалын санд иргэдийн нэрийн дансанд мөнгийг нь хуваарилах, тодорхой хөрөнгө оруулалтын шийдвэр гараад Сангийн яаман дээр Ирээдүйн өв сангийн гүйлгээ хийгдэхэд гэдэг юм уу иймэрхүү өдөр тутмын үйл ажиллагааг нь яамнууд үйл ажиллагааны удирдлага хэлбэрээр хэрэгжүүлэхээс биш, яамнууд өөрсдөө хөрөнгө оруулалтын юм уу зарцуулалтын ямар нэгэн шийдвэр гаргаж хэрэгжүүлэх боломжгүй юм. Энэ хуулийн концепт бол ингэж хийгдэж байгаа гэдгийг тодруулж хариулъя.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууна.

М.Оюунчимэг: Манай Улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байгаа энэ уул уурхайн салбарын бас олон жил нуруундаа үүрээд авч явж байгаа энэ салбарын эрдэмтэд, нэр хүндтэй бизнес

эрхлэгчдийн олон нийтийн хэвлэл мэдээ мэдээллийн хэрэгсэл дээр бас өгч байгаа тэр ярилцлага энэ тэрнээс харахад Ирээдүйн өв сангийн энэ хөрөнгийг улс төрийн зорилгоор юм уу, үр ашиггүй төслүүдэд санхүүжүүлэхгүй. Энэ бол урт хугацаанд Монгол Улсын ирээдүйн өв сан байх юм гэдэг тэр баталгаа тэр чагт харагдахгүй байна. Энэ өөрөө бидэнд тийм эргэлзээ төрүүлж байна гэсэн асуултуудыг бид нараас асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар ийм зүйл бол байхгүй. Энийг тэгж гэнэт улс төрийн зорилгоор юм уу, эсвэл үр ашиггүй төслүүдэд өмнөх Хөгжлийн банк шиг, өмнөх тэр Ирээдүйн өв сангийн хөрөнгө гэнэт алга боллоо гэдэг юм уу, эсвэл өөр нэг зүйл рүү зарцуулчихсан ийм зүйлүүдийг дахин давтахгүйн тулд Баялгийн сангийн энэ хууль дээрээ бид маш сайн зааж тодорхой, хэн ч харсан энэ тодорхой юм байна. Үүний тэр ил тод менежментээ сайн зааж өгөх нь чухал юм байна гэдгийг би хэлье гэж бодсон юм аа.

Г.Занданшатар: Санал байна. Одоо Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Би 2 л асуудал байгаа юм. Засгийн газрын тусгай зориулалттай 25 сан байдаг. 8 нь болохоор хуулиар зохицуулагддаг, үлдсэн 17 зүгээр ийм сан байна гээд Тусгай зориулалтын сангийн хууль дээр сангийнх нь нэрийг нь оруулаад л, эх үүсвэрийг нь тавиад л, тэгээд л журам баталж үйл ажиллагааг нь явуулдаг. Одоо нэг ёсондоо удирдлагыг нь журмаар зохицуулдаг гэсэн үг. Тэгээд энэ 3 сан дээр ялгаа байхгүй яг ийм зарчмаар орж ирсэн байна л даа. Яах вэ төлөвлөгөөгөө, тайлангаа Их Хурлаар хэлэлцүүлэх юм байна. Засгийн газраар батлуулах юм байна.

Гэхдээ нэг асуудал нь юу вэ гэхээр журам маань өөрөө нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт болж чаддаггүй. Нэг ёсондоо журам зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломж байхгүй.

Тэгээд энэ дээр та нарыг би нэг анхаарлаа хандуулаад, энэ нэг журмыг нь болж өгвөл хуульдаа оруулаад ингээд явахгүй бол 3-ын 3 Монгол Улсын хамгийн том сан дээр журмаар зохицуулна гээд ороод ирдэг. Эргээд хариуцлагын асуудал яригдахаар зөвхөн Төрийн албаны хуулиар л хариуцлага тооцох боломжтой болно. Тэгээд энэ дээр хуулийн багуудаа ажиллуулмаар байна. Энэ дээр Их Хурлын дарга бас нэг анхаарал хандуулаад, гүйцээн боловсруулах чиглэл бас өгүүлчихвэл сайн байна. Дараа нь бид нар ниргэсний дараа бөөн асуудал болж, бөөн сонсгол хийж байхаар одоо яг энэ дээрээ асуудлаа яриад, хуульдаа шаардлагатай бол оруулаад явмаар байна. 25 сангийн 8 л асуудалгүй байгаа шүү дээ. Бусад нь бүгдээрээ ямар нэгэн байдлаар журам нь зөрчигдсөн, зарцуулалтад дулимаг дутмаг болоод ингээд явчихсан байгаа. Би өөрөө энэ сангуудыг шалгах ажлын хэсэг дээр ажиллаж байсан болохоороо ингээд та бүхэнд гарах асуудлыг нь хэлээд байгаа юм шүү. Тэгээд энэ дээр нэг анхаараад өгөөрэй.

2 дугаарт болохоор энэ үйл ажиллагааны удирдлагыг 3 яам зохион байгуулна гээд орсон байгаа. Энэ дээр мөн болж өгвөл тодорхой хэмжээний зөвлөлийн бүтэц бий болгоод, хувийн хэвшилээ тэр дээр нь төлөөллийг нь оролцуулаад, энэ төсөл хөтөлбөр төлөвлөгөөгөө ярилцдаг болчихмоор байна. Бид нар энэ хувийн хэвшилээсээ жоохон тасраад байгаа шүү. Одоо энэ хөгжлийн сан ч байдаг юм уу, хуримтлалын сан ч байдаг юм уу, ирээдүйн өв сан ч байдаг юм уу. Энэ дээр чинь нөгөө ажил олгогч эзэд, тэдний төлөөлөл хамтарч ярьдаг баймаар энэ тэр платформыг нь тэр зөвлөл хэлбэрээр байх юм уу ийм хэвлэлээр оруулах хэрэгтэй. Угаасаа энэ чинь тайлан төлөвлөгөө нь бүх юм нь Их хурлаар, Засгийн газраар орно. Гэхдээ аппарат нь бол яамнууд дээрээ байг. Тэгэхдээ тэр яам дээрээ тэр сайдыг нь оролцуулаад, хувийн хэвшилтэй нь хамтарсан зөвлөлийг нь байгуулаад, тэгээд тэр

дээрээ анхан шатын яриануудаа хийдэг болмоор байна. Судалгаа шинжилгээтэй хийдэг болмоор байна. Нэгэнт одоо тэнхимийг бол Их Хуралд өргөн баригдчихсан байгаа юм чинь тэр тэнхимийн төлөөллийг нь байлгаад бусад яг ач холбогдолтой гэсэн тэр салбарын төлөөллийг нь оролцуулаад энэ зөвлөлийн хэлбэрээр эхний шатны тэр шүүлтүүрийг хийдэг, ярилцдаг ийм платформ бий болгохгүй бол дан төрийн л бүтэц бий болчихоод байна шүү дээ. Тэгээд яалт ч үгүй яг тэр хөгжлийн төлөвлөгөө байдаг юм уу, хуримтлалын юу байдаг юм уу энэ дээр чинь л хувийн хэвшлийн дуу хоолой маш чухал шүү. Энэ дээр ажлын хэсгийн дарга маань бас анхаараад өгөөч гэдэг хүсэлт тавих гэсэн юм. Баярлалаа

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч асуултад хариулна.

Б.Баттөмөр: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Яах вэ, болгоомжлол. Нөгөө алдсан хүн 10 тамтай гэж. Бид чинь байнга хулгай дунд амьдарч, юмаа хулгайч нарт алдаж байсан учраас бас болгоомжлолууд байна л даа. Тэгээд энэ яг менежментийг нь бол Засгийн газар хариуцна. Яах вэ 3 яам бол Засгийн газартаа ажлаа тайлагнана. Ажлаа оруулна, саналаа оруулна. Засгийн газар Их Хуралд оруулна. Их Хурал бол эцсийн шийдвэрээ гаргана. Их Хурлын гаргасан шийдвэрийг хэн ч өөрчилж чадахгүй. Хэн ч зориулалт бусаар ашиглахгүй. Тайлан тооцоо мэдээлэл тэр ил тод байдлыг түрүүн хэлчихсэн. Дахиж давхар яриад яах вэ. Тэгэхээр энэ хуульд бол ямар нэгэн Хөгжлийн банк дээр гардаг шиг ийм алдаанууд, бусад сан дээр гарсан алдаанууд бол энэ хууль дээр, энэ сан дээр бол би гарахгүй болов уу гэж бодож байгаа. Засгийн газраас оруулж ирсэн санал нь бол тусгай бүтэц бол хэрэггүй юм аа. Одоо ингээд энэ үйл ажиллагаа цахимжиж байна гэж байгаа. Тэгэхээр зэрэг би чинь цахимжих хэрээр энэ орон тоо хэмнэгдэж байх ёстой шүү дээ. Бид орон тоог хэмнэнэ гэдэг асуудал ерөөсөө

ярихгүй байгаа шүү дээ. Тийм учраас одоо байгаа орон тоо дотроо багтаагаад яам яаман дээр тодорхой хүмүүс хариуцаад тэр нь одоо Засгийн газартай нэгтгэж танилцагдаад, тэгээд Засгийн газар нь Их Хуралдаа оруулаад, Их Хурал нь хууль болж баталж өгөөд, хуулийн хэрэгжилтийг Засгийн газар хангадаг. Түүнээс биш дураараа энийг зарцуулах юм ерөөсөө байхгүй байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй гэж бодож байгаа юм аа.

Тэгээд энэ нэгэнт удирдлагын юмыг яамнууд нь өөрөө хэрэгжүүлээд явах учраас энэ дээр Засгийн газраас оруулж ирсэн санал дотор тэр журам гэдэг юм бол ерөөсөө байхгүй байгаа. Тийм учраас бол Засгийн газар өөрийнхөө чиг үүргийнхээ хүрээнд энийг хийгээд явна гэдэг нь зүйтэй юм байгаа юм.

Энэ хувийн хэвилийн хувьд бол мэдээж энэ хөгжлийн сан гээд тэгж байна. Сая Ганхуяг гишүүн ярьж байна. Хөгжлийн сан дээрээ хувийн хэвилийн саналыг авъя гэж байна. Хөгжлийн сан бол одоо ард нийтээр хэлэлцэх гэж байгаа. 2025 оны Хөгжлийн төлөвлөгөөнд орох юмнуудыг Хөгжлийн яамнаас зохион байгуулаад явж байгаа. Энэ дээр хувийн хэвшил бол бүгд саналаа өгөөд явж байгаа гэж ойлгож байгаа 1 дүгээрт.

2 дугаарт бол юу вэ гэхээр сая үүний түрүүн бид нар Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийг баталлаа. Мэргэжлийн нэгдсэн холбоонууд энэ яамнуудын үйл ажиллагаанд оролцоод, хамтарч ажиллаад, чиг үүргийг нь гүйцэтгээд ийм зүйлүүд нь энд явж байгаа юм. Тийм учраас бол хувийн хэвилийн санааг авна гэдэг бол энд шийдэгдээд явж байгаа гэсэн ийм зүйлийг хэлэх гэж байгаа юм. Тэгээд яах вэ, ер нь бол сайжруулах асуудлууд бол байна. Аливаа юм бол нэг гарч ирснээрээ шууд амжилтад хүрнэ гэж бол байхгүй. Ямар ч байсан Монгол Улс баялгийн сантай боллоо. Баялгийн сан дотроо 3 төрөлтэй байна. Энэ дотор тэр

хөгжлийн сан төрийн оролцоо бол бас тодорхой хэмжээнд манай Үндсэн хуульд чинь заачихсан байж байгаа шүү дээ. Төр, хувийн хэвилийн холимог тогтолцоотой байна. Холимог эдийн засагтай байна гээд. Хөгжлийн сангийн эх үүсвэр маань төрийн өмчтэй компаниуд бүрдүүлнэ шүү дээ. Тийм ээ. Өөрөөр хэлбэл ... уучлаарай тэр хуримтлалын сангийн хөрөнгийг. Яагаад гэхээр энд бол төрийн өмчтэй компаниудын ноогдол ашигийн 34 хувиас хуримтлалын сан бүрдэнэ. Хуримтлалын сан бол одоо байгаа иргэдэд хөгжлийн сан 2 одоо байгаа иргэдэд хамаарч байгаа асуудал. Ирээдүй өв сан маань бол ирээдүй үедээ хадгалах ийм л зохицуулалтаа Засгийн газраас оруулж ирсэн энэ саналыг бид бас дэмжээд ингээд явж байгаа Ганхуяг гишүүн ээ. Манай ажлын хэсгийн гишүүдээс нэмж хариулах юм байвал хариулж болно.

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт. Сангийн менежмент удирдлагын асуудлыг.

С.Наранцогт: Ганхуяг гишүүний асуултад тодруулж хариулъя. Яах вэ энэ хуулийн үндсэн концепц хэлэлцэх эсэх дээр ч би бас хэлж байсан. Ер нь үндсэн орлого, хуваарилалтын зарчим, зарцуулалтын үндсэн зарчмыг нь ер нь тодорхойлсон нэлээдгүй товчхон хууль орж ирж байгаа. Хураангуй. Тэр нь бас энэ Үндэсний ирээдүй өв сангийн хууль 2030 он хүртэл хэрэгжихтэй холбоотой. Засаглал менежментийн хувьд бол тэр хөрөнгийн удирдлагын компанийн асуудлыг манай гишүүд бас нэлээд ярьж байгаа. Энэ асуудал бол ингээд 2030 он дээр яг хөрөнгийн удирдлагын менежментийн компани нь бол Норвегийн сангийн загвараар ажиллаж эхлэх юм. Наана нь энэ хөрөнгө оруулалтын бодлого тодорхойлоход бол хувийн хэвилийг оруулахгүй гэсэн хаалт ерөөсөө байхгүй. Юу вэ гэхээр хөрөнгө оруулалтын бодлогыг бол сангуудын хөрөнгө оруулалтын бодлогыг бол Засгийн газар тодорхойлно гэж байгаа. Тодорхойлохдоо сая Баттөмөр гишүүний

хэлсэн мэргэжлийн холбоодоор дамжуулаад, хувийн хэвшлийг оруулсан ч болно, тухайн салбарын экспортуудыг оруулсан ч болно. Ийм механизмуудыг ажиллуулах бололцоо нь бол өөрөө нээлттэй байгаа. Зүгээр хуулийн хувьд бол бид нар үндсэн концепц, үндсэн хуваарилалтын зарчмыг тодорхойлсон хууль оруулж ирж байгаа учраас энэ дээр ингэж тэр болгон процессыг бол нарийвчилж хуульчлах бололцоо байгаагүй. Гэхдээ энэ таны ярьж байгаа зүйлийг бол Засгийн газар өөрөө хэрэгжүүлээд явах бололцоо нь өөрөө бүрэн нээлттэй байгаа юм гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд хэрэгжүүлээд ч явах байх. Яг хэлсэн зарчмуудаар.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн бас зарчмын санал хэлсэн. Ер нь ингээд бид нар цөмөөрөө л Норвегийн сангийн тухай яриад байгаа. Тэгтэл Норвегийн сангийн үндсэн эрхэм зорилго нь бол одоо бол нөгөө ирээдүй үеийн санхүүгийн баялгийг Файнанишиал Велт гэж байгаа. Тэр юмыг сефкард хамгаалаад өсгөж үржүүлэх гэсэн ийм зорилготой шүү дээ. Яг тэр зарчим зорилгоороо явдаг. Ирээдүй өв сан бол жишээлбэл Норвегийн сан шиг хөрөнгө оруулалт хийж, өсгөж үржүүлсэн байсан бол энэ 10 жилийн хугацаанд 50 хувиар өсчихсөн. 10 тэрбум доллар болчихсон байж болно. Жишээлбэл Норвегийн сангийн үнэлгээ одоо 2019 онд 10 тэрбум крон байсан бол одоо 16 тэрбум крон болоод 60 хувиар өсчихсөн байна шүү дээ. Доллар валютаар шүү дээ. Яг ийм л сан бид байгуулахыг энэ төслийн үзэл баримтлал шаардаж байгаа. Тэгэхээр Монголбанк энэ Төрийн нэгдсэн дансанд байршуулна гээд энэ 5 дугаар заалтад ороод ирж байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг. Энийг гүйцээн боловсруулж одоо Ганхуяг гишүүний ч гаргаж байгаа саналаар энэ сангийн менежмент удирдлагыг хараат бус, бие даасан ийм шийдвэр лүү нь чиглүүлэх ёстой. Тэгэхгүй

бол Улсын Их Хурал бол улс төрийн шийдвэр л гарна шүү дээ. Тэгээд тэр болгон хурдтай тийм шийдвэр гараад байгаа байхгүй. Одоо Норвегийн сан жишээлбэл Apple, Nestle, Microsoft, Samsung-ийн энгийн хувьцаа, тийм 9 мянган компани хувьцаа эзэмших энэ чинь валютаараа байна гэсэн үг шүү дээ. Тэд нарын үнэлгээ даблдаад өсөхөөр дагаад ингээд 60 хувиар өсчхөж байгаа юм. Жишээлбэл. Тэгтэл манай сангууд чинь ийм үхмэл сан болгоод байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт Монголбанк төрийн нэгдсэн санг байршуулна гээд орхичхож байгаа юм. Тэрийг зарцуулна гэж Улсын Их Хурлаар ороод, шийдвэрлээд, зөвхөн зарцуулах шийдвэр гарна. Улс төрийн шийдвэр гарна. Бид нар энэ чинь зарцуулдаг сан биш, хуримтлалын өсөж, үрждэг сан болох үржүүлгийн хурд болгоно гэсэн ийм концепц дэвшүүлээд байгаа шүү дээ.

Ингээд Ирээдүйн өв сан шиг ахиад ингээд нэг ийм тэтгэмжийн сан болоод хувирчих юм бол тэтгэврийн сан болоод хувирчих юм бол ирээдүй үедээ баялаг үлдээх гэсэн Үндсэн хуулийн үзэл санаа ширгэнэ ээ. Үндсэн хуулийн үзэл санаанд бол Үндсэн хуульд бол одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш хүртээмжтэй байх ийм үндэсний баялгийн санд газрын баялгийн өгөөжийг хуримтлуулж ийм тэгш хүртээмжтэй инклюзив буюу хүртээмжтэй байх тэр агуулгыг л шингээсэн. Тэгэхээр энэтэйгээ уялдуулж төслийн 10.3 дахь хэсгийг үндэслээд гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Дахин анхаарахыг одоо манай Ганхуяг гишүүн ч гаргасан.

Одоо Итгэлт баян хүртэл хэлдэг биз дээ. Сохор зоосыг ч гэсэн сэгсэрч бай, тэгвэл үр төлөө өгдөг юм гэж. Аливаа зүйлийг хөдөлгөөнтэй байж байж л амьд байдаг. Сангийн хөрөнгө өсөж үржих ёстой. Ингээд Монголбанк ингээд үхмэл хөрөнгө болохгүй, тэгээд эрсдэлгүй байх юм бол Ирээдүй өв сан төрийн дансанд яаж байж байгаа тийм юм болно шүү. Ийм учраас үйлдэл, эс үйлдэл 2-ыг

хослуулсан энэ байх ёстой. Тэгээд тэр нь энэ олон сангууд шиг эрсдэлд учруулдаггүй байх юмыг энүүгээр хааж өгөх ёстой, хараа хяналтыг нь сайжруулах ёстой. Тэгээд Монголбанканд байршуулна гэхчээр Норвегийг дурдаж байгаа юм л даа. Норвег чинь Norges bank буюу Норвегийн төв банканд байршиж байгаа. Тэгэхдээ сангийн удирдлагыг нь Сангийн яам, удирдах зөвлөл нь Сангийн яам, Монголбанк, нөгөө Мөнгөний бодлогын хороо шиг ийм хороо байгуулаад, тэр хороо мэргэжлийн хүмүүсийг доороо сонгон шалгаруулалтаар авч ажиллуулаад, ингээд хамгийн ашигтай хөрөнгө оруулалтуудыг хийж байгаа байхгүй юу. Зөвхөн өгөөж нь 8,6 тэрбум крон, хүүгийн өгөөж нь. Тэгэхээр Норвегийн сан дээр чинь тэгэхээр тэр өгөөжөө зарцуулж байгаа юм. Тэгээд үнэлгээгээрээ өртгөөрөө өсөж байгаа юм. Ийм өсгөн үрждэг сан байгуулах чинь ерөөсөө Үндэсний баялгийн сангийн үндсэн концепц байхгүй юу. Байгалийн баялгийг бол шууд зарчих гэж байгаа юм. Тэгээд ашиглаад л ингээд тэр их мөнгийг олж авангуутаа тэрийгээ үржүүлж байгаа байхгүй юу. Үндсэн баялгийн сангийн концепц агуулга энэ шүү дээ. Тэгээд энэтэйгээ нийцүүлж гүйцээн боловсруулах шаардлагатай гэдгийг бас санал хураалтын өмнө цохон тэмдэглэе.

Ингээд Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Дараа нь санал хураалт. Санал хураалт юу болж байна. Ямар ч байсан Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асуучихъя.

Б.Бат-Эрдэнэ: Үндэсний баялгийн сангийн хуулийн үзэл баримтлалын хүрээнд бол дэмжиж байгаа. Тэгэхдээ байна шүү дээ. Би 2004 оноос энэ Их Хуралд суусан. 2004, 2008, 2012 оны парламентууд бол энэ эх орныхоо байгалийн баялагт бол дэндүү хариуцлагагүй хандсан даа. Одоо бол яах вэ, энэ сүүлийн 2 парламентын хугацаанд удирдаж байгаа хүмүүс нь энэ эх орон, ард түмнийхээ нэг нийтлэг эрх ашиг дээр бас ч гэж ингээд байж байгаа учраас

хандлага нь бол арай өөрчлөгджээ. Тэр 2004, 2008, 2012 оны парламентуудын энэ хугацаанд бол их эх орныхоо байгалийн баялагт энэ ард түмэн эзэн байх энэ эрхийг хангуулахын төлөө үгээ хэлэхэд бол тэрийг дэмждэг хүмүүс ер нь тун цөөхөн байлаа шүү дээ. Үе үеийн парламентад бол тэгээд л дарга юу гэж хэлнэ вэ мань дагана гэсэн нэг байр суурьтай хэдэн хүмүүс. Нэг хэсэг нь бол хувийн ашиг сонирхлын зөрчилтэй. Тэрэндээ барьцаалагдсан. Амандаа ус балгасан юм шиг таг суудаг ийм хүнд хэцүү цаг үед бид зүтгэж тэмцэж байж Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол, энэ “Оюутолгой”-н хөрөнгө оруулалтын гэрээ хийх үед ингэж нэг юм ятгаж, татаж чангааж байж арай гэж батлуулсан шүү дээ. Тэгээд энэ тогтоолд бол анхны “Оюутолгой”-г яриад байгаа шүү. Анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа Монголын талын эзэмших хувь хэмжээг 50 хувьд хүргэх ийм зарчмын заалт орсон. Тэгэхдээ энийг Засгийн газарт үүрэг өгчихсөн. Тэгээд энэ талаас нь авч үзэхгүй бол энэ гэрээ дээр бол тодорхой заачихсан шүү дээ. 4,7-5 жилийн хугацаанд анхны хөрөнгө оруулалтаа нөхнө гээд тодорхой заачихсан. Энэ бол 2009 оны 10 сарын 6-нд үзэглэсэн шүү дээ. Яах вэ, ТЭЗҮ-г засвартай хүлээж авсан. Техник ажлын зураг байхгүй гээд л бид нарын ярьдаг юм өнөөдөржин ярихаар юмнууд дутуу л даа. Гэхдээ одоо ингээд бодох юм бол ийм л юмыг алдсан шүү дээ.

Үүний дараа тэр 2007 онд энэ стратегийн ач холбогдол бүхий ордын жагсаалтыг 2 эрсдэлтэй 16 орд, дараа нь 39 орд ингээд заагаад өгчихсөн. Энийг одоо бид бүр харин тэр заасан тооноос нь одоо ч хэдхэн байна. Дөнгөж дол 5, 6 ордын тухай асуудал яригдаж байгаа биз дээ. Тэгээд цаад талын ордууд хаана орсон бэ. Бид нар 2012-2016 онд энэ Их Хурал дээр нөгөө л нэг хэдэн хэлдэг юмнууд хэлээд авч үлдэж чадаагүй энд Их Хурлын тогтоол гаргуулаад, хавтаслаад гарч байсныг бид мэдэж байгаа шүү дээ. Цаашид ч энэ баялаг, эх

орны эрдэс баялаг бол нэмэгдэх ёстой. Стратегийн ордод авах энэ орд бол тэр 16, 39-өөр бол хязгаарлагдахгүй ийм юм байгаа юм. Ингээд би асуух гээд байгаа юм бол тэр “Оюутолгой”-н орд гадаадын хөрөнгө оруулагч гэж сайхан нэрээр халхавчилсан зээл зуучлагч, мөнгө хүүлэгч энэ луйварчдад зориулж Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулсан. 34, 50 хувийг эзэмшиж болно. Тэгэхдээ хөрөнгөө гаргаж эзэмшинэ гэж. Яах вэ энэ хууль дээр бол энийг оруулж ирж байгаа юм байна. Гэхдээ бол хувь хэмжээг нь 34 хүртэл, 50 хүртэл эзэмшиж болно гэдэг тэр бөөрөнхий заалтаараа л оруулж ирээд ингээд сууж байгаа юм. Тэгээд энэ чинь Ашигт малтмалынхаа хууль дээр ямар байдлаар засагдах юм бэ.

Г.Занданишатар: Хууль хоорондын зөрчил болон ашигт малтмалын хууль дээр яаж туссан юм бэ. Стратегийн ордын асуудал гэсэн асуулт. Санжаагийн Наранцогт. 4 номер. гүйцэтгэх захирал.

С.Наранцогт: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ саяын заалт дээр үнэгүй эзэмшиж болно гэдгээр Ашигт малтмалын хуулиар дагах хуулиар тэгж өөрчлөгдөөд орж ирж байгаа юм. Тэгэхээр яг энэ баялгийн сангийн хууль дээр бол тэр заалт байхгүй. Баялгийн сангийн хууль нь өөрөө стратегийн ач холбогдолтой орд газраас олох үр өгөөжийг нийт ард иргэдэд тэгш, үр өгөөжтэй хүртээхийн тулд энэ хууль орж ирж байгаа учраас Ашигт малтмалын хуулийн стратегийн ач холбогдолтой ордтой холбоотой тодорхой заалтуудад нь энэ өөрчлөлт оруулах саналыг оруулж ирж байгаа юм. Стратегийн 2007 оны тогтоол 2 хавсралтаар гарсан. Тэр эзэмшлийн асуудлыг бол АМХЭГ-ын дарга 5 дугаар микрофон дээр хариулна.

Г.Занданишатар: За 5. Баярмандал. Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар.

Л.Баярмандал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Саяын асуулт дээр бас нэмээд хэлэхэд Ашигт малтмалын тухай хууль дээр бол байгаа заалт байгаа. Ашигт малтмалын өмчлөл гээд 5.4, 5.5 дугаар заалтууд. Тэгээд энэ дээр бол угаасаа энэ хууль дээр бас сая гишүүн хэлж байсан. 50 хувь хүртэл, 34 хувь хүртэл гээд энэ бол өөрчлөгдөөгүй. Зөвхөн үнэгүй оруулж болно. Тэгээд компанийн хувьцаа гээд тодруулаад 2 заалт л орж байгаа. Бусад нь бол хуучин хэвээрээ байгаа. 2007 оны Их Хурлын 27 дугаар тогтоолоор батлагдсан 1 дүгээр хавсралтын 16 орд, 2 дугаар хавсралтад 39 орд байгаа. Энэ бол одоог хүртэл өөрчлөгдөөгүй байгаа. Улсын Их Хурал дээр бас өмнө нь бол яригдаж байсан гэсэн. Тэгэхдээ бол энэ асуудлыг илүү судалж байж оруулах хэрэгтэй гэдгээр бол буцаж байсан ийм асуудал байдаг юм байна лээ. Одоогоор бол энд ямар нэгэн жагсаалтад өөрчлөлт ороогүй ингээд явж байгаа.

Г.Занданишатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: 2019 оны 11 сарын 14-нд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг санаачилсан хүмүүсийн 1 л дээ. Энд бол энэ баялгийн сан баялагтаа эзэн байх эрхийг хангахын төлөө л бид ажилласан. Нэлээн сайн ажилласан. Тэрэнд тодорхой заалтууд орсон. Тэгэхээр зэрэг энэ хуулийг дэмжээд байгаа. Хамгийн гол нь цаад талд нь дахиад Хөгжлийн банкны араас орох вий. Энэ эрсдэлийн удирдлага талаасаа анхаарахгүй бол болохгүй шүү. Энэ 3 чиглэл байна. Яах вэ хуримтлалын сан нь бол тэгээд явах юм байна гэхэд Ирээдүйн өв сан энэ олон улсын зах зээлээс үнэт цаас Засгийн газрын бонд, крипто валют ч гэдэг юм уу энэ санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулаад ингээд энэ эрсдэлийн хязгаарыг оновчгүй тогтоосноос болоод нэг валютаас нэг газраас хэт хараат ч болдог юм уу ийм юм гарахгүй ээ. Хөгжлийн сангийн энэ хөрөнгө мөнгийг

үр ашиггүй, эргэж ашгаа нөхөхгүй ийм урт хугацааны юманд оруулчих вий гэсэн ийм сан.../минут дуусав/

Г.Занданишатар: Хариулах уу. Баярмандал 5 номер. Энийг ер нь байна шүү дээ. Үндсэн хуульд энэ санал энэ дээр уялдах ёстой юм байгаа юм. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд оногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж. Тэгэхээр энэ Бат-Эрдэнэ нарын гишүүд санаачилж оруулсан Үндсэн хуулийн заалт л даа. Тэгээд тэрийг тэр нийцүүлж Ашигт малтмалын хууль болон бусад хуулиудад өөрчлөлт орох ёстой. Тэгээд энэ Үндэсний баялгийн сангийн хууль эцэслэн батлахдаа энийг бас агуулгыг нь шингээх ёстой юм байгаа юм. Бас нэг зүйлийг Баттөмөр гишүүн ээ анхаармаар байгаа юм. Энэ АМНАТ-ийн буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 3,5 их наядын төлбөр орлогыг чинь 95 хувийг 23 компани оруулдаг юм. Тэрний дийлэнх нь бол энэ стратегийн орд газрууд оруулдаг юм. Энэ ийшээ баялгийн сан руу шилжихээр төсөвт тодотгол хийхээс өөр аргагүй эрх зүйн үндэс бий болно шүү дээ. 3,5 их наядын өөрчлөлт орж ирнэ. Стратегийн ордуудаа бас тодорхойлох шаардлага гарна. Тэгээд энийг хэлэлцүүлэг дээрээ хэзээнээс хуулиа хэрэгжиж эхлэх вэ энэ заалт гэдгээ бас тооцоолохгүй бол эрх зүйн үндэс үр дагавар ихтэй.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 38 санал байгаа. Тарахгүй л дээ. Зарим гишүүд 2 цагаас ирнэ гээд сая гараад явцагачихлаа л даа. Яг 14 цагаас санал хураалт явна.

Одоо хуулийн төсөл өргөн барина. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд,

Хаянгаагийн Болорчулуун сайд нар хууль өргөн барина.

Одоо 2 Байнгын хорооны хамтарсан хурал хуралдана. Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Төсвийн байнгын хороо хамтарч хуралдана. Гаалийн татвар гурилын асуудлыг ажлын хэсэг хуралдаж шийдсэн.

Үдээс өмнөх чуулганыг завсарлая. 14 цагаас санал хураалтаар эхэлнэ. Гишүүд 14 цагт бэлэн байх ёстой. Яг 13 цаг болсон учраас үдийн завсарлага.

ЗАВСАРЛАГА.

Г.Занданишатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүд ээ. Санал хураалтад бэлтгээрэй.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 18-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Зарчмын зөрүүтэй 38 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналууд байгаа.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “салбарын” гэсний дараа “, авто зам, төмөр замын дэд бүтцийн” гэж

нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Хассуурийн Ганхуяг, Тогмидын Доржханд, Мөнхөөгийн Оюунчимэг, Жамъянхорлоогийн Сүхбаатар /цаашид “ажлын хэсэг” гэнэ/. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно.

Ингээд Жигжидийн Батжаргал гишүүн. Өөр үг хэлэх хүн байна уу. Батжаргал гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Тийм. Энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 1 дэх санал дээр ийм асуудал гарч ирээд байгаа юм аа. Уул уурхайн олборлолт ашигт малтмал энэ боловсруулах салбарын, тэгээд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр бий болсон тэр авто, зам төмөр замын компанийн орлого л ийшээ орохоор уг нь зохицуулагдах ёстой. Гэтэл шууд авто зам, төмөр зам гээд хэлчихээр зэрэг болж өгөхгүй байгаа юм. Тийм учраас үүнийг гүйцээн боловсруулахаар чиглэл өгөх нь зөв гэж би ойлгоод байна.

Г.Занданишатар: Эдийн засгийн байнгын хороо дарга аа, Бямбацогт гишүүний яриад байсан асуудал уу. Тэгэхдээ энэ чинь холбоотой л байна шүү дээ. Энийг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Батжаргал гишүүний санал, ажлын хэсгийн саналыг үндэслээд энэ 1 дэх заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Дараагийн санал.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шууд удирдлага” гэснийг “үйл ажиллагааны удирдлага” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.1, 8.3.1 дэх заалтын “шууд удирдлагыг” гэснийг “үйл ажиллагааны удирдлагыг” гэж тохиолдол бүрд нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулна. 2 дахь санал хураалт. Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн

саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн дэмжиж, 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Хөгжлийн” гэсний өмнө “Үндэсний” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Үндэсний хөгжлийн гэж болж байгаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн суудалдаа суу. Битгий уур хүргэж бай.

4.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “орон сууц зэрэг суурь хэрэгцээг хангах” гэснийг “орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт хүчингүй. Санал хураалт явуулахгүй шүү. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Үгүй ээ, энэ юу яагаад байгаа юм байна. Энэ хуулиар бид нар хуримтлалын сангийн тухай яриад, тэгээд иргэдийнхээ нэр дээр хуримтлалын нэрийн данстай байхаар яриад, тэгээд 4.1.6, 7.1.5, 8.2.2-оор энэ харилцаануудынхаа ерөнхий эрхийг нээсэн хэр нь 10.1.2-оор 3 зүйлд энэ хөрөнгийг зарцуулна гээд. Энэ 3-т юмаа аваагүй хүмүүсийг яах юм. Нэгэнтээ хүний нэр дээр нэрийн данс нээсэн юм бол үлдэгдлийг нь яаж өвлөгдөх юм энэ тэр гээд асуудал нь эрх зүйн зохицуулалтгүй үлдчихээд байгаа байхгүй юу. Үүнийг яаж зохицуулах вэ.

Г.Занданишатар: 57,5 хувийн саналаар өмнөх санал дэмжигдсэн. Одоо энэ зэрэг суурь хэрэгцээг хангах гэдгээ бүр зөвхөн орон сууц болгоод хязгаарлаж байгаа л юм байна. Энийгээ тэгээд эцсийн хэлэлцүүлэгтээ анхаарч үзээрэй. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бусад юм хязгаарлачхаж байна шүү дээ. Батжаргал гишүүний хэлж байгаа зөв шүү дээ. Энэ санал хураалт. Нэрийн данс нээчихсэн мөртөө тэр чинь бусад. Энийгээ эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарахгүй бол.

5.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төрийн сангийн нэгдсэн” гэснийг “Монголбанкан дахь төрийн сангийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Энийг гүйцээн боловсруулах чиглэл өгчихье.

Энийг түрүүн тодорхой хэлсэн. Өсөж, үрждэг сан байх ёстой. Үхмэл дансанд хадгалагддаг байж таарахгүй ээ. Ирээдүйн өв сан шиг эргэлтэд орохгүйгээр ингээд хадгалагдчих юм бол энэ үхмэл хөрөнгө болно. Ийм учраас энэ тогтолцооных нь асуудлыг энд шийдэж өгч, хяналтынх нь асуудлыг нь шийдэж өгч ингээд үрэгдээд алга болдог нөгөө сангууд шиг байж болохгүй гэсэн үндсэн зарчимд нийцүүлж энэ хэсгийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Одоо Норвегийн сангийн жишээг зөндөө яриад байдаг. Тэгтэл Норвегийн сан чинь хөрөнгө оруулалтын сан байж Apple, Nestle, Microsoft, Samsung-ийн хувьцаа худалдаж авсан нь 2019 онд 10 тэрбум кроны үнэлгээтэй өгөөжтэй байсан бол одоо 16 тэрбум буюу 4, 5 жилийн дотор 60 хувиар өсчихсөн байгаа шүү дээ. Ингэж нөгөө хөрөнгө оруулалт хийгдэж байх ёстой. Тэгтэл 2019 оноос хойш Ирээдүй өв сан тэгж үржиж өссөн бол хөрөнгө оруулалтын сан байсан бол доллароороо байж байсан бол энэ ямар том хуримтлалын сан байж болох байсан энэ гашуун туршлагыг одоо давтмааргүй байгаа юм. Энийг ийм учраас гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

6.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэд заалтын “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Бөхчүлууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй.

Б.Пүрэвдорж: Эрх баригч нар төрийн өмчийн компани дээр гарч байгаа олон хулгайг илрүүлж, гаргаж байгаа

боловч яг өнөөдөр Их Хурал руу оруулж ирэхдээ энэ хулгайг яаж шийдвэрлэх вэ, яаж цаашидаа байхгүй болгох вэ гэдэг тэр концепцыг ерөөсөө оруулж ирэхгүй байгаа. Тэгээд энэ дээр Баялгийн сан дээр оруулаад ирэх болов уу гэж бодсон чинь үгүй байна. Тэгэхээр энэ баялгийн сан чинь хамгийн гол нь төрийн өмчийн компаниудын орлого дээр суурилагдаж л үйл ажиллагаа явуулах ёстой. Тэгтэл тэр төрийн өмчийн компанийн удирдлага менежментийг зөв болгох асуудал хамгийн гол нь цүнх баригч нар очиж тэнд хулгайлдаг байдлыг л зогсоох нь хамгийн чухал байхгүй юу даа.

Тийм учраас энэ хуультай Баялгийн сангийн хуультай миний өргөн барьсан “Эрдэнэт” үйлдвэрийн 20 хувийг Монголын ард түмэнд үнэгүй эзэмшүүлэх, 20 хувийг нь НДШ төлдөг ажилтан, албан хаагчтай үндэсний компанид тодорхой үнээр борлуулж эзэмшүүлэх энэ тогтоолын төслийг хамтатгаж хэлэлцэх ёстой гэж би үзэж байгаа.

Яагаад гэвэл Компанийн тухай хуулиар хэрвээ 36 хувиас дээш гарсан тохиолдолд тухайн компанид ард иргэд өөрсдийнхөө төлөөллийг оруулах ийм боломжийг бүрдүүлэх юм. Миний тогтоолын төслийн дагуу бол 21 аймаг, 9 дүүргээс хамгийн шилдэг хүмүүс тэр ард иргэдээр шүүгдэж гарч ирээд, санал авч гарч ирээд тэр ТУЗ-ийг байгуулаад, тэндээсээ хамгийн сайн гүйцэтгэх удирдлага буюу захирлуудыг томилох ийм боломжийг бүрдүүлэх юм байгаа юм. Ингэсний үр дүнд тухайн төрийн өмчийн компани илүү шилэн, ил тод, хариуцлагатай, хамгийн гол нь цүнх баригч очдоггүй, хулгай хийдэггүй л байх ийм боломжийг бүрдүүлэх ёстой юм байгаа юм. Тэгээд хэрвээ энэ тогтоолын төсөл үр дүнтэй цаашидаа хэрэгжээд явах юм бол Монгол Улсын стратегийн орд бүхий төрийн өмчийн компаниуд дээр бүгд дээр нь энэ зарчмаар ажилласны үр дүнд энэ төрийн өмчийн компаниуд илүү үр дүнтэй. Хамгийн гол нь Монгол Улсын иргэд Үндсэн хуулийн 6.2-т заасан газрын

доорх баялаг, газрын доорх баялаг бол ард түмний өмч гэдэг тэр суурь заалтын хэрэгжих үндэс болох байхгүй юу даа.

Гэвч харамсалтай нь өнөөдөр энэ Засгийн газар яг энэ асуудлаар ерөөсөө оруулж ирсэнгүй. Тийм учраас энэ газрын доорх баялгаа Монголын ард түмэн тэгш хүртчихмээр байна. Тэндээсээ янз янзын дээрээ хулгайгүй, доороо ард түмэн бүгдээрээ үр ашгийг нь хүртсэн ийм л нийгмийг Монголын ард түмэн хүсээд байгаа. Тэгэхээр энэ зарчим дээр Баялгийн сангийн тухай хууль дээр миний өргөн барьсан тэр тогтоолын төслийг “Эрдэнэт” үйлдвэрийн 40 хувийг ард иргэд, компаниудад хувьчлах, ингэсний үр дүнд тухайн компани илүү сайн ажиллах ийм боломжийг бүрдүүлж, ашиг орлого улам нэмэгдэх тэр зүйл сайжирна л гэж үзээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр харамсалтай нь дахиад л нөгөө 3 сан байгаа. 3 сан дээр нь Засгийн газар мөн түүнчлэн яамнууд тэр санг нь удирдана гэх дээр цүнх баригч нар дахиад л оччих гээд байгаа байхгүй юу даа. Тэгэхээр дахиад л нөгөө хулгай чинь үргэлжилсэн хэвээрээ л байна. Тийм учраас энийг олон нийтийн болгох, менежментийг нь сайжруулах тэр ажлуудыг л энэ Баялгийн сангийн тухай хууль дээрээ хэрэгжүүлэх ёстой. Энэ хэрэгжүүлэхэд хамгийн тус болох тэр тогтоол бол миний өргөн барьсан тогтоол байгаа. Тийм учраас энэ тогтоолыг энэ баялгийн сантай хамтатгаж хэлэлцэж өгөөрэй гэж хүсээд байгаа юм.

Г.Занданишатар: Энэ асуулт хариулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Тэгээд 12.4 дээр авто замын болон төмөр замын дэд бүтцийн гээд нэмчихсэн учраас энэ дээр нөгөө ноогдол ашгийг нь тодотгож л уул уурхайн төрийн өмчит компаниудыг зааж байгаад л бараг найруулгын шинж чанартай заалт л даа.

Санал хураалт. Таны асуудал дуусчихсан. Санал хураалт. 27 гишүүн дэмжиж, 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ тэгэхдээ тэр авто зам

дэд бүтцийн компаниудынхаа уг нь орлогыг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх гэж уг нь оруулсан юм байгаа биз дээ. Тэгээд энэ чинь хуримтлалын санд бол ямар ч байсан орохгүй болчихлоо шүү дээ тээ.

7.Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг, мөн 12 дугаар зүйлийн 12.8, 12.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын, авто зам, төмөр замын дэд бүтцийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл авъя гэж байгаа юм. Энд Бямбацогт сайдынхаа саналыг оруулаад, ингээд аваад оруулаад боловсруулчихъя. Цааш нь гүйцээн боловсруулчихъя гэж байгаа юм. Чиглэл өгөөч ээ гэж хүсээж байна.

Г.Занданишатар: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Гүйцээн боловсруулах чиглэл өгчихлөө. Алх тогичихлоо. Тэгээд саналыг харгалзаж үзээд гүйцээж янзалъя гэж байна шүү дээ.

8.Төслийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийн “ордын төрийн эзэмшлийн хувийг” гэснийг “ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. 12.7 шүү. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Энэ заалт дээр анхаарахгүй бол энэ чинь нөгөө бид нарын балагт “Оюутолгой”-н гэрээний л нэг хувилбар гарах гээд байна шүү дээ. “Оюутолгой”-д төрийн эзэмшлийн 34 хувьдаа бид нар 2,3 тэрбум долларын өр үүсчихсэн гээд байгаа. Тэгэхээр бид нар төрийн эзэмшил энэ ордынхоо эзэмшлийн тухай ярих юм уу. Энэ дээр чинь бол

ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмших хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцаа гээд байгаа юм. Энэ 2 дээр асуудал гарах уу, үгүй юу. Энийг ажлын хэсэг та бүхэн маань анхаарч үзэхгүй бол дахиад нөгөө Оюутолгой, Рио Тинто ийм асуудал чинь л явах юм бол 2,3 тэрбумын өрийн тухай асуудлыг болохоор Монголын талын эзэмшиж байгаа 34 хувьтай холбогдуулаад тэрийг бол нэг бүрчлэн тооцоод байдаг. Гэтэл нөгөө талд нь Рио Тинто компанийн тэр олон охин компаниудтай нийлсэн 66 хувийн хөрөнгө оруулалт яг энэ хэтрэлт ямар хүүтэй авсан энэ бүх юмнуудыг бол ерөөсөө ойлголт байхгүй бид нар явж байгаа шүү дээ. Тэгээд ямар ч байлаа гэсэн Их Хурал бол 2021 оны 12 сарын 31-нд баруун, зүүн дээрээ гарч байгаад 1 юм 103 дугаар тогтоол баталсан. Тэгээд энэ хүрээндээ үүсчхээд байгаа 2,3 тэрбум долларын тухай асуудлыг тэглэсэн. Ярьж байгаа. Гэтэл 66 хувийн асуудал хаана байна. Тэрийг нь энэ тогтоолоор заагаад өгчихсөн. Аудитын тэгэхдээ хараат бус тэр аудитын байгууллагыг аль байгууллагыг сонгон шалгаруулж оруулахыг Монголын тал мэдэхээр орсон гэх мэтчилнээр хийх ажлууд зөндөө байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм жишээгээр л цаашаа явах юм бол ерөөсөө баялаг маань бол гарын салаагаар л урсана. Дахиад л одоо үндэстэн дамнасан компаниуд энэ дотоод, гадаадын шуналт бүлэглэлүүдийн гараар ороод л өнөөдөртэй золгож байгаа шүү дээ. Яг л ийм байдлаараа явах байхгүй юу даа. Тэгээд тийм учраас энэ дээр анхаарах хэрэгтэй. Энэ ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөр гэхэд чинь жишээлэх юм бол Оюутолгой 2021 онд 108 сая, 2022 онд 88 сая. Тэгтэл нөгөө муу турж үхэх гээд байгаа гээд нэрлэгдээд байсан “Эрдэнэт” маань харин 2,4 дахин их буюу 2021 онд 220 сая ингээд 2022 онд 248 сая гээд ингээд нэмэгдээд яваад байгаа байхгүй юу. Тэгээд ийм юмнуудыг анхаарахгүй бол болохгүй шүү. Үнэхээр энэ гадаад дотоодын шуналт бүлэглэлүүд бол би дахиад хэлье, дахиад хэлье. Эд нар бол

арай хэтэрч байгаа байхгүй юу. Энэ хуулийн хулгайг бол зүгээр хамрын доороос нь л авдаг хүмүүс шүү дээ. Би зүгээр жишээтэй юутай нь хэлж чадна шүү.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Энэ яах вэ, төрийн эзэмшлийн ордын төрийн эзэмшил гэдгийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг л гэж тодруулсан. Стратегийн орд газрууд 35 хүртэл эзэмшинэ гээд заачихсан тийм ээ. Тэгээд орлого төвлөрүүлэгч этгээд нь толгой компани гэхээр “Эрдэнэс Монгол” ХХК гээд бараг биччихмээр л юм шиг санагдаад байгаа юм даа энэ хуульд. “Эрдэнэс Монгол”-ыг хэлж байгаа биз дээ. Санал хураалт явуулъя.

Ер нь хууль ойлгомжтой байх үүднээс байна шүү дээ. Хууль зүйн техникийн хувьд “Эрдэнэс Монгол” гэж нэр оноочихсон л юм бол “Эрдэнэс Монгол” ХХК гээд шууд орлого төвлөрүүлэгч этгээд гээд дахиад төөрүүлээд ингээд орлого төвлөрүүлэгч этгээд нь юу юм бэ гээд ингээд хаагаад л яваад байгаа юм л даа. Тэгээд энгийн ойлгомжтой байх юм бол зүгээр “Эрдэнэс Монгол” ХХК гээд биччихвэл бараг дээр л юм байна лээ. Нэрийг нь өөрчлөхгүй л бол. 59,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудал.

9.Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “эзэмшлийн” гэснийг “төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Ингээд л байх тусам хууль сунжраад л байгаа шүү. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

12 дугаар зүйлийн 12.11-ийг хасах саналыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ шүү.

С.Бямбацогт: Энэ Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл хуулийн төсөлд заасан заалтууд нь өөрчлөгдөөд байна л даа. Түүрүүн ярьсан. Зарим заалт нэмээд замын компаниас, төмөр замын компаниас орлого төвлөрүүлнэ гээд. Уг нь замын компани, төмөр замын компани чинь ачаа тээврийг аль болох хямдхан зардлаар ард иргэдэд хурдан шуурхай тээвэрлэж хүргэх л үүрэгтэй л дээ. Үндсэн үүрэг нь. Гэтэл одоо ингээд орлого төвлөрүүлээд орчхож байгаа юм. Тэгээд одоо яамгүй болгоод “Эрдэнэс Монгол” гэж компани удирдаад явахгаар иймэрхүү юм болох гээд л явж байгаа. Энийг бас эргэж ярилцъя гэсэн. Энэ дээр бас Засгийн өргөн барьсан төслөөс хасах гээд байна л даа. Засгийн газрын өргөн барьсан. 12.11 уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн эзэмшлийн хувьцааг иргэдэд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхийг хориглоно гэж. Энийг бас яагаад ингээд хасахаар болчихсон юм бол. Энэ дээр ажлын хэсэг хариулт өгч болох уу. Энэ одоо бас бид нар нэлээн анхаарах ёстой. Бид нар ганцхан “Эрдэнэс Тавантолгой” компаниас л хувьцаа эзэмшээд, иргэд маань 350 мянган төгрөг авч байгаа. Одоо ингээд олон стратегийн ордуудаас, стратегийн орд эзэмшигч компаниудаас хувьцаа Монгол Улсын 3 сая 500 мянган иргэд маань бас хувьцаа эзэмших эрхтэй болох гэж байгаа. Боломжтой болох гэж байгаа. Энэ хэмжээгээр иргэдийн маань орлого нэмэгдэнэ. Эрүүл мэнддээ зарцуулж болно. Боловсролоо зарцуулж болно. Сургалтын төлбөртөө зарцуулж болно. Цаашилаад бас бид нар нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлүүлэх, эрүүл мэндийнхээ даатгалыг төлүүлэх, иймэрхүү бас бололцоо боломжийг суутгуулах ийм боломжууд нэмэгдэх л ёстой юм л даа.

Тийм болохоор аль болох олон компанийн хувьцааг эзэмшээд, үүнээсээ жил болгон бэлэн мөнгөөр авдаггүй ч гэсэн бэлэн бусаар ингээд бас төрийн үйлчилгээндээ зарцуулах ийм бололцоог л нээж өгөх гээд байгаа юм. Гэтэл энийг Засгийн газрын өргөн барьсан төслийг хасахгүй явсан бол яасан юм бол. Яагаад ингээд хасах гээд байгаа юм бол. Энэ дээр нэг тайлбар байж болох болов уу.

Г.Занданшатар: Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлж байгаа л даа. Энэ чинь иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхийг хориглолцоод байна шүү дээ энэ заалт чинь. Энийг л хасаж байгаа юм. Ашигт малтмалын хуульд стратегийн орд газруудын 10 хувийг иргэдэд эзэмшүүлнэ гэсэн заалт бий. “Эрдэнэт” компани ч юм уу, түүрүүн ажилчдадаа жишээлбэл, үнэ төргүйгээр ESOP гэж /employee stock option plan/ гэж байдаг. Тэр бүх боломжийг шууд хуулиар хориглолцоож болохгүй юм гэсэн агуулгаар л энэ заалтыг хасаж байгаа юм байна гэж ойлгож байгаа юм. Харин энэ даширамд бас нэг зүйл дурдчихъя. Түүрүүн бас зарим гишүүд яриад байсан. 1072 хувьцааг нөгөө 500 мянган төгрөг авчихсан ахмадууд шууд дээрээс нь өгчихсөн шүү дээ. Ахмадууд, оюутнууд хасагдчихаад одоо нөгөө ноогдол ашиг энэ тэр авахаараа эргэж авъя гэсэн асуудлууд тавиад байгаа. Тэгэхээр энийг нөгөө ноогдол ашигаасаа суутгах замаар хувьцаагаа эргэж эзэмших бололцоог нь нээж өгөх асуудлыг бас энэ Сангийн хуулиараа шийдчихмээр байгаа юм. Иргэд тийм санал тавиад байна лээ. Тэр бол илүү конструктивный буюу бүтээлч хандлагаар. Зүгээр үнэ төлбөргүй буцаагаад эзэмшүүлэхээр шударга бус. Зарим хэсэг нь түүрүүлээд мөнгө авчхаад. Гэхдээ ноогдол ашигийнхаа 200 мянга, 500 мянга авахгүйгээр хувьцаагаа эргээд сэргээж болно гэсэн үг байхгүй юу. Тэгээд 2, 3 жилийн дараа эргээд хувьцаа эзэмшигч болох. Тэгэхгүй бол зарим хэсэг нь эзэмшээд, зарим хэсэг нь эзэмшихгүй байгаа энэ харилцааг ийм замаар зохицуулах боломжийг судлаад, тэгээд та хэд бас оруулж ирвэл сайн байна.

Ингээд санал хураалт явъя. Төслийн 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсгийг хасах. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баттөмөр гишүүн ээ, ингээд суутган тооцох замаар эргээд сэргээчихвэл байна шүү дээ хувьцаа эзэмшигч эрхийг нь сэргээхгүй бол алаг цоог болоод байна л даа. Тийм ээ. Тэгэхгүй бол энэ асуудал ер нь яригдах юм байна. Өглөө ч гэсэн зарим гишүүд яриад сүүлд нь шахагдаж, шахагдаж их асуудал гарч ирж магадгүй. Үгүй ээ, энэ чинь суутгачихсан байгаа байхгүй юу. Жишээлбэл 1072 хувьцаа биш оюутнууд зарим нь талыг нь аваад байгаа байхгүй юу. Одоо жишээлбэл тэр тухайн үед оюутан байж байгаад 500 мянган төгрөг авчихсан хүн чинь 1072 биш 500 хэдэн хувьцаатай байдаг юм шиг байна лээ. Олон олон. Ахмадууд ч гэсэн тийм байгаа.

11.Төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал 55.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саяын саналыг бол Дархан хотын иргэд их тавиад, зарчмын хувьд байж болох юм гээд Жавхлан сайд, Дамдинням гишүүн 2 бол хэлчихсэн байна лээ. Уулзалтынх нь бичлэгийг би үзсэн.

12.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1. Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

8.1.Сангийн эх үүсвэрийг холбогдох журмын дагуу хуваарилалт хийснээс хойш ажлын таван өдрийн дотор Монголбанкна дахь Сангийн дансанд шилжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бодвол нөгөө орлого төвлөрүүлэгч этгээд “Эрдэнэс Монгол” энийг шилжүүлэх байх л даа. Энэ төрийн сангийн данс гэдэг нь байх юм уу, үгүй юм уу гэдгээ бас.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг, 8.3 дахь хэсгийн, 9¹ дүгээр зүйлийн 9¹.1 дэх хэсгийн “энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Сангийн” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түрүүчийн санал 69,8 хувийн саналаар санал дэмжигдсэнийг протоколд тэмдэглэе.

Дараа нь Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн гарчгийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 30 гишүүн дэмжиж, 59,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 5³ дугаар зүйлийн “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.2-т” гэснийг “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.б-д” гэж тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5³ дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураагаад явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “33.2.11” гэснийг “33.2.10” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “5.3.27” гэснийг “5.3.26” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй бас нэг саналын томъёоллын 1 санал байна.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 33 дугаар зүйлийн 33.2.10 дахь заалтын “33.2.6-д” гэснийг “33.2.6, 33.2.10-д” гэж, мөн зүйлийн 33.2.10 дахь заалтын дугаарыг “33.2.11” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 30 гишүүн дэмжиж, 59,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт буюу 21.1.16 дахь заалт, 30.14 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчит /өмчийн оролцоотой/” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 31 гишүүн дэмжиж, 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйл буюу 30.10.1 дэх заалтын “ашигт малтмалын” гэснийг “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын” гэж өөрчилж, мөн зүйлийн 30.10.2 дахь заалтын “бусад тохиолдолд” гэсний өмнө “энэ хуулийн 30.10.1-д зааснаас” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 хувийн саналаар биш, 59,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийн “сангийн” гэсний дараах, мөн зүйлийн “орлого,” гэсний дараах “хөрөнгө оруулалтын орлого” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 30 гишүүн дэмжиж, 59,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийн “20-оос” гэснийг “34-өөс” гэж өөрчилж, мөн хэсгийн “эзэмших” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулна. Энэ чинь 20-оос гэж 20 хувийг 34 болгоод эзэмших гэдгийг чинь яагаад хасчхаж байгаа билээ. Санал хураалт. 31 гишүүн дэмжиж, 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ энэ дээр их утгын алдаа болгочоод байна шүү. Эзэмших гэснийг хасахаар эцсийн найруулга дээр янзлахгүй бол энэ чинь ийм утгатай болчхоод байна. Аливаа этгээд дангаар болон харилцан хамаарал бүхий этгээдийн хамт стратегийн ач холбогдол бүхий. Хамт эзэмших гэдэг үг хамт гэдэг үг хамт хасагдахгүй бол хамт эзэмших гэхээр эзэмших гэдгийг нь авчхаад хамт стратегийн ач холбогдол гэдэг чинь одоо ямар байна. Найруулгаар хамт гэдэг үгийг хасахаар хамт хураалгахгүй бол хасвал хамт эзэмших гэдгийг хасахгүй бол энэ өгүүлбэр чинь тэгээд хэрэгжихгүй болчхоод байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5.8 дахь хэсгийн “хуулийн этгээд /төрийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/-ийн” гэснийг “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “гэрээ байгуулсан” гэсний дараа “тохиолдолд тухайн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ өгүүлбэр ч гэсэн их л сонин л утгагүй болчхоод байна. 68,2 хувийн саналаар санал дэмжигдсэн.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн “5.9.Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан энэ хуулийн 5.7-д заасан хуулийн этгээдийн хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэр түрүүний 2 дахь хураасан. 5.8 дахь хэсэг чинь байна шүү дээ. Тохиолдолд тухайн хуулийн этгээдийн гээд орчихоороо агуулга нь өөр ойлгогдохгүй л болоод байх юм.

4.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/9 дүгээр зүйлийн 9.1.16, 9.1.17 дахь заалт:

9.1.16.энэ хуулийн 5.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийг удирдах, хуулийн хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхт төлөөлөгчийг томилох;

9.1.17.энэ хуулийн 9.1.16-д заасан бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг энэ хуульд нийцүүлэн батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 72,7 хувийн саналын санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран —ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болох бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.”

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат 2 гишүүнээр тасаллаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Энэ дээр бас жоохон нухацтай хандвал яасан юм бэ гэж би бас хэлэх гээд байгаа юм. Стратегийн орд энэ улсын төсвөөр хайгуулыг нь хийгээд тогтоочихсон орд. Тэр доор юу байгааг мэдэж байгаа. Тэгээд энэ нь ямар нэгэн хэлбэрээр энэ замбараагүй явж ирсэн цаг хугацаанд лиценз нь хувь хүмүүсийн гар дээр оччихсон. Энэ бол бараг энэ Баялгийн сангийн хуулийн амин сүнс нь байх. Энэ стратегийн орд бид нар 16 гэж байгаа, хавсралтад нь дахиад 39 гэж байгаа. Үндсэндээ 55 ордын асуудал яригдахаас өнөөдөр яг энэ хууль нөлөөлөх энэ хуулийн ашиг тус өгөх орд нь 6-хан байгаа шүү. Үлдэж байгаа 49-ийг нь яг энэ хуулийн энэ заалтаар төр эргээд хувийн хэвшлийнхнийг гуйх болж байгаа байхгүй юу. Хаана байгаа, юу байгаа, ямархуу нөөцтэй гэдгийг нь мэдсээр байж өгчихсөн ордоосоо тэдэн хувийг нь өгчхөөч гэж. 50 хүртэл гэдэг үг чинь муухай бөөрөнхий үг байна. Яагаад 50 хувь байж болдоггүй юм бэ. Үнэ төлбөргүйгээр эзэмшиж болох бөгөөд болно, болох гэдэг үгний чинь ард болохгүй ч байж болно гэсэн агуулга явж байгаа шүү. Та нар энийг өөрсдөө мэдэж байгаа байх. Тэгэхээр өнөөдөр үнэхээр бид нар баялгийн хуулийг батлаад, ард түмэндээ энэ 3 сангаар дамжуулаад хөрөнгө оруулалт хийнэ, ард түмний өмнө тулгамдаад байгаа олон асуудлуудыг шийднэ. Ирээдүйд байгаа төрөх иргэддээ хуримтлалын сан үүсгэнэ гэж байгаа бол ядаж энэ нөөцийг нь тогтоочихсон ордынхоо 50 хувь гээд ингээд нэг шууд оруулчих тийм зүйл байхгүй юу. Энийг чинь яаж л бол яаж ашиглана гэдгийг та нар бүгдээрээ мэдэж байгаа даа.

Дараагийнх нь тэр улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж. Энэ дээр бол яах вэ, эрсдэлээ үүрээд аж ахуй нэгж нь хийжээ. Хөрөнгө оруулалт хийжээ. Энэ дээр 50 биш 34 хувь гээд ингээд

оруулчхаж болдоггүй юм уу. Дахиад л ийм бөөрөнхий 34 хүртэлх энэ чинь 1 ч байж болно, 2 ч байж болно, 33 хувь ч байж болно шүү дээ. Тэрийг та нар дахиад л мэдэж байгаа. Яг энийг ингээд барьчихсан нөхдүүд бол 34 хувиа май гэж өгөх үү. 50 хувиа май гээд өгөх үү. Өгөхгүй гэдгийг ч мэдэж байгаа шүү дээ та нар. Тэгээд 1 ийм худлаа Баялгийн сангийн хууль гэж ийм сайхан хууль оруулж ирээд, тэгээд дотор нь яг амин сүнс болсон нөгөө ард түмэнд ашгаа өгөх ордууд нь өнөөдөр ч тодорхой биш байгаа. Байгаа юмнаас нь авъя гэхээр ингээд болох ч юм шиг, болохгүй ч байж болох юм шиг ийм хогийн бөөрөнхий юм оруулж ирээд Их Хурал дээр ингээд явуулж байгаад би бол харамсалтай санагдаж байна. Тэгэхээр энэ дээр Их Хурлын гишүүд маань бас жоохон бодолтой хандаж, энэ хуулийн заалтыг эргэж харж, Их Хурлын дарга гүйцээн боловсруулах чиглэл өгдөг юм уу, яадаг юм гэсэн ийм саналтай байна. Дмжихгүй гэсэн саналтай байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн ажлын хэсэг үг хэлнэ. Эхлээд Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ. 2 гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Энэ бол ерөөсөө л гол хулгай луйвар... Идэрбат аа, би үг хэлж байна. Гол хулгай луйврын эхийг тавьсан энэ хуулийн заалтыг чинь би онтой, сартай нь хэлээд байгаа шүү дээ. Энэ чинь 2006 онд энэ “Айвенхоу Майнз”-д “Оюутолгой”-г өгөхийн тулд л Ашигт малтмалын хуульд бүр Сингапурт очиж сууцгааж байгаад гадаадынхны заавраар хийсэн энэ заалт чинь л энэ шүү дээ. Тэгээд энэ чинь ганцхан “Оюутогой”-оор дуусаагүй. Араас нь Цагаан суварга, Ноён уулын алт, энэ бүх юм ч орж ирсэн шүү дээ. Та бид нар мэдэж байгаа. Энэ хуучин сууж байсан хүмүүс. Сентерра гоулд Ардын нам тэгэхэд цөөнх байсан. Их Хурал дахь намын бүлгүүдээр танилцуулаад, бид нар энэ “Бороо гоулд”-ыг авсан үйлдвэрийн бааз байна. Хөрөнгө, санхүү бүгд бэлэн байна. Энэ ганцхан урт нэртэй хуулиар ашиглах энэ

боломж нь хязгаарлагдаад байгаа стратегийн ач холбогдол бүхий орд газарт та нар маань энийг аваад өгчих. Монголын Засгийн газрын эзэмших хувийг хэдээр ч бид тогтоож өгөхөд бэлэн байна. Монголын Засгийн газраас ямар ч хөрөнгө, санхүү бид шаардахгүй гээд ингээд танилцуулга хийж Их Хурал дээр явж байгаад тэгээд Засгийн газар руу очоод 1 сар болоод хүрээд ирэхэд Засгийн газар 370 сая билүү, 300 гаруй сая долларын хөрөнгө оруулалт шаардаж байна. Тийм учраас энэ 300 хэдэн сая доллар гарах бололцоо байхгүй. Тийм учраас бид бол энэ ямар ч төрийн эзэмшил хувьцаа эзэмшихгүй гээд ингээд л оруулаад ирдэг шүү дээ. Тэгээд яг энэ бололцоог нь бол энд байна шүү дээ. Одоо энд жишээлэх юм бол энэ чинь яагаад би түрүүн бас 12.7 дээр би бас тодорхой л асуусан. Эсвэл энэ баялгийг түшиглэж байгуулсан компанийн хий хоосон хувьцаа эзэмшээд, тэгээд амаараа шороо үмхдэг. Эсвэл хувьцаа эзэмшихдээ эзэмшиж болно. Тэгэхдээ гаргах хөрөнгийнхөө хэмжээгээр мэднэ гээд л тэр ноён уулын жишгээр л явна шүү дээ. Тэгээд энэ чинь “Оюутолгой”-д зориулсан энэ Ашигт малтмалын хуулийн цоорхой чинь дараа дараагийн том бүх стратегийн орд газруудыг алдах тэр нүх сүв л болсон юм шүү дээ. Хамгийн том бид нарын гайхамшиг гээд ингээд яриад байгаа “Оюутолгой”-н Хөрөнгө оруулалтын гэрээ чинь 15 жилийн дараа юу боллоо доо. Та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд эндээс чинь бол тэр 103 дугаар тогтоолоос чинь энэ Монгол Улс өөрийнхөө баялагт 34 хувийг үнэ төлбөргүй эзэмшинэ. Та нарын энэ одоо 34 хувь эзэмшиж байгаа Монголын талд оногдуулсан энэ өр чинь байхгүй гээд одоо тэглүүлсэн шүү дээ. Тэр эсвэл хий хоосон өр тэглүүлсэн байх нь, эсвэл энэ чинь хоорондоо ийм алдаатай ийм зүйл болох гээд байна шүү дээ. Одоо энийгээ өглөө бол засна гэж яриад байсан. Тэгээд энэ яг зүйл заалт чинь бол хэвээрээ л орж ирж байна шүү дээ. Тэгээд одоо энэ жишээлэх юм бол энэ 5.5 дээрээ бол улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийн цогцоос стратегийн ач

холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хувийг эзэмшинэ гэж ярьж байна шүү дээ. Тухайн ордод хөрөнгө үүснэ. Тэрийгээ “РиоТинто” шиг “Айвенхоу Майнз” шиг хэд ч болгож өсгөж болно шүү дээ. Өнөөдөр жишээлэх юм бол 2013-2020 оны энэ үйл ажиллагаа “Оюутолгой” чинь бол 4,6 тэрбум долларын алдагдал хүлээхдээ бидэнд үүрүүлээд ингээд л байж байгаа ийм л зүйл шүү дээ. Тэгээд ийм юмтай ноцолдоод байвал ямар байх юм байгаа юм. Энэ чинь 1 долларын бүтээгдэхүүн гаргахад 1,46 долларын зардал гаргаж байгаа алдагдалтай гээд тэрийг нь хаана ч тооцох бололцоогүй ингээд явсаар байгаад л өнөөдөр ийм алдагдал гаргачхаад л бидэнд үүрүүлээд байгаа шүү дээ. Тэгээд энийгээ нүх цоорхойг нь хаахгүй бол энэ үнэхээр бид баялагтаа эзэн байх тухай асуудал бол байхгүй шүү дээ. Энийг 2008 оноос гэхэд 16 жил л үүний араас хөөцөлдөж байгаа юм. Ийм л зүйл байгаа юм. Тийм учраас энэ бол байж болохгүй. Маши тодорхой ордоо, баялгаа эзэмшигч улсын хувьд энэ бусад улс орнуудын жишгээр төр хайгуул хийнэ гэж нөөцийг нь тогтоосон бол 5 хувь, хувийн аж ахуйн нэгж өөрөө хөрөнгө гаргаад хайгуул хийсэн бол 34 хувь нь үг дуугүй эзэмших ийм л заалттай байх ёстой шүү дээ. Ийм л байр суурьтай байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ 2 заалт бол ажлын хэсэг оруулж ирж байгаа шүү. Маш их төвөгтэй юм байна лээ. Хажууд сууж байгаа хүмүүсээс өгсүүлээд тэгэх ёстой шүү, байж болно гэж заана гээд л. Засгийн газрын оруулж ирсэн төсөлд энэ байхгүй. Би бол үг хэлж байгаа хүмүүстэй бүгдтэй нь санал нэг байна. Монголын баялгийг бол хэдхэн хүн авчихсан. Гаднынханд худалддаг ийм л байдалтай байгаа байхгүй юу. Тэгээд та бүгд дэмжинэ гэх юм бол энэ дээр гүйцээн боловсруулах санал Их Хурлын даргаас өгөх юм бол энийг тэр улсын

төсвөөр хайгуул хийсэн нөөцийн 50 хувийг төр эзэмшинэ гэдэг. Энэ эхний заалт. Доод талынх нь 34 хувьтай тэнцэх төр эзэмшинэ гэсэн заалтыг бид нар оруулаад ирье. Дэмжинэ гэвэл. Тэгээд энэ дэмжигдэхгүй тэгээд л унах юм бол тэгээд л энэ чинь тэр чигээрээ байхгүй болно шүү дээ. Нөгөө л хуучнаараа л энд 50 хүртэл хувийг эзэмшинэ гэдэг энэ заалт ч байхгүй, шинэ ч байхгүй л болно. Тийм учраас энийг яадаг юм. Бүлэг ярих юм уу, яах юм. Энэ бол цэвэр яг ажлын хэсгийнхний оруулж ирж байгаа санал шүү. Одоо манай “Эрдэнэс Тавантолгой” компанийн “Эрдэнэс Эрдэнэс” манай Наранцогт бид нар ажлын хэсэгт сууж байгаад ингээд оруулж ирсэн санал шүү. Дэмжинэ гэвэл энийг сая яг хэлж байгаагаар нь оруулаад ирье. Дэмжихгүй гэвэл дахиж яагаад хэрэггүй шүү.

Г.Занданишатар: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Холбоотой асуудал байгаа. Тэгэхээр байна шүү дээ түрүүн 5.7 дээр байна шүү дээ. Аливаа этгээд дангаараа болон харилцан хамаарал бүхий этгээдүүдтэйгээ нийлээд стратегийн орд газраас гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг эзэмшихийг хориглоно гэж байгаа шүү дээ. Тийм агуулгатай шүү. Тэгэхгүй бол хамт эзэмших гэдгийг хасаад тэр өгүүлбэрийг ерөөсөө гол санааг аягүй бүрхэгдүүлээд энэ заалтыг санаатай, санамсаргүй аль нь боловч нэг тийм бүдгэрүүлчихсэн байна. Тийм учраас 5.7-оо дахиж хамт, тэгэхгүй бол дангаараа биш юм аа гэхэд харилцан хамаарал бүхий этгээдүүдээр ингээд нийлээд л 50, 60 хувийг эзэмшиж байдаг байж болохгүй шүү дээ. Хамт эзэмших гэдэг үгээ энэ тэрийг зөв найруулах хэрэгтэй. Энийг ч гэсэн тодорхой болгохгүй бол хууль 2 утгатай байж болохгүй л дээ. Тийм учраас 50 дотор 34 ч орно, 50 хүртэлх гэхээр 34 хүртэл ч орно. Бүгд юм ингээд ороод тэгээд энийгээ их тодорхой болгож хуульчлах шаардлагатай. Тэгэхгүй бол энэ дараа нь ахиад нэг хэрүүлийн алим болох юм байна. Тийм учраас тодорхой болгож

хуульчилж гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

6. Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 2/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2/8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт:

8.1.7.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох болон ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ Улсын Их Хурлын бүрэн эрхэд оруулж ирж байгаа юм байна. Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхээр оруулж ирнэ. Саяын санал 59,1 хувийн саналаар дэмжигдсэн.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 3/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

9.1.5.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг.

5.4, 5.5-ыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас түүнтэй уялдуулж энийг бас гүйцээн боловсруулах чиглэл

өглөө. Улсын Их Хурлаар оруулж ирж ишийдвэрлэх л юм байна л даа.

8.Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 31 гишүүн дэмжиж, 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг томъёолол дэмжигдсэн тэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дэх заалтын “холбогдуулан” гэсний дараа “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигласны үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр” гэж нэмж, мөн заалтын “2029 оны 1 дүгээр улиралд багтаан” гэснийг төслийн 1 дэх заалтын 1.2 дахь дэд заалтын “боловсруулж,” гэсний дараа шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 30 гишүүн дэмжиж, 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Монгол Улсын иргэн бүрд 2024 оны 2 дугаар улиралд багтаан хуримтлалын нэрийн данс үүсгэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Би энэ дээр давхар хэлэх гээд байна. Түрүүн Их хурлын дарга хэлсэн. Энэ 1072 хувьцааг энэ сайн хувьцаа нэртэй ийм хөтөлбөр хэрэгжүүлээд ахмадуудын 1072 хувьцааг янз бүрээр нь авчихсан. Оюутнуудын тал хагасыг нь авчихсан. Тэгээд энэ хувьцааг яаж эргүүлж эзэмшүүлэх арга хэмжээг авах юм бэ. Түрүүний хэлсэн одоо энэ чиглэлээр нь тодорхой юмыг оруулж өгөхгүй бол болохгүй ээ. Зүгээр тэр чигээр нь хаачих вий. Дараагаар нь энэ нас барсан иргэдийн хувьцааг өвлүүлэхтэй холбоотой харилцааг яаж зохицуулах юм. Энэ юмыг нь цогцоор нь авч үзэхгүй бол үнэхээр болохгүй шүү гэж 1 дүгээрт хэлэх гээд байгаа юм.

2 дугаарт. Түрүүн хэлсэн. Энэ баялагтаа эзэн байх үндсэн юу чинь бол эсвэл хүмүүсийн яриад байгаа шиг тэр ашигт малтмалын нөөц ашигласны роялти, юу байдаг юм тэрүүгээрээ бусад улс орнуудын жишигт хүргэж нэмэгдүүлэх, эс үгүй бол энэ гадаадынханд зарчхаад яваад байгаа. Одоо бид нар Дачин Тамсагийг мэдэж байгаа шүү дээ. “Соко интернешнл” гэж одоо гайхамшигтай Америкийн гуравдагч орны хөрөнгө оруулалт орж ир л гээд л баярлаад л, алгаа ташаад л, дээлээ тослоод л байсан. Тэгээд юу болсон. Хятадын компанид манайхаас ямар ч оролцоо байхгүйгээр шилжүүлчихсэн. Өнөөдрийн хэрүүл, хараалын талбар болчихоод л ингээд л байж байгаа шүү дээ. Яг энэтэй адилхан өөрсдөө баялагтаа эзэн байж, ордынхоо шүү тэр компанийн биш ордынхоо хувийг хөдөлгөөн байхгүйгээр эзэмшиж чадахгүй бол ийм л байдлаар болно шүү

дээ. Тэгээд сайхан хөрөнгө оруулагч нэртэй, зээл зуучилдаг, мөнгө хүүлдэг үгүй ээ, бүр хүүгээс хүү тооцож авдаг, нийлмэл хүү тооцоод авдаг ийм л юм тасрахгүй шүү дээ. Тэгээд үүний жишээг би хэлээд байгаа шүү дээ. “Оюутолгой”-д зориулж хийсэн Ашигт малтмалын хуулийн чинь цоорхойгоор дараа дараагийн стратегийн ордууд чинь ингээд цувраад цувраад гараад дууссан шүү. Заримыг нь бид нар нэг юм хэрүүл тэмцэл хийж байж байж зогсоосон, заримыг нь бол чадаагүй алдсан ийм зүйлүүд байгаа шүү. Ингээд энэ ажлын хэсэг дээр орж ажиллах саналаа өгсөн. Их Хурлын дарга бол ажлын хэсэгт оруулна гэсэн. Зүгээр мэргэжлийн хүндээ би оръё гээд байгаа юм биш. Энэ чиглэлээр Их Хуралд орж ирсэн цагаасаа 10 хэдэн жил үүний араас хөөцөлдсөн учраас оръё гэсэн. Оруулаагүй. Тэгээд энэ орж ирж байгаа юм чинь одоо ийм л байдалтай юм оруулж ирж байна шүү дээ. Тэгээд энийгээ тэр энэ ажлын хэсэг юмнууд нь эргэж анхаарч авч үзэхгүй бол энэ ерөөсөө цаашаа явахгүй шүү.

Г.Занданишатар: Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Энэ нэрийн данс үүсгэх асуудлыг 1 дүгээрт нь бас хуримтлалын нэрийн данс үүсгэх бас ийм хурдан амжих уу, амжихгүй юу гээд энийг бас бодмоор байгаа юм.

2 дугаарт нь ажлын хэсэг бас нэг анхааралдаа авчхаач ээ гэж. Бид нар нөгөө нэг хэсгийг нь бол ирээдүй хойч үедээ өвлүүлж үлдээнэ. Нэг хэсгийг нь бас өнөөдөр амьдарч байгаа иргэддээ өгнө. Хуримтлалын санд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууцын зориулалтаар дэмжлэг үзүүлнэ гээд орчихсон байгаа. Тэгэхээр ингээд яг эрүүл мэндээ зайлиггүй шаардлагагүй, дээрээс нь орон сууцын шаардлагагүй, боловсролын шаардлагагүй бас хүмүүс байж болно. Дээрээс нь өшөө илүү юу гэдэг юм, НДШ-

ээ төлж чаддаггүй, ЭМД-ын шимтгэлээ бас төлөх бололцоо, боломж муутай бас хүмүүс байгаад байгаа юм. Тэгээд энэ хүмүүс дийлэнх нь малчид. 800 гаруй мянган малчин иргэн байна. 200 гаруй мянган малчин өрх байгаа гэдэг нь хавартаа ноолуурын орлоготой, намартаа махны орлоготой. Бусад үедээ орлого олдоггүй. Жилийн турш тасралтгүй орлоготой байж байж түүнээсээ НДШ-ээ төлж байх ёстой. ЭМД-аа төлж байх ёстой. Тийм болохоор бас уг нь иргэдийг ЭМД-аа төлөх тэр энэ хувь хишиг хувьцааных нь ноогдол ашиг дээрээс энэ бололцоог бас бүрдүүлэх боломж бий болгох тал дээр, мөн бас НДШ-ээ бас энэ ноогдол ашигаасаа суутган тооцуулаад, тэр нь НДШ нь төлөгдөөд ирээдүйд тэтгэвэрт гарах боломж нь бүрдэж байх иймэрхүү заалтуудыг бас нэг ажлын хэсэг бас дахиж хуралдахдаа нэг анхаараад оруулчих юм бол бас илүү өргөн хүрээтэй, илүү бас илүү хүртээмжтэй, илүү бас нүдээ олсон зайлиггүй бас иргэдийнхээ тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн мөнгөөр нь аваад, юу гэдэг юм инфляцыг өсгөөд бараа бүтээгдэхүүн худалдаад авах биш. Ийм байдлаар бас нөгөө нийгмийн баталгаа, нийгмийн хамгаалал энэ чиглэлдээ бас нэг дэм болчих юм биш байгаа. Энэ тал дээр бас манай ажлын хэсэг бас эцсийн хэлэлцүүлэг хийх үедээ бас энэ боломжийг нэг судлаад анхаараад өгөөч ээ л гэсэн саналтай байна.

Г.Занданишатар: Санал хураалт явуулна. Өмнө нь нэг сануулж, анхааруулах зүйл байна. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай дэг жаяг тогтсон жаягаар хууль санаачлагч ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзээд хуулийн ажлын хэсэгт ажилладаггүй. Засгийн газар санаачилсан хуульд Засгийн газрын гишүүд тийм учраас ажлын хэсэгт ажилладаггүй тийм дэг жаягтай. 2 дугаарт энэ Засгийн газрын гишүүд байна шүү дээ хойшид оруулж ирж байгаа асуудал дээрээ танхим дээрээ нэгдэж орж ирээд, нэгдсэн байр

суурьтай баймаар байгаа юм. Энэ Бямбацогт гэж би хэлээгүй. Би бусад хуулиуд дээр, бусад бүх хууль дээр сайд нар салаа утгатай, хоорондоо зөрчилтэй, тэгээд Улсын Их Хурал дээр тэр хагарал чирэгдэл орж ирдэг. Ингээд үүнээс болоод асуудлууд гацдаг, удааширдаг цөөнгүй тохиолдлууд удаа дараа давтагдаж байгааг би одоо Засгийн газрын гишүүдэд онцгой анхааруулж хэлмээр байна. Засгийн газрын гишүүдэд онцгой анхааруулж хэлмээр байна. Энийг бол хэрэг эрхлэх газар, хойшид ч гэсэн Засгийн газрын гишүүд энийгээ анхаарч ажиллавал зохино. Танхимын зарчмаар ажилладаг энэ зарчмаараа. Одоо сүүлийн 3, 4 хууль дандаа хоорондоо зөрчилтэй. Тэгээд орж ирээд энд хэрэлдээд, гишүүдийг хуваагаад болохгүй байна. Сайд болгон өөр бодолтой. Засгийн газар дээрээ, танхим дээрээ, Засгийн газрын хуралдаан дээрээ нэг яриад нэг мөр ойлголттой болоод ороод ирж бай.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. 30 гишүүн дэмжиж, 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Яг тэр дэлгэц дээр гэрэл ойчоод харагдахгүй болчихоод байна.

4.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Хуримтлалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Хуралд өргөн мэдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ирэх оноос хэрэгжих бол энэ тодотгол хийх шаардлагагүй л болно л доо. Ингээд 62,2, хувийн саналаар санал дэмжигдлээ.

5 Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн дансыг Монголбанк дахь төрийн сангийн дансанд үүсгэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Төрийн сангийн нэгдсэн сан гэж угаасаа байгаа юм. Тэгэхдээ Ирээдүйн өв сан ч гэсэн бүгд төрийн нэгдсэн сангийн нэгдсэн данс чинь Монголбанканд байршидаг юм. Тэгээд Ирээдүйн өв сан ч гэсэн тэнд байршиж байгаа юм. Угаасаа л. Тийм учраас энэ дээр нэг их.

6.Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

15.13 цаг.

Дараагийн асуудалд орно.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён эгээрүүлэх, үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Төслийн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын

хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үндэсний хөдөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо 2024 оны 4 сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр баталж, мөрдүүлнэ.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2023 оны 209 дүгээр захирамжаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Баделхан, Баярсайхан, Бейсен, Энхболд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан.

Уг ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Хүний эрхийн комисс, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Монгол Улсын их сургууль, Удирдлагын академи, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн зэрэг байгууллагыг төлөөлөл мэргэжил арга зүйгээр хангасан. Тухайн хөтөлбөрийн төслийг Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас D-parliament.mn цахим талбарт байршуулж, олон нийтээс санал авч, Төрийн албаны зөвлөл цахим хэлэлцүүлэгт 2800 гаруй төрийн албан хаагчийг оролцуулан төслийг

хэлэлцүүлсэн бөгөөд яам, агентлагийн удирдах албан тушаалтнууд, иргэний нийгэм, судалгааны байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд зэрэг байгууллагын удирдлагыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг 7 удаа зохион байгуулж, нийт 45 төрийн болон төрийн бус байгууллагын 520 гаруй санал ирүүлснийг нэгтгэн тусгаж, хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Баделхан төрийн албаны цахим бүртгэлд хэдэн төрлийн үйлчилгээ бүртгэсэн талаар, Төрийн албаны шуурхай байдлыг хангах, цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд төрийн албан хаагчдыг цахим бүртгэлд хамруулж, дараагийн асуудлыг шийдвэрлэлгүй байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хөтөлбөрийн төсөлд тусгасан төрийн албан хаагч гэдэг захиргааны болон тусгай албан хаагчаас гадна улс төрийн албан хаагчийг хамруулсан эсэх талаар асуулт асууж, санал гаргасныг төсөлд төсөлд тусган, Тогтоолын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үндэсний хөтөлбөр батлах тухай” Их хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлуулж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Ойлголоо. Жаргалмаа гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя. Цэнддаваагийн Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Лхагвын Цэдэвсүрэн Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн дарга, Должингийн Баатарсайхан Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Баярын Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Доржсүрэнгийн Дуламсүрэн Ёс зүйн хорооны гишүүн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар, Минжүүрийн Цэрэнбат Ёс зүйн хорооны гишүүн АШУУИС-ийн багш, анагаах ухааны доктор, дэд профессор, Занданбазарын Цэдэнжав Ёс зүйн хорооны ажлын албаны Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга, Ганбатын Мягмар МУИС-ийн Улс төр судлал, Олон Улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн ахлах багш, төрийн удирдлагын доктор.

Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалмаа: Ийм хууль орж ирж байгаад бас баярлалаа гэдгээ хэлье. Тогтоолын төсөл орж ирж байгаад баярлалаа гэдгээ хэлье. Төрийн албаны тухай хууль орж ирж байхад би бас яг ярьж л байсан л даа. Ер нь төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх ёстой юм бэ. Төрийн алба хашиж байхдаа ёс зүйн алдаа гаргаж байгаа төрийн албан хаагчдаа харууцлага тооцдог байх энэ тогтолцоог ер нь бид хэрхэн яаж бүрдүүлэх ёстой юм бэ гэдэг зүйлийг бас хөндөж ярьж байсан. Тэгээд энэ тогтоолын төсөл орж ирж байгаа нь үнэхээр талархууштай. Яагаад би энэ зүйлийг хэлэх гээд, асуух гээд байна вэ гэвэл өнөөдөр Авлигатай тэмцэх тухай хуулийн хүрээнд бид нар төрийн алба хашихдаа Хөрөнгө орлогын мэдүүлэг өгөхөөс гадна ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдүүлгээ өгдөг байх. Гэтэл өчигдөр, уржигдар, 3 өдрийн хугацаанд

үргэлжилсэн эмийн түр хорооны хурал дээр тухайн салбарт ажиллаж байгаа төрийн алба хаагчдын ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шийдвэрлэдэггүй байх, зөрчлийн мэдүүлгээ өгсөн ч гэсэн төрийн албанд орж ажиллуулдаг байгаа ийм кэйсүүд маш ихээр гарч ирсэн. Яагаад гэвэл энэ хууль байгаад, хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа нь ямар учиртай юм бэ гэдэг зүйлийг би асуумаар байгаа юм. Яг одоо төрийн албан хаагчийн ёс зүйн тогтоолын төслийг оруулж ирэхдээ хэр энэ тал дээр судалж оруулж ирэв гэдэг зүйлийг би асуух гэсэн юм. Энэ хуулийг би дэмжинэ. Маш ихээр дэмжинэ.

Байгууллага төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг ёс зүйн чиглүүлэх сургалтад заавал хамруулж хэвшүүлнэ. Төр иргэнээ дээдэлдэг байх, төрийн хүнд сурталыг арилгах гэдэг бол үнэхээр иргэндээ үзүүлж байгаа үйлчилгээнээс хамаарах ёстой. Гэтэл үүдэндээ иргэнээ хүлээлгээд суугаад байдаг энэ төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг ингээж анхнаас нь бэлтгэнэ гэдэг бол маш сайн хэрэг. Яг би танаас судалгаа асуулаа. Авлигатай тэмцэх газраас. Төрийн албаныхнаас Цэдэвсүрэн даргаас тодруулъя гэж бодож байна. Хэд хэдэн бас асуудал байна. Хуулиа ингээд ярихаар бид нар үнэхээр хууль байгаад цаасан дээр буугаад үлдэнэ шүү дээ гэдэг зүйлийг бид яримааргүй байгаа. Сая ч гэсэн хууль ярьж байхад бас тэгж байна тийм ээ. Магадгүй Улсын Их Хурлын гишүүд сая Баялгийн сангийн тухай хууль хэлэлцээд лиценз, тодорхой хэмжээний уу уурхайн хувь ярихад уг нь бүгдээрээ сууж байсан. Тэгээд төрийн албаны ёс зүйн тогтоолыг хэлэлцэх гэхэд бүгдээрээ, ихэнх нь гараад явчихлаа л даа. Тэгэхээр энэ мэтээр ёс зүйг бид нар нэхэх ёстой. Гэтэл яг өнөөдөр нөхцөл байдал ямар байгаа гэдэг судалгаа хийгээд энэ тогтоол бидэнд хэрэгтэй юм байна. Төрийн бодлого хэрэгтэй юм байна гэдгийг гаргаж ирэв гэдгийг нэг хэлээч.

Ганцхан асуулт асуугаадахъя. Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлнэ гэж юу гэсэн үг юм бол. Энийг тайлбарлаж өгөөч ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: 5. Эрхэлсэн комиссар Дуламсүрэн. Дуламсүрэн хариулах юм уу.

Д.Дуламсүрэн: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагчийн төрийн албанд анх орох гэж байгаа, эсвэл албан тушаал нь өөрчлөгдөж байгаа хүмүүсийн хувьд бол Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргаж байгаа. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар авч хянаад, ашиг сонирхлын зөрчил тогтоогдож байна уу, тогтоогдохгүй байна уу. Мөн тухайн салбарт ажиллахад ямар нэг байдлаар цаашид ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байна уу гэдэг үндсэн дээр хянан шалгаад албан бичиг явуулж байгаа. Дүгнэлт бүхий. Энэ нь хэрэв Авлигатай тэмцэх газраас тухайн ажил албан тушаал хашихад ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байгаа тохиолдолд нөгөө томилох эрх бүхий албан тушаалтан үнэхээр тэр ашиг сонирхлын илт ашиг сонирхлын зөрчилтэй бол угаасаа томилох ёсгүй байгаа. Үүсэж болзошгүй байна. Ийм учраас цаашид анхаараад хэрэв энэ чиглэлийн ажил, албан тушаал энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад ямар нэг байдлаар ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэж үзэж байгаа тохиолдолд тухайн албан тушаалтнаар мэдэгдэл тайлбарыг нь гаргуулаад, магадгүй тэр ажилд, жишээлбэл ажлын хэсэгт орж ажиллах ёстой байлаа гэхэд тэр ажлын хэсэгтээ орж ажиллахгүй байхаар түдгэлзүүлдэг ч юм уу ийм арга хэмжээ авах ийм зохицуулалт бол байж байгаа.

Томилох эрх бүхий албан тушаалтан бол Авлигатай тэмцэх газрын өгсөн дүгнэлтийг үндэслээд,

албан бичгийг үндэслээд, тушаалаа гаргаж байгаа тэр хүний өөрийнх нь бас эрх мэдлийн асуудал байгаа. Бид бол яг томилох байгууллага нь биш учраас тухайн албан хаагчийг авах, авахгүй гэдэг дээр бол томилох эрх бүхий бүхээ хүнийг л ерөнхийдөө яг тэр хүн л одоо ёс зүйтэй байна. Хуулийг дагаж мөрддөг ийм байх ёстой гэдэг таны саналтай бол санал нэг байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр Удирдлагын академиас 3 удаагийн том судалгаа хийсэн байгаа. Суурь судалгаа. Энэ дээр төрийн албан хаагчдын хариуцлагын асуудал 90 нь ямар байна. Төрийн албан хаагчийн ер нь ямар үнэт зүйлсийг илүү их эрхэмлэж байна. Мөн түрүүчийн үйлчилж байсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ямар түвшинд байгаа юм бэ гэсэн судалгаануудыг бол хийсэн байгаа. Энэ судалгааны дүн бол хангалттай гэсэн дүн бол үзүүлээгүй. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдын хувьд бол хөгжиж дэвших асуудал нь ч гэдэг юм уу, тухайн төрийн албан хаагчдын байгууллагынх нь хувьд бол зүгээр нэг сургалт хийх төдийхнөөр урьдчилан сэргийлэх ажил яваад байна. Тийм учраас ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудал дээр илүү байгууллага нь ёс зүйн дэд хороотой болчихсон байгаа. Шинэ хууль батлагдсантай холбогдуулаад. Энэ дэд хороодын үйл ажиллагаа тухайн байгууллагатайгаа уялдаад, ёс зүйн хороонд чиглэл заавраа өгөөд, хяналт шалгалтаа хийгээд ингээд явах ийм зохицуулалттай орж байгаа учраас түрүүний ярьсан нөгөө орчин нөхцөлийг бий болгож арга хэрэгслээр дэмжих гэдэг энэ зохион байгуулалтын шинжтэй үйл ажиллагаа ер нь их түлхүү орж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл бид нар төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа бол шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэхүйц хэмжээнд дэвшилтэт арга барилаар энийг цаашид явъя гэсэн байгаа. Өөрөөр хэлбэл хуучин байсан,

үйлчилж байсан дүрмийн дагуу, хуулийн дагуу ёс зүйн зөвлөл гэж байсан. Энэ ёс зүйн зөвлөл бол одоо байхгүй. Ёс зүйн дэд хороод гээд өөр статустай, өөр эрх мэдэл бүхий ийм хороод, ийм ёс зүйн хороо Монгол Улсын түүхэнд анх удаа бий болгоод ажиллаж байгаа учраас энэ хууль нь батлагдсан энэ хөтөлбөр нь батлагдаад ингээд явчих юм бол бүх зохион байгуулалтын шинжтэй өөрчлөлт, шинэчлэлт бол шууд гарна гэж үзэж боловсруулсан байгаа.

Г.Занданишатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя. Асуулт, үг нэг явж байна.

Б.Жаргалмаа: Яагаад энэ тогтоолын төсөл хэрэгтэй юм бэ, тогтоол хэрэгтэй юм бэ гэдэг тал дээр бол иргэд олон нийт өчигдөр эмийн түр хорооны сонсголыг сонсоод, сая ч гэсэн бас албаны хүний хариулж байгаа хариултаас сонсоод ойлгож байгаа байх гэж бодож байна. Үнэхээр төрийн албанд ёс зүйн сахилга хариуцлага гэдэг юм алдагдчихсан. Түүгээр шинэ албан хаагчдаа ёс зүйн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь алдагдчихсан учраас өнөөдөр хүний эмийн зөвлөлд ажиллаж байгаа хүн эмийн сангаа ажиллуулаад, лабораторио ажиллуулаад, борлуулан түүгээх үйл ажиллагаагаа хийгээд явж байгаа. Энэ бол бид Авлигатай тэмцэх тухай хууль байгаа. Тийм ээ. Анх тэр хууль батлагдаж байхад бид нар ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх юм байна. Хөрөнгө орлогын мэдүүлгээ өгөх юм байна. Бүх зүйлийг сайн сайхнаар ярьж байсан боловч хууль нь хэрэгжихгүй тухайн явцдаа түүний ашиг сонирхол өөрчлөгддөг гэдэг ийм тайлбартайгаар хууль хэрэгжихгүй байгаа ийм нөхцөл байдал үүсээд байгаа учраас би үүнийг маш нухацтай хэлэлцэж анхаарч үзээсэй гэдэг хүсэлтийн үндсэн дээр үг хэлж байгаа шүү гэдгийг дахиад хэлье.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Амартөгс хариулах уу. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны

саналаар, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Энэ тогтоолын төсөл учраас асуулт, үг хамт явж байгаа л даа. Асуулт, үгтэй хамт явж болно. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг төслийг нь уншиж байхад энэ бас нэлээд бодит байдлыг харсан, урьдчилан сэргийлэх тал дээр нэлээд анхаарал татсан сайн болжээ гэж би уншиж танилцаж үзээд яг бодож байсан. Тэгээд хамгийн гол нь бид нар нөгөө төрийн албаны зөрчлүүд, том том зөрчил гарч байна шүү дээ. Яг төрийн албан хаагч төрийн өндөр албан тушаалтнуудын үнэн ёс зүйгүй, идэж ханадаггүй нэг аймшигтай юмнууд манайд бол бүр ингээд ёстой нээрээ бул чулуу шиг болчихоод байна шүү дээ. Тэгээд бид нар энийг дараа нь мэдээд л бүгдээрээ уулга алдаад л ингээд байдаг. Гэтэл үнэндээ энийг урьдчилан сэргийлэх, бий болгохгүй байх тэр хөрсийг нь бүрдүүлэх асуудал бол бидний хамгийн гол зорилго байгаа. Тийм учраас ийм юмнууд дээр бол төрийн албан хаагч үнэхээр том ёс зүйн зөрчил гаргаад энэ ажлаа хийж чадах бол тэрэнд нь шууд цэг тавьж чаддаг, бас төрийн албан хаагчийг ийм юм гаргахгүй байх тал дээр нь анх ажилд ороход нь бүр тэр суурь хандлага, тэр шалгуурыг нь маш сайн бий болгоод өгчихвөл энэ цэгцрэх байх. Өчигдөр 3 өдөр үргэлжилсэн эмийн сонсголоос харж байхад төрийн зохицуулалт тэнд байхгүй гэвэл үгүй. Хамгийн их зохицуулалттай. Маш их хууль дүрэмтэй хэр нь хамгийн их энэ төрийн оролцоо доор төрийн зохицуулалтаар мэдээлэлд ойр хүмүүсийн бизнес цэцэглэчихсэн, тэрийг дагаад хэдхэн монопол компаниуд бүр эмийг аалзны тор шиг ингээд бүрхчихсэн байна

шүү дээ. Эмийн зах зээлийг. Эцэст нь юу болж байна гэхээр бид нар төсөв дээр үнийг нь нэмээд л байдаг. Эмийн салбарт гэхэд төсөвлөлт энэ 2019 онд 40 тэрбум, 2023 онд 90 тэрбум, 2024 онд 137,7 тэрбум төгрөг ингээж төсөвлөж өгч байхад энэ маань нөгөө ард иргэдийн ачаалал тэр эм, тариандаа зарцуулж байгаа нуруун дээрх ачаалал, санхүүгийн ачааллыг нь бууруулах ёстой байтал өөр зам руу урсаад л орчхоод байгаа. Энэ нь өөрөө бас ёс зүйгүй бөгөөд бараг энэ бол дэндүү нүгэлтэй ийм үйлдлүүд байгаа. Тэгэхээр ийм зүйлүүд дээр бид бол цэг тавих цаг бол болсон.

Сая хэлж байна. Тэр Авлигатай тэмцэх тухай бид хууль баталсан хэр нь энэ хууль маань бас зарим тохиолдолд сорчлоод үйлчлээд байна уу даа гэдэг асуудал ч байгаа. Тэгэхээр бид энийг бол таслан зогсох ёстой. Нэг талаас.

2 дахь зүйл хэлэхэд одоо энэ төрийн албан хаагч гэдэг дээр манай Сүхбаатар дүүргийн нэг соёл урлагийн салбарын нэртэй эмэгтэйг ажлын байранд бэлгийн дарамт үзүүлэх асуудал үүсээд, тэгээд гомдол гаргаад шүүх дээр очихоор харин эсрэгээрээ нөгөө эмэгтэй буруутан болоод, нэр төр нь ингээд баахан явж байгаа юм байна л даа. Ажлаас нь бараг халах шахаад. Тэгэхээр ийм зүйл дээр энэ төрийн албаны ёс зүйн зөрчил харин буруутай хүнд нь үйлчилдэг ёстой болохоос биш, нөгөө хэлмэгдсэн хүнд нь үйлчлээд байж байж бол огт болохгүй. Тэгэхээр бид ер нь амьдралд ойрхон хэрэгжих, хэрэгжихэд нь хяналт тавьдаг ийм хууль, үндэсний хөтөлбөр гаргахгүй бол цаас үйлдвэрлээд л байдаг, хөтөлбөр гаргаад л байдаг, хууль гаргаад л байдаг. Энэ нь эргээд бүр асуудлыг нөгөө саяын миний хэлээд байгаа мэдээлэлд ойрхон юм уу, эсвэл албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигладаг ийм зүйл нь илүү ингээд давамгайлаад энэ нь өөрөө Мон Монгол Улсын хөгжлийг боомлоод байгаа. Бид зөндөө хууль гаргадаг. Тэгээд л нэг сайд юм уу нэг удирдлагыг нь сольдог харин нөгөө доор хөрс нь тэр чигээрээ үлдээд байдаг. Тийм юман дээр л

бид ер нь анхаарахгүй бол яг үнэндээ дээд шатдаа гэхээсээ илүүтэй тэр дунд шатад ч гэсэн асуудлууд байгаа. Үнэхээр мундаг төрийн албан хаагчид байна. Тэднийгээ бид урамишуулж хамгаалж байх ёстой байхгүй бол одоо харин төрийн албанд ажиллая гэдэг хүмүүсийн сонирхол зарим нь буурч байна гээд байгаа юм. Яагаад гэхээр цалин хөлснөөсөө биш дарамтаасаа, даргын дарамт, тэр тухайн албаны даргын юм уу, тухайн салбарыг удирдаж байгаа хүмүүсийн дарамт нь төрийн албанд ажиллахаас үнэхээр ядаргаатай гээд гараад нөгөө гадаад руу явах юм уу эсвэл хувийн хэвшил рүү явахад хүргэж байгаа учраас бид бас энэ төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийгээ нэг талаас хамгаалах, сайн ажиллах орчныг нь бүрдүүлэх, нөгөө талаасаа элдэв муу юманд өртөхгүй байх, ёс зүйн алдаа гарахгүй байх тэр соён гэгээрүүлэх ажлыг бол маш сайн хийх ёстой юм байна лээ шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ёс зүйтэй холбоотой юм байна. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Мөнхцэцэг, Наранбаатар, Мөнх-Оргил, Пүрэвдорж, Сандаг-Очир, Учрал, Цогтбаатар гишүүн байсан. Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Би ёстой саналаа өгөх гээд энэ машин ажилласангүй. Энэ хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданишатар: Дамдины Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Идэрбат гишүүн байсан хаачсан бэ. Энэ Байнгын хорооны дарга нь энд сууж байна шүү дээ. Санал хураалт. Цогтбаатар гишүүний горимын санал дэмжигдлээ.

Цогтбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулна. Төсвийн байнгын хороо яагаад чуулгантай зэрэгцээж хуралдаад байгаа юм бэ. Санал хураалт. Тогтоолын төсөл батлагдлаа. 51,3 хувийн саналаар.

Энэ эсрэг дарж байгаа хүмүүс бол ёс зүйн асуудалтай хүмүүс байна гэж үзье. Ажлын хэсэгт баярлалаа. Явж байж болно.

15.35 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна.

Энэ хооронд энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 4 дүгээр сарын 17-нд Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан төрсөн байна. Санязын Хавдислам, Дашкенийн Жибек нарын 12 хүүхэдтэй айлын 3 дахь хүү болж эхэлж мэндэлжээ. Ингээд баяр хүргэе. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделханд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын

гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Таны насыг хэлж болох уу.

Гонгорын Дамдинням гишүүнийг индэрт урьж байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар тогтоолоор дээрх хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Тус Байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явуулж дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг

явуулах үед ажлын хэсгээс уур амьсгалын өөрчлөлт, гамигийн эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үндэсний чадавхыг бэхжүүлэх, төсөвт зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулан, Малын гаралтай түүхий эдийн анхан шатын ангилалд тордолт хийж, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, стандарт техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталж, үе шаттай хэрэгжүүлэх зэрэг саналыг төсөлд нэмж тусгах. Төслийн малын тэжээлийн нэр төрөл, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх заалтыг тэжээлийн ургамлын тариалалт, тэжээлийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэхээр бэлчээрийн даацыг уялдуулан зохистой ашиглах заалтыг малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах аар өөрчлөн найруулах зэрэг зарчмын болон найруулгын нийт 13 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн хуулийн төслийн хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг хуулийн төслийн 5 дугаар зүйл болон 7 дугаар зүйлтэй холбогдуулан 2 санал, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 1 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Г.Ганболд нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авлаа. Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллын нэг бүрчлэн хэлэлцэн, санал

хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөх бүхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна. Тэр хооронд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсэг Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Мөнгөнцогийн Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Сарантуяагийн Цогтсайхан Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал,

Даваасүрэнгийн Батсүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт.

Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалах сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль гэж яасан ч урт нэртэй хууль юм. Ямар ч хурдан оруулаад ирдэг юм. Энэ одоо ярьж байсан зүйл бол 8 жил яригдсан. Тэгээд өнөөдөр 8 жилийн эцэст дараагийн парламент бий болоход 3 сар дутуу байхад ингэж малчдыг хуурч, шилний цаанаас чихэр горьдуулж болохгүй ээ. Энэ хуульд бол малчдад хэрэгтэй юм үнэндээ алга. Улам дээр нь дарамталж байна. Одоо ер нь болохгүй зүйлээ хүн рүү чихдэг, нам руу чихдэг, одоо бүр уур амьсгал руу, дэлхий рүү, байгаль дэлхий рүү чихдэг болж. Малчид өөр ер нь нэг их олон хууль батлаад өг гэж гуйгаад байгаа зүйл алга.

Сая бид нар орон нутагт явлаа. Хэнтий аймгийн Баянхутаг, Дархан, Баянмөнх, Галишараас урагшаагаа, дээр нь Сүхбаатар аймгийн бүх сумд гамшигт өртчихөөд байна. Энэ тоон мэдээллүүд бүгд буруу байна. Зөвхөн Сүхбаатар аймагт өнгөрсөн жил 5 сарын 20-ны шуурганаар 520, энэ жилийн өвөл 1 сая 600 мянган мал, нийтдээ 2 сая мал хорогдчихоод байхад энэ мэдээллүүд худлаа байна. Худлаа байна. Дээр нь цаг агаарынх биш. Энэ бол ер нь өнөөгийн эрх баригчдын малчдын талаар арга хэмжээ аваагүй байсаар байж байгаад ийм түвшинд хүргэсний л хор гай юм. Тийм учраас энэ хуулиа татаад авчхаж болдоггүй юм уу. Хуулийг аль ч шатнаас нь. Жишээлбэл хуулийн 9 дүгээр зүйл дээр малчны эрх үүрэг гэнэ. Мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг явуулсан байна. Чанарын бүтээмжүүдийг нэмэгдүүлсэн байна. Өөрөө мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн байна. Ингэж байж зээл өгнө гэнэ. Тэгээд энэ үүргээ биелүүлээгүй бол гэнэ. 11 дүгээр зүйл дээр энэ үүргээ биелүүлээгүй бол хууль

зөрчсөнд тооцож, энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд Эрүүгийн болон Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж. Ингэж болдог юм уу. Угаасаа энэ хамтрал, коммун нэгдэл, хоршоо гээд үндсэндээ энэ чинь хөдөөгийн мал аж ахуй болохгүй байна гэдгийг нь 100 жилийн хугацаанд баталчихсан шүү дээ. Малчид бол одоо хөдөөгүүр явахад бүх хүн хэлж байна. Зүгээр бид нарын энэ гамшигийг түүхэнд байгаагүй энэ гамшигийн хохирлыг нэг удаа төлөөд өгвөл өөр төрөөс юу ч гуйхгүй. Дээр нь бид нарын махны үнийг малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнийг ингэж хог болгохгүй л болгоод өгчих юм бол бид нар төрөөс юу ч гуйхгүй амьдарч чадна л гэж байгаа юм. Ингээд өөрсдөө чадна гээд байхад чинь, та нар чадахгүй ээ, заавал хоршоолол бол. Хоршоолол болох юм бол бид нар зээл өгнө гэж байгаа юм. Өнөөдрийнхөө авсан 5 сая, 10 сая, 20 сая төгрөгийн зээлийг яая гэж байхад та нар олноороо нийлчих юм бол 50 хүртэлх сая төгрөгийн зээл өгнө гэдэг чинь хүн доромжилж байгаа асуудал байна. Тийм учраас энэ хуулийг ер нь татаад авчхаж болохгүй юу. Ярьж болох л байлгүй, баталж болох л байлгүй. Ийм одоо харьцангуй хол зөрүүтэй парламент дээр энэ малчин өрхийн амь амьжиргааг шийдэх гэж байгаа энэ хуулийг татаад авчхаасай гэж би хүсэж байна. Хүсэж байна. Ер нь малчид бол энэ 2 самбарын л юмыг хүсэж байгаа. Нэг нь зээл тэглээд өгөөч. Нэг нь бидний махны үнийг битгий бариад байгаач. Түүхий эдийн үнийг битгий бариад байгаач. Тэгвэл бид нар бол өөр зүйлийг хүсэхгүй ээ, төрөөс юу ч гуйхгүй ээ л гээд байна. Тэгэнгүүт та нар гуйна гээд ингээд байх. Энэ талаар нэг би нэг асуулт.../минут дуусав/

Г.Занданшатар: 3 номер. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан хариулна.

Д.Амарбаясгалан: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Та хаанахын бодлого ярьж байгаа юм бол

гэж бас гайхтал асуулт асуулаа. Монгол Улсын уламжлалт мал аж ахуйн салбарыг сэргээх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зорилготойгоор Засгийн газар энэ хуулийн төслийг өргөн барьсан. Малчдыг жоохон чинээлэг болгоё гээд асуудал шийдээд хуулийн төсөл боловсруулаад ороод ирэхээр уурлаад байх юм. Яагаад энэ малчид сэргээж болохгүй юм бэ. Малчид яагаад чинээлэг дундаж давхаргыг төлөөлдөг иргэд байж болохгүй юм бэ. Зөвхөн зээлдээ баригдсан, зээлийнхээ өрийг тэглүүлсэн, ядуу гэдэг статустай байх ёстой юм уу. Энийг бас гайхаж асууж байна. Монгол Улсын Засгийн газрын зүгээс малчид руу чиглэсэн 3 бодлогыг хийж хэрэгжүүлж байна.

1 дүгээрт хэрэглээний зээл буюу өнгөрсөн хугацаанд авсан зээл нь цас зудын нөхцөлөөс болоод төлөхөд хүндрэл үүссэнтэй нь холбогдуулаад зээлийн эргэн төлөлтийг үндсэн зээлийг 1 жилээр хойшлуулах, 1 жилээр хойшлогдсонтой холбоотойгоор хүү хуримтлагдана. Хуримтлагдсан хүүгийн 75 хувийг улсын төсвөөс татвар төлөгчдийн мөнгөөр төлж барагдуулах ажлыг хийж байгаа.

2 дахь зүйл нь хагас жилийн мал тооллогын дүнгээр малын хорогдлын тоо эцэслэн гарна. Малын хорогдлын тоо эцэслэн гарсантай холбогдуулаад малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Малжуулах хөтөлбөрт зориулж 2024 оны улсын төсөвт 22 тэрбум төгрөг батлагдсан байгаа. Тэгэхээр хэчнээн өрх малжуулах хөтөлбөрт хамрагдах вэ гэдгээс хамаарч 1 өрхөд хэдэн төгрөгийн дэмжлэг үзүүлэх вэ гэдэг асуудал тодорхой болно.

3 дахь асуудал буюу мал аж ахуйн салбарыг цогцоор нь хөгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газар боловсруулсан. Малчид өнөөдөр хэрэглээний зээл жилийн 20-24 хувийн хүүтэй зээл авч амьдарч байна. Олон малтай байж байж арилжааны банкнаас зээл авах боломж нь

хангагддаг. Яг энэ байдлаараа үргэлжлэхэд малчид цаашидаа амьдрах нөхцөл боломж сул байна. Өнөөдөр дундаж малчны орлого сарын 1 сая 500 мянган төгрөг байна. Сарынх нь зардал нь 2 сая 100 мянган төгрөг. Сард 600 мянган төгрөгийн алдагдалтай амьдарч байна. Яг энэ юу гэсэн үг вэ гэхээр мал дээр удаан олон жил амьдрах тусмаа малчид улам бүр ядуурдаг ийм тогтолцоо бий болчихжээ. Тийм учраас Мал аж ахуйн салбарт 3-5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэй, хөрөнгө оруулалтын зээлийг өгч байгаа юм. Энэ хөрөнгө оруулалтын зээл үндсэндээ малчид маань нийлээд, нэгдээд хоршоод, анхан шатын боловсруулалт хийдэг мах нядалгааны цехтэй, арьс шир, түүхий эдийн анхан шатын тордолтыг боловсруулалтыг хийдэг боломжтой болох юм байгаа юм. Ялангуяа 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлээд гар аргаар нядалсан махыг зах зээлд нэвтрүүлэхгүй байх хуулийн зохицуулалт хийгдсэн байгаа. Тэр үеэс эхлээд юу болох вэ гэхээр мал нядалгааны үйлдвэрүүд очерт автана. Эргээд малчид маань малаа зарж чадахгүй хэлбэр лүү орно. Гараар нядлаад зах зээлд борлуулж чадахгүй учраас малын үнэ унана. Эргээд малчдын орлого бүр улам бүр багасах нөхцөл рүү орж байгаа учраас анхан шатын мах нядалгааны цехтэй, малын түүхий эдийн тордолтын цехтэй, сүү сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах анхан шатын үйлдвэртэй, мал эмнэлгийн анхан шатын хоршоотой, мал үржлийн анхан шатын хоршоотой байх тэр нөхцөл боломжийг бий болгох зорилгоор энэ шинэ хоршоо хөдөлгөөний төлөвлөгөөг боловсруулж Засгийн газар хэрэгжүүлэхээр болж байгаа.

Ер нь өнөөдөр малчдын орлого ямар байгааг та түрүүн 1 сая 500 мянга гэж хэлж байна. Мал өөрийн өртөг бол малчны хотонд үндсэндээ 20-хон хувь шингэж байна. Үлдсэн 60 хувь нь ченжийн тогтолцоо дээр шингэж байна. Үлдэж байгаа 20 хувь нь хэрэглэгчдэд хүрэх, худалдан борлуулах цэг дээр үлдэж байгаа юм. Тэгэхээр малчны хотноос 1

сая төгрөгөөр гарсан үхэр хэрэглэгчдэд ирэхэд 5 сая болж байгаагийн тал хувийг нь малчдадаа үлдээе гэж.../минут дуусав/

Г.Занданишатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууя.

Ж.Батсуурь: Би хэлээгүй юм аа сайд аа. Сая би 10-аад хоногт 4 мянга орчим малчидтай уулзаад ирлээ. Тэр хүмүүс өөрөө өөрсдийнхөө бодлогыг бид нар хуульчлуулмаар байна л гэж байгаа юм. Асуудал бол. Шаардлагатай гэвэл бид нар жагсаал цуглаан хийхэд ч гэсэн яваад очиход, угаасаа харах малгүй болчихсон, хийх ажилгүй болчихсон өөрсдийнхөө эрх ашгийн төлөө очиход бас бэлэн байна л гэж байгаа юм. Тэгээд энийг би хэлээд байгаа зүйл бол байхгүй. Улсын Их Хурлын гишүүн бол ард нийтийн хэлсэн ярьсан зүйлийг эрх баригчид, шийдвэр гаргах түвшиний хүрээнд хүргэх л үүрэгтэй. Хүмүүсийн хэлсэн протокол бүгдээрээ байж байна. Шаардлагатай гэвэл явсан сумдын бүх бичлэгүүд нь байж байна. Араас нь зохиогоод яриад байгаа зүйл бол байхгүй ээ гэдгийг хэлэх гэсэн юм. Тэгээд өмнөх асуултад.../минут дуусав/

Г.Занданишатар: Даишэвэгийн Амарбаясгалан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Энэ хууль хорших нөхцөл боломжийг бүрдүүлнэ. Хоршооны гишүүн, хоршоо гэдэг зүйл өөрөө хуулийн этгээд болж байгаа. Хуулиар зохицуулалт хийгдэж байгаа. Тэгэхээр хуулийн этгээдийн хувьд энд хүлээх үүрэг хариуцлага гэдэг зүйл зайлиггүй байх ёстой гэдгийг бас танд хэлмээр байна.

2 дугаарт би бас таны түрүүний асуусан асуултад дутуу хариулчихлаа. Хэрэглээний зээлийг тэглэх асуудал, хэрэглээний зээлийг хойшлуулаад, хүүгийн 75 хувийн хөнгөлөлтийг үзүүлэх асуудал зэргийг их зөв ялгаж салгаж ойлгох ёстой. Ер нь цаашидаа малчид маань ер нь

яаж амьдрах юм бэ гэдэг зүйл дээр та бас бодож яримаар байна. Ялангуяа Сүхбаатар аймгийн тухайд мал хорогдол ихтэй. Маш олон айл малгүй болсон. Тэр малгүй болчихсон айл өрхийг та цаашаагаа яаж амьдар гэж, ямар арга зам зааж өгч байгаа юм. Ганцхан зээлийн хүү, зээлийг нь тэглэж өгсөн гэсэн нэрийн дор тэр малчдыг цаашаагаа яаж амьдрах чинь зөвхөн өөрийн чинь.../минут дуусав/

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Жамбын Батсуурь гишүүн тодруулъя.

Ж.Батсуурь: Энэ хуулийн 9.1.1 дээр Мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхлэх хүрээнд хоршоо байгуулах зорилго, үйл ажиллагаа, чиглэлийг дэмжсэн малчдыг хоршоонд нэгдэхийг үүрэг болгочихсон байгаа байхгүй юу. 9.1.1 дээр ингэхлээр чинь үүрэг болгочихсон байна. Энийг хар даа. Үүрэг гэж байгаа байхгүй юу.

3 дугаар бүлэг. Малчин хуулийн этгээдийн үүрэг. Тэгэхлээр энэ бол өөрөө болохгүй юм аа. Яг үнэндээ бол малжуулах бодлого явуулах нь бол зүйтэй. Тэгэхдээ энд байгаа зөвхөн уур амьсгалаас биш засаг төрийн арга хэмжээ байгаа шүү дээ. Жишээлэх юм бол Сүхбаатар аймагт 2 сая мал хорогдчихоод байхад 40 мянган тонн тэжээл хуваарилдаг. Хорогдоогүй газар 400 мянган тонн тэжээл хуваарилахлаар чинь малчид өгөхгүй яах юм бэ. Тийм учраас энэ асуудлыг бол өөрөө.../минут дуусав/

Г.Занданишатар: Даишэвэгийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулна. Тодруулгад хариулна.

Д.Амарбаясгалан: Батсуурь гишүүн ээ, 1 дүгээрт малчны эрх, үүрэг гэж орж ирж байгаа. 9 дүгээр зүйл. Малчин ямар эрхтэй байх юм, ямар үүрэгтэй байх юм гэдэг. Ер нь аливаа асуудал бол эрх, үүргээр зохицуулагддаг гэдгийг та бас хэлүүлэлтгүй мэдэж

байгаа байх гэж бодож байна. Хоршоонд нэгдэх нь малчны сайн дурын үндсэн дээр нэгдэх эрхтэй. Бүгд нэгдэхгүй. Бүх малчин хоршоонд нэгдээд, хоршооны гишүүн болоод зээл аваад үйлдвэрлэл эрхлэх шаардлагагүй гэж үзвэл тэр хамрагдахгүй байх нөхцөл нь бүрдэнэ.

2 дугаарт Сүхбаатар аймаг энэ жил цас зудын нөхцөл дээр ер нь Засаг дарга бол маш хариуцлагагүй ажилласныг бас энд хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Засгийн газрын зүгээс нөөцийн өвс тэжээл хуваарилаад, Сүхбаатар аймагт 400 мянган тонныг татаж ав гэдэг үүргийг өгөхөд 100000-ыг авна гээд, эхлээд авахгүй гэж 14 хоносон. Малчид тэнд малын тэжээлгүй байсан. Маш хүндрэлтэй нөхцөлд орсон. Өөрсдөө өвс тэжээлээ татаж авдаггүй.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би 3 асуулт асууна.

Нэг дэх юм нь нэг ийм ойлголт байгаа юм. Хууль нөгөө уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах гэж байгаа юм. Тэгээд энэ гишүүд нөгөө одоо ямар арга хэмжээ авах гэж байна гэдэг юм асуугаад байгаа юм. Энэ орж ирсэн хуулийн төслүүдээс хараад байхаар нөгөө дараа нь Мал аж ахуйн салбараа цаашид яаж хөгжүүлэх вэ, хэрхэн хамтарч нэгдэж ажиллах вэ, үйлдвэрлэлийг нь хэрхэн дэмжихтэй холбоотой асуудлын харилцаа бол ингээд бүрэн зохицуулагдчихаад байгаа юм. Тэгэхээр 1 дүгээрт асуух гээд байгаа юм нь юу байна гэхээр одоо энэ жилийн энэ болсон зудын үед үүссэн хохирлыг барагдуулах чиглэлээр 2 арга хэмжээ авах гэж байна гэж би ойлгосон. 1 дүгээрт малжуулах. Тэгэхээр энэ Булгантуяа сайд хариулах юм уу, Амараа сайд хариулах юм уу. 1 дүгээрт малжуулахдаа ийм хэмжээний хөрөнгө

гаргана, ийм хэмжээний асуудлаар саяын Батсуурь гишүүний яриад байгаа тэр малгай болчихсон хүмүүс дээр ийм арга хэмжээ авах гэж байгаа гэдгээ нэг ярьчихмаар байгаа юм.

2 дугаар асуудал нь юу байна вэ гэхээр нөгөө малчны зээлийн 75 хувийг хөнгөжчихөж байгаа. 6 хувь буюу 25 хувийг өөрөө төлнө. Тэр 25 хувийг хөнгөлж байгаа эх үүсвэрийг энэ 6.1.9-өөс гаргах гээд байна уу, энэ орж ирсэн хуулийн 6.1.9-өөс гаргах гээд байна уу, аль эсвэл одоо Засгийн газар тодорхой хүрээнд шийдчихээд байна уу гэдэг ийм зүйлийг 1 дүгээрт нь тодруулъя Амараа дарга аа.

2 дахь асуудал юу байна вэ гэхээр 6.1.9 дээр яах вэ төсвийн тогтвортой байдлаа хасчихсан. Тэр болж байгаа юм. Төсөв хооронд зохицуулалт хийх гэдэг заалтыг нь хасчихсан юм. Төсөв хооронд зохицуулах. Сангийн яамны Санжаадорж байсан уу сая. Санжаадорж хариулна биз. Төсөв хоорондын зохицуулалтыг яагаад хасчихсан юм. Тэгэхээр нөгөө би бодвол энэ нөгөө хоршоо байгуулаад, цаашидаа явж байгаа зээлийн эх үүсвэрт нь зээлийн эх үүсвэрийн хүүд нь зориулж тодорхой хөрөнгийг эндээс гаргах гээд байгаа юм. Гэтэл төсөв хооронд гэгчихсэн чинь тэгээд төсвийн ерөнхийлөн захирагчдынхаа хооронд жаахан зохицуулалт хийж л хэдэн юм гаргах гэж байгаа шүү дээ. Тэгэхдээ Жавхлан сайдын ярьж байгаагаар 50 орчим тэрбум төгрөг гэж байна лээ. Максимум. Тэрийг гаргахад нөгөө төсөв хооронд гээд юмыг хасчихаар хамрагдахгүй болчих вий яах вэ энийг бодвол энэ Сангийн яам тооцсон юм болов уу даа гэж бодож байна.

3 дахь асуудал нь ажлын хэсэг Батжаргал гишүүн хариулах байх. Тэр газрын хуультай холбоотой асуудал руу 5 га-гийн асуудал байдаг юм. Тэр 5 га-гийн асуудлаар зөвхөн 1 хоршоонд хоршооны гишүүд давхцахгүй байх ч гэдэг ч юм уу энэ чиглэлээр тодорхой харилцаануудыг оруулж байна уу, үгүй юу. Ингэхгүй

болохоор нөгөө хоршоод давхцаад 5 га-гаар яваад байх юм бол газар олдохоо болиод явчихна шүү дээ. Бараг бүх бэлчээр хашичих гээд унана. Тэгэхээр бэлчээр хашихгүй байх асуудал чинь манай хамгийн том үндэсний аюулгүй байдлын асуудал байхгүй юу. Тийм учраас энэ асуудал дээр бодвол ажлын хэсэг ажилласан Батжаргал гишүүн хариулт өгөх байх гэж бодож байна. Ийм 3 зүйлийг тодруулъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Даишэвэгийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулна.

Д.Амарбаясгалан: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Малжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 22 тэрбум төгрөг байгаа. Энэ 22 тэрбум төгрөг энэ хагас жилийн мал тооллого хийгдээд хэдэн малчин өрх олон тоогоор малаа хорогдуулсан байна. Малжуулах хөтөлбөрт хамрагдах шаардлагатай байна гэдэг тоо эцэслэн гарсны үндсэн дээр 22 тэрбум төгрөг зарцуулагдана. Тэгэхээр хэдэн өрх байх вэ гэдгээс хамаарч дүнгийн асуудал яригдана.

2 дахь нь энэ зээлийн хүүгийн 75 хувийн хөнгөлөлтийн асуудлыг 2024 оны төсөвт батлагдчихсан байгаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас төлж барагдуулж байгаа. Засгийн газрын тогтоол гараад, албажаад, хэрэгжээд эхэлсэн байгаа.

3 дахь асуудал дээр бас би тайлбар өгчих үү. 5 га газар дээр тийм ээ. 5 га газрын тухайд бол 1 хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар 1 удаа үнэ төлбөргүй олгох асуудал яригдаж байгаа. 1 хоршоонд гэдэг ойлголтоор явна. Хоршоо хэдэн гишүүнтэй байх вэ, 1 хүн хэдэн хоршоонд гишүүнээр байх вэ гэдэг асуудал бол тусдаа асуудал юм.

Г.Занданшатар: Хэн нь хариулах юм. Жигжидийн Батжаргал гишүүн. Тэмүүлэн дарга та 2 чинь хамт хэлэлцсэн биз дээ.

Ж.Батжаргал: Төсөв хооронд гэдгийг ажлын хэсэг дээр, Байнгын хороо дээр авсан. Улс болоод орон нутгийн төсвийн хооронд зохицуулалт хийгдэх гээд байгаа юм. Тийм учраас тэрийг авч байгаа. Зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчдынхаа хооронд урсгал болоод хөрөнгийнхөө зардлын хооронд л зохицуулалт хийхээр. Зохицуулалт хийсэн тухай бүрээ Улсын Их Хуралд тайлагнаж байхаар заалт нэмж, Улсын Их Хурлын төсөв батлах, хяналт тавих, бүрэн эрхийг нь балансжуулж хадгалсан гэж ингэж л хэлмээр байна.

Г.Занданшатар: Төсөв дотор гэдгээ авчихаар бол нийт мөнгөн дүн хэмжээ нь болж байгаа юу Тэмүүлэн гишүүн ээ. Тэмүүлэн дарга. Төсвийн байнгын хорооны дарга. Дотроо гүйхээр чинь нийт зардал, нийт алдагдал төсвийн алдагдалд нөлөөлөхгүй байх. Ганзоригийн Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр төсөв хооронд гэдэг нь ерөөсөө Улсын төсөв болон орон нутгийн төсөв, Ирээдүй өв сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн хооронд зохицуулалт хийж болохгүй ээ л гэсэн үг болчихож байгаа юм. Тэгэхээр хийж болно гэснийг нь бид нар хасаад, ерөөсөө энэ одоо юу гэдэг юм. Магадгүй тэр орон нутагт санхүүжилт олгох гэдэг юм уу, малчдын тэр зээлийн хүүг хойшлуулахтай холбоотой энэ Засгийн газраас гаргах тэр санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч нар дотроо гэдэг юм уу, төсөв дотроо л бүрдүүлж гарга гэдэг зохицуулалтыг хийж өгч байгаа. Тэгэхээр энэ зохицуулалтын хүрээнд ямар нэг болон улсын төсөв орон нутгийн төсөв хооронд мөн Ирээдүй сан болон Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан хооронд зохицуулалт хийх эрхүүдийг хязгаарлаж өгч байгаа. Энэ дээр нэмээд бид нар бас

яах вэ, энэ хууль дээр оруулж өгсөн. Саяын тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль эд нар бас дагаж мөрдөхгүй гэдэг заалтууд байсан асуудлын хувьд бас хасаад ингээд оруулж өгч, Улсын Их Хурал өөрөө төсвийг хянах гол үндсэн суурь зарчим хуулиудаас дагаж мөрдөхөөр зохицуулалтуудыг хийж өгсөн байгаа.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Та нар чинь одоо тэгээд ямар хөл дээрээ босоод л өглөө болгон 1 хууль хэн нь бодож оруулж ирээд байдаг юм бэ. Сүүлийн үед л нэг баахан л болох, болохгүй хууль оруулж ирэх юм. Тэгээд энэ чинь маш сонин байна. Нөгөө та нарын энэ хамгийн инээдтэй юм нь бол хүн болгонд таалагдах гэж бодох юм. Энэ социалистууд. Энэ чинь арай хэтэрч байна. Тэгээд энэ хууль ингээд гарна, тогтоол гарна. Энэ мөнгө төгрөг чинь хаанаасаа гарах юм бэ. Ямар хуулиудыг зөрчиж байна вэ. Энэ чинь Улсын төсөв гэж байдаг уу. Төсвийн тодотгол хийх шаардлагатай юу. Энэ хуулийг гаргаж байгаа нэртэй баахан хүлээлт үүсгэж байна та бүхэн. Тэгээд энэ бэлчээрийн даац ямар билээ өнөөдөр. Тэр малчдаасаа асуусан уу. Яг ямар хүсэлтэй, ямар бодолтой байгаа юм. Карманаасаа мөнгө гаргаж байгаа юм шиг л яах юм. Тэгээд та нарын нөгөө өмнө нь хийсэн баахан макетууд байгаа шүү дээ. Тэр Дарханы, Эмээлтийн. 1 ч ажилладаг олигтой үйлдвэр байхгүй. Үгүй ээ, тэгээд энэ малчид чинь яах юм амьдрахын тулд малаа өсгөж л таараа шүү дээ. Тэгээд тэрийг нь мянгат малчин гээд баахан шагнал тараана.

Тэгээд энэ уул уурхайн компаниуд байна. Гүний усыг нь ховх сорно. Тэр газрын гагнаас болчихсон алтыг нь авчихна. Нийгмийн ямар ч хариуцлага байхгүй. Энэ бүгдийг судалж шийдсэн юм уу. Та нар чинь одоо хаанаасаа гараад ирсэн юм бэ. Гэнэтхэн өнгөрсөн борооны хойноос цув нөмөрч байгаа юм шиг л байх юм. Яг нөгөө хэрэгтэй үед нь бензинээр

тасална. Яг нүүдэл суудал эхлэх үед нь өвс тэжээлээ татахад нь дизелийн түлшээр тасална. Ийм хариуцлагагүй юм хийчхээд, хийдэг байж одоо ингээд сонгууль болох гэж байхаар болох дөхчихлөө. Ээлжит хуурсан аргаа л хэрэглэж байгаа. Тэгээд л бас одоо хамтрал коммун гээд явна. Би яг одоо харсан юм шиг мэдэж байна. Нөгөө нэг хорооны балай авгай нар, нөгөө авгай хэлдэг шиг хорооноос юм өгвөл авна даа гэдэг шиг. Тэгээд зарим нэгийгээ ялгаварлана тэр чинь. Нөгөө хамтралын бух буудсан нөхөр гээд л хувийн бухыг яалаа гэдэг шиг л зарим нэгэн хүмүүсийг гадуурхана. Үгүй ээ, малчдаас асуугаад, өөр мэргэжил эзэмшиж болно шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгийг үр дүнтэй зарцуулах хэрэгтэй шүү дээ. Энэ малын тоо чинь дийлэхгүй байна. Бэлчээрийн даац чинь дийлэхгүй байна. Үгүй ээ, танай энэ Засгийн газарт чинь юм боддог хүн байна уу. Амьдрал мэдэхгүй, ажил мэдэхгүй, оруулж ирж байгаа хууль нь хүлээлт л үүсгэнэ. Өөр юм ерөөсөө алга байна. Тооцоо судалгаа ямар ямар хуулиуд зөрчигдөж байгаа талаар тэрийг чинь бас мэдмээр байна. Миний харж байгаагаар бол их олон хууль зөрчиж байна. Тэгээд гал унтраах маягаар ямар ч хийх чадал чадвар байхгүй, зүгээр хэдэн хуулийн төсөл гаргаж байгаа нэрээр, баталж байгаа нэрээр хүлээлт үүсгээд л, тэгээд нөгөө малчид маань баахан мал авах юм байна гэж ойлгоно. Ингээд Ардын нам сонгуулиа өгөхийн тулд бүгдээрээ бөөгнөрнө гэж хэлнэ. Тэгээд сонгууль өнгөрлөө энэ чинь байхгүй болно. Үгүй ээ, одоо энийг бол ёстой Ванга шиг л би хэлсэн юм даа уг нь. Ёстой Ванга шиг харсан юм шиг хэлж байна. Тэгээд одоо энэ Амарбаясгалан дарга баахан олон юм ярих байлгүй. Бас сонсьё л доо тэрийг. Тэгээд тодруулъя.

Г.Занданшатар: Даишээвэгийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулна.

Д.Ганбат: Ганбат гишүүнийхээ асуултад хариулъя. Одоо Ванга шиг хэлье

Ганбат гишүүн ээ. Мал аж ахуйн салбар Монгол Улсыг нуруун дээрээ үүрч явах ёстой чухал салбар. Энэ салбар өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүнд үзүүлж байгаа нөлөөлөл нь 10,5 хувьтай байна. Монгол Улсын Засгийн газрын зүгээс боловсруулаад хэрэгжүүлэх гэж байгаа хөтөлбөрийн үр дүнгээр урт хугацаанд 5 их наяд төгрөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж мал аж ахуйн салбарын сэргэлтийг бий болгоно гэж ингэж зорьж байгаа. Үүний үр дүнгээр 5-10 жилийн дотор мал аж ахуйн салбарын ДНБ-д нөлөөлөх нөлөөллийг 30 хувьд хүргэх төсөөллийг, зорилтыг тавин ажиллаж байна.

Монгол Улсын нийт газар нутгийн 72 хувийг мал аж ахуйн салбар эзэлж байгаа. Бэлчээрийн даац хомсдол үүсээд 20 гаруй жил болж байна. Энэ хугацаанд мал аж ахуйн салбар уналтад орох нөхцөл үүссэн. Яагаад гэхээр олон тооны мал бэлчээрээс хангалттай хэмжээнийхээ тарга тэвээргийг авдаггүй. 60-70 хувийнхаа тарга тэвээргийг авч байна. Хангалттай тарга тэвээргээ аваагүй байгаа мал өвлийн хүйтэн, цас зудын нөхцөл байдалд тэсвэрлэх боломжгүй болсон. Ийм учраас зуднаар олон сая тонны мал хорогддог ийм нөхцөл дээр очсон. Энэ нөхцөлийг бид цааш нь хагас эрчимжсэн хэлбэрээр бэлчээрийнхээ даацад тохирсон илүү ашиг, шим сайтай мал аж ахуйн салбар болгож хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Монгол Улсын хувьд 1 малаас олж байгаа дундаж орлого өнөөдрийн байдлаар 31 доллар байна. 13 жилийн өмнө 22 доллар байсан. 13 жилийн өмнө 34 сая орчим байсан мал өнөөдөр 70 орчим саяд хүрсэн. Эргээд 1 малаас олж байгаа орлого нь 50 хувиар нэмэгдсэн ийм нөхцөлтэй байгаа юм. Тэгэхээр Засгийн газраас авч хэрэгжүүлэх энэ төлөвлөгөөний үр дүнгээр малын тоо тодорхой хэмжээнд буурах, малаас олдог орлого нэмэгдэх энэ нөхцөл боломжийг бий болгож өгнө.

Малчны сарын орлого дунджаар 1 сая 500 мянган төгрөг. Зардал нь 2 сая 100 мянган төгрөг байгаа юм. Тэгвэл Засгийн газраас энэ хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөний үр дүнгээр малчны сарын дундаж орлого 5 сая төгрөгт хүргэх боломжтой гэж Засгийн газрын зүгээс үзэж байна. Ер нь хөдөө аж ахуйн салбарт олон талын бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Өнгөрсөн цаг хугацаанд. Үр дүнтэй болсон нь байна, бас үр дүнгүй болсон нь ч байна. эхдээ анх удаагаа хөрөнгө оруулалтын зээлийг хоршооны гишүүн болж нэгдсэний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх боломж олгож байгаагаараа онцлог. Урьд өмнө нь ийм төрлийн арга хэмжээ огт авагдаж байгаагүй. 1 ёсондоо малчин бол 3 төрлийн зээлд хамрагдаж үйл ажиллагаа явуулах боломжтой болж байгаа юм. Хэрэглээний зээлтэй, хөрөнгө оруулалтын зээлийг энэ хөтөлбөрийн хүрээнд авна. Эргэлтийн зээлээ авч бизнес хийнэ. Үр дүнгээр нь малчин бол зөвхөн мал малладаг хүн биш юм. Малчид бол аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа явуулдаг, хөдөлмөрлөснийхөө үр шимээр илүү сайн сайхан амьдрах нөхцөл боломжийг өөрсдөдөө бий болгодог ийм нөхцөл рүү орно. Мөн дээрээс нь энэ хөтөлбөр хэрэгжсэний үр дүнгээр хот, суурин газрын төвлөрөл саарна. Хөдөөгийн хөгжил бодитой бий болно. Энэ асуудлаар Засгийн газар малчидтай уулзаж, олон талын судалгааг хийсэн. Нийт малчдын 80 хувь нь үндсэндээ хоршоонд нэгдэж, аж амьдралаа дээшлүүлэх, амьжиргаагаа сайжруулах бодлогыг дэмжинэ гэдгээ илэрхийлж байгаа гэдгийг бас танд хэлье ээ.

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Арай гайгүй сайд нь Амарбаясгалан сайд л даа. Гэхдээ таны наад хариулж байгаа юм чинь ерөөсөө ямар ч логик алга байна. Тэр чинь одоо бэлчээр нь дийлэхгүй гэж байна. Тэгсэн мөртөө малаа өсгө гээд байна. Өсгөсөн малынх нь гарч байгаа ашиг шимийг нь борлуулж чадахгүй. Тэр үйлдвэрүүд нь

хаачсан. Баахан макет хийсэн. Тэрийг асууж лавлаад байхад хэлэхгүй юм 1 дүгээрт.

Үгүй ээ, тэр авсан мөнгөө тэр хүн яаж зарцуулаад, яаж амьдралдаа зориулах нь тэр хүний, малчин хүн чинь бид нараас илүү ухаантай, хэрсүү. Юу нь болох, болохгүйг мэднэ шүү дээ. Тэгээд мөнгийг нь л өгчих л дөө. Үнэхээр өгөх гээд байгаа юм бол. Тэр хүн чинь өөрөө мэдээд зарцуулаад өөрийнхөө амьдралыг аваад явчихна. Тэгэхгүй заавал болохгүй, бүтэхгүй юм руу шахаад байх ямар хэрэгтэй юм бэ. Байгаль цаг уур нь болохгүй байна бэлчээр нь болохгүй байна. Гарч байгаа түүхий эд нь болохгүй байна. Тэгээд бас л үр дүнгүй салхинд хийсгэсэн баахан мөнгө. Тэгээд бодож олж байгаа юм нь нөгөө л хуучин хамтрал.../минут дуусав/

Г.Занданишатар: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Баянхонгор аймгийн Шинэжсинстээ сумд сайн чанарын ноолуур гаргадаг цагаан ямаа байдаг. Та мэдэх байх гэж бодож байна. Увс аймагт хүрэн ямаа байдаг. Та бас сонсож байсан байх. Энэ 2 ямаанаас гарч байгаа ноолуур хоёулаа 2 өөр чанарынх байдаг. Гэхдээ малчид ижилхэн үнээр зардаг байхгүй юу. Тэгэхээр Засгийн газраас хэрэгжүүлэх гэж байгаа энэ бодлогын үр дүнгээр цагаан ямааны 12 микронтой ноолуур дор хаяж 300 мянган төгрөгөөр зарж чаддаг хэмжээнд аваачих ёстой юм байгаа юм. Тэр 18 микронтой бүдүүн ширхэгтэй ноолуур гардаг ямааны ноолуур 150 мянгаараа зарж байж болдог энэ тогтолцоонд аваачна. Өнөөдөр ченжийн тогтолцоо яадаг вэ гэхээр малчид тэнд гуйж ноолуураа зарж байна. Ноосоо өгч байна, махаа өгч байна. Тэгвэл энэ хөтөлбөр хэрэгжсэний үндсэн дээр малчид бүтээгдэхүүнээ гаргаад, үйлдвэрүүд тэрийг нь сорчилж шилж худалдаж авдаг тэр тогтолцоонд шилжинэ.

Г.Занданишатар: Одоо болсон. Та тэртээ тэргүй мэдэж байгаа юм чинь. Та чинь Ванга шиг харж мэдчихээд байгаа юм чинь асуух хэрэг байгаа юм уу. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үгүй ээ, тэмээ гэхээр ямаа гээд байх юм. Тэгвэл ямаагаа ярья л даа. Үнэхээр Шинэжсинстийн Залаа цагаан гээд үйлдвэр байдаг юм манай. 12-оос бага микронтой. Дэлхийд бол гайхамшигтай л даа. тэгээд 300 мянгаар аваадах л даа. Одоо сайндаа л 180 хүрч байна. Та авахгүй л бол танай намынхан тэнд очоод ялахгүй шүү. Та нэгэнт л ам гарчихлаа. Тийм учраас энэ Занданишатар дарга миний микрофоныг хаах гээд байх шиг байна. Гэхдээ яах вэ, тэгээд эрх биш төрийн 3 өндөрлөгийн 1 болохоор авах л байх л даа саналаа. Тэр талаар бол бодлого явуулаагүй ээ. Үнэхээр өнөөдөр 8 жил засгийн эрх барьчхаад та нар гэнэтхэн гараад ирсэн юм шиг. Би тэр макет чинь яасан юм, үйлдвэр чинь хаачсан юм, тэр уул уурхайн бодлого чинь нийцэхгүй байна. Тэр төсөв яагаад тодотгодоггүй юм гээд яг тодорхой асуултууд асуугаад байна шүү дээ. Заавал тэр 1 нэгдэл нийгэм шиг хуучин байж байж.../минут дуусав/

Г.Занданишатар: Сая Амарбаясгалан дарга хариуллаа шүү дээ. Одоо ноолуураас 320 сая орчим долларын түүхий ноолуур экспортолдог юм. Одоо самнаад гаргадаг болоод 500 сая долларт хүрч байна. Малчид нийлээд одоо цаашид 700 сая доллар болно. Нийлээд хоршоо байгуулаад, Улаанбаатарт угаалгаж самнуулаад Италид гаргаж байна. Ховдын хоршоо. Тэгэхэд 150 доллароор зарж байна. Үгүй ээ, хүргэчихсэн. Хүргэчихсэн жишээнүүд ингээд хоршоод хамтраад ажиллахаараа болгочихсон жишээнүүд зөндөө бий. Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Энэ тулгамдсан асуудлыг шийдэхэд бол их чухал ач холбогдолтой байж таарна. Яагаад

гэвэл анхдагч хоршоо. Монголчуудыг ерөөсөө хоорондоо эвлэж нэгддэггүй жалгын амь амиа бодоод байсан юм шиг тэгж ойлгож болохгүй л дээ. Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг. Тэгээд цаашлах юм бол аравтын буюу арванаараа зохион байгуулагдаад ингээд л хэчнээн 100 жил, мянган жилээрээ амьдарч ирсэн. Тэр хуучин тогтолцооны одоо нэгдэл хэлбэрийн хувьд дээрээсээ захиргаадалтай, тогтолцооны хувьд бас асуудалтай юмнууд байсан байх. Одоо сайн дураараа эвлэлд нэгдээд энэ байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах, өнөөдрийн тулгамдаж байгаа олон асуудлаа шийдэх энэ бол зөв зүйтэй юм гэж. Анхдагч дундын хоршоо, тэгээд үйлдвэрлэгч, тэгээд үйлдвэрлэгчээс хэрэглэгч экспорт гэсэн ийм зарчмаараа явах нь бол мэдээжийн асуудал.

Би тодруулж асуух гээд байгаа юм хоёр зүйл байгаа юм. 1 дүгээрт бол энэ яг өнөөдөр байгалийн гамшигт нэрвэгдчихсэн ийм нөхцөл байдалд давын өмнө 3 асуудал. Зээлтэй холбоотой. Энэ гамшигийн хохирлыг яаж нөхөн төлөх юм, барагдуулах юм гэдэгтэй холбоотой асуудал. Тэгээд энэ малгүй болсон амьжиргааныхаа эх үүсвэрээс салсан малчдыг малжуулах, тэгээд цаашлах юм бол орлох ажлын байрных нь асуудлыг яаж цогцоор нь шийдэх вэ гэдэг юм дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй байгаа юм. Яг бодит байдал дээр зээл ямархуу байдалтай байна вэ гэвэл нэгэнт Засгийн газраас энэ арилжааны банкнууд даатгалын компаниудтай уулзаад, ер нь хугацааг нь бол сунгах нь, хүүг бол хөнгөлөх нь гээд ингээд шийдвэр гарчихсан байдаг. Шийдвэр албажиж хүрэхээс өмнө арилжааны банкнууд малчдаас гэрээгээ нөгөө 1 жилээр сунгасныг чинь биш 6 сараар гэрээг нь гэрээгээ сунгаад, тэгээд малчдын хүүг хөнгөлөлгүйгээр хүүг нь төлүүлээд байгаа ийм зүйлүүд байх юм. Тэгээд энэ дээр одоо анхаарахгүй бол энэ байдал чинь ингээд л улам цаашаа хавтгайрах нь гэж.

Дараагийнх нь юм бол энэ малжуулахтай холбоотой асуудал дээр яаж анхаарах юм. Энэ хуучин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авч хэрэгжүүлж байсан хэмжээ бага хугацаа мөн бага ийм малжуулах хөтөлбөрөөр бол ерөөсөө цаашаа явах ямар ч боломж байхгүй ийм зүйл байгаа юм. Яг одоо малаа алдчихсан ерөөсөө өнөөдөр, маргаашийг яаж өнгөрөөх вэ, ахуй амьдрал яах билээ гэж байгаа энэ хүмүүс рүүгээ хандсан ямар бодлого байх юм. Ийм 3 зүйл дээр их тодорхой юм хэлж өгөөч ээ гэж.

Дараагийнх нь юм бол энэ хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “малчин” гэсний дараа “мал бүхий иргэд” гээд нэмсэн байна. Энэ их зүйтэй, зөв. Дэмжиж байна. Тэгвэл нөгөө талд нь энэ төв суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээ, хүнсний аюулгүй байдал талаасаа хэрэгцээ хангамж талаас нь зүтгэж байгаа фермерүүд ямар хэлбэрээр оролцох юм бэ. Энэ фермерүүдийг нэмэх бололцоо байх уу гэж. Энэ бол ер нь маш чухал зүйл шүү. Тогтвортой. Хүн амын сүүний хэрэгцээ ч байдаг юм уу, махны хэрэгцээ энэ зүйлийг ч хангаж байна шүү дээ. Тэгэхээр ийм зүйлийг би асууж тодруулах гээд байгаа юм. Их баярлалаа.

Г.Занданшатар: 4 номер Ганхүлэг дэд сайд.

М.Ганхүлэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Яг одоогийн хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа ажилтай холбогдолтой асуулт асуулаа. Засгийн газрын хүрээнд бол 3 шатын арга хэмжээг малчдын асуудлыг шийдэх зорилгоор зохион байгуулж байгаа. Хамгийн 1 дүгээрт бол энэ зээлийн хүүг 1 жилээр хойшлуулаад, хүүг нь болохоор 75 хувийг нь Засгийн газраас төлөх, иргэд, малчид өөрсдөө 25 хувийн хүүг 1 жилийн хугацаанд төлөх энэ шийдвэр Монголбанкнаас гараад, арилжааны банкнууд руугаа мэдээллүүд нь очоод ингээд ажиллаад явж байгаа. Та бид бас орон нутгаар сая ажиллахад сумдууд

дээр бас зөрүүтэй мэдээллүүд, үүнтэй холбогдолтой бас сайжруулах ажлууд бас байгааг газар дээр нь танилцсан. Үүний үндсэн дээр бол яг Монголбанкныхан болон арилжааны банкнуудтай яриад, нэгдсэн мэдээллүүд өгөх ажлууд Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Засгийн газар дээр бас хийгдээд явж байна. Ямартай ч малчид маань бол өөрийн сум орон нутаг дээр байгаа арилжааны банкнууд дээр очоод, хүсэлтээ өгөөд, хүсэлтийн дагуу зээл бол 1 жилээр хойшлогдож, зээлийн хүүгийн төлбөрийн 75 хувийг нь бол төр хариуцаад ингээд 25 хувиа 1 жилийн хугацаанд төлөөд явах энэ боломжийг олгож байгаа юм. Үнэхээрийн цас зудын нөхцөл байдалтай байгаа 1 жилийн хугацаанд бас зээлийн асуудал дээрээ толгой амар байх, зээлийн хүүгийн хөнгөлөлт эдлэх энэ боломжийг хамгийн нэн тэргүүнд авч хэрэгжүүлж байгаа.

2 дахь асуудалд нь бол малжуулах хөтөлбөртэй холбогдолтой асуултыг асуулаа. 2024 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр төсөвлөгдсөн байгаа 22 орчим тэрбум төгрөгийг энэхүү малжуулах хөтөлбөрт зориулахаар бол тооцоолон ажиллаж байна. Яг өнөөдрийн байдлаар бид бүхэн 7 хоног болгон 70-аас дээш хувийн малын хорогдолтой малчин өрхүүдийн судалгааг аваад ингээд ажиллаад явж байгаа. Нийтдээ бол 4816 өрх бол өнөөгийн байдлаар бол бүртгэгдсэн байгаа. Энэ тоо энэ 5 сар дуусах хүртэлх хугацаанд бас нэлээн үргэлжилнэ. Тэгэхээр хагас жилийн мал тооллогын эцсийн дүн гарна. Энэ үеэр малын хорогдол өндөр байгаа малчин өрхүүдэд хуучин зохион байгуулж байсан хөтөлбөрийг илүү сайжруулан хүргэнэ гэдэг энэ мэдээллийг өгөх байна. Бид бүхэн хуучин бол 5 орчим сая төгрөгийг малаа алдсан иргэдэд бас олгодог байсан бол энэ тоог 8 хүртэлх сая төгрөг болгож нэмэгдүүлэхээр тооцоолон бас ажиллаж байна.

Мал бүхий иргэдтэй холбогдолтой саналыг бас Байнгын хорооны хэлэлцүүлэг дээр болон ажлын хэсэг дээр

бид бүхэн ярьж бол нэмэгдүүлсэн. Одоогийн байдлаар хоршооны гишүүн мал бүхий иргэд бас орж байгаа. Энэ нь хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэдэд урамшуулал олгож байсан үеийн энэ зохион байгуулалтаас хамаарч бас нэлээдгүй гишүүд бол орж ирсэн. Мал бүхий иргэд нь бол сум багт ажиллаж байгаа төрийн албан хаагч, мөн бусад чиглэлийн малын эрүүл мэнд, үржлийн ажил төрлийг зохион байгуулдаг ийм мэргэжлийн бас хүмүүс нэлээдгүй байдаг. Энэ утгаараа энэ хуулийн төсөл дээр зөвхөн малчин байхаас гадна, мал бүхий иргэдийг нэмж оруулах нь энэхүү бас төсөл хөтөлбөр илүү бас мэргэжлийн, мөн бизнес утгаараа бас хэрэгжээд явах боломж нь бүрдэх нөхцөл юм гэж үзэж ажлын хэсгээс малчин болон мал бүхий иргэдэд энэхүү бодлогыг чиглүүлэн ажиллая гэдэг энэ саналыг дэвшүүлсэн байгаа.

Г.Занданшатар: Тодруулах уу. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр миний асуултад би хариултаа авч чадсангүй л дээ. Тэр фермерүүдийг оруулж байна уу, үгүй юу гэдгийг хэлж өгөөч ээ гэж.

Дараагийнх нь юм бол энэ зээлтэй холбоотойгоор энэ банкнууд чинь бол яриа хэлэлцээр хийгээд нэгэнт тогтчихсон шийдвэр гарч албажих нь тодорхой байхад зориудаар сумуудад байгаа арилжааны банкнуудын төлөөллүүд чинь шахаж байгаад малчдыг энэ хуримтлагдсан хүүгээр нь хүүг нь төлүүлээд, ингээд гэрээгээ сунгаад яваад байна шүү дээ. Тэгэхээр 1 жилээр сунгаж чадаагүй хүүгээ тэр өндөр дүнгээр нь төлчихсөн энэ малчдын эрх ашгийг яаж хамгаалах юм бэ. Эргэж энийг нь авч үзэх юм уу. Одоо тэгээд бандан тас гээд цаашаа явах юм уу. Энэ чинь бол бас төвөгтэй ийм асуудал бий болгоод байна шүү дээ.

Г.Занданшатар: Дашизвэгийн Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Малчин болон мал бүхий иргэн хамрагдах боломжтой гэж байгаа юм. Ферм гэж тусад нь заахгүй. Гэхдээ фермийн үйл ажиллагаа явуулж байгаа хагас эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа иргэд өөрсдөө малчин мал бүхий иргэн гэдэг статуст бүрэн багтдаг учраас малчин болон мал бүхий иргэн гэдгээрээ л тодорхой явж байгаа юм.

2 дахь нь зээлийн эргэн төлөлтийг хэрэглээний зээлийн шүү. Өмнөх авчихсан байсан хэрэглээний зээлийн эргэн төлөлтийг 1 жилээр хойшлуулсан. 1 жилийн хугацаанд хуримтлагдах хүүгийн 75 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын батлагдсан багцаас төлж барагдуулна. Энэ ажил хэрэгжээд эхэлсэн явж байгаа.

Г.Занданшатар: Бадмаанямын Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Энэ арилжааны монопол банкнууд чинь увайгүй байна л даа. Ингээд нэгэнт Засгийн газартай яриа хэлэлцээр хийгээд тодорхой болчихсон юмыг цаг наргүй шахаж байгаад малчдаас гэрээгээ сунгалгүйгээр хийгээд, тэгээд хүүг нь авчхаад байгаад байгаа байхгүй юу. Тэгээд ер нь банк даатгалын компаниуд гэж ер нь хамаг л ашигийг нь хамж авч байдаг. Энэ хүмүүс тэр арилжааны бизнесийн гэрээ хийчихээд малчинтай тэгээд энэ учирсан хохирол нь банкны эрсдэл гэж өөрөө хариуцах ёстой зүйл баймаар юм шиг санагдах юм. Тэгээд одоо амар жишээлэх юм бол төрөөс одоо 75 хувийг нь төлүүлчээ, тэгээд нөгөө өндөр ашиг нь энэ банкнууд чинь өөрсдөд нь ингээд хэвээрээ байгаад байна шүү дээ. Энэ банкнууд бол арай болохгүй байна гэж би ингэж л үзэх гээд байгаа ийм зүйл шүү дээ. Тэгсэн мөртөө ингээд ийм тодорхой байж байхад чинь шахаж байгаад ингээд малчдаар нөгөө хуримтлагдсан өндөр хүүтэй зээлийн хүүг нь төлүүлээд ингээд хугацааг нь

сунгахгүй ингээд ийм маягаар.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Ганхүлэг дэд сайд аа, Монголбанк руу өнөөдөр л нөгөө гэрээний бичиг очоод, арилжааны банк руу хүлээгдэж байгаа юм байна лээ. Энэ малчид бас нөгөө зээлийн хөнгөлөлт, хугацаа сунгалт удаашраад байна гэж маш их асуугаад байгаа юм. Арилжааны банкнууд одоо л чиглэл нь очиж байгаа юм байна лээ шүү Ариунбат дарга энийг та нар анхаарч, шуурхайлах талаар ажиллах хэрэгтэй.

2 дугаарт Ганхүлэг дэд сайд бас нөгөө Баян-Овоо сумынх байх аа Бат-Эрдэнэ аварга аа, нөгөө аравтын зохион байгуулалтад орсон. Тэгээд Хэнтий аймгийн малчин өрхийн нэгдсэн холбоо байгуулсан шүү дээ. Одоо тэр 10 гэрийн зохион байгуулалт зудыг давахад хамгийн сайн туршилага болж байгаа нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын туршилага дээр үндэслээд энэ малчин өрхийн нэгдсэн холбооны хууль чинь амьдрал дээр уялдсан, хуучин уламжлалт давуу талыг ашигласан ийм зохион байгуулалтын нэгж. Цаашидаа тэгээд багийн хурал гэж болдоггүй. 10 гэрийн дарга нар цуглаад л багийн хурлаа хийчихнэ. Багийн хурлаасаа сум, сумын дарга нараа сонгох энэ тэр гээд ийм мал аж ахуйтайгаа уялдаатай ийм зохион байгуулалтын системд оруулж байх юм бол сумын дарга ч гэсэн ер нь цаашидаа ИТХ гэхээсээ илүү энэ малчдаасаа 10 гэрийн дарга нараас дамжуулаад сонгодог энэ тэр гээд ийм зохион байгуулалтын хэлбэрт орж ирж хоршооллоо ч дэмжинэ. Малчдын бэлчээрийн зохицуулалт, малын үржил угсаа сайжруулах энэ бүх ажлыг дэмжих ийм ажил хийгдэх юм байгаа юм. Энэтэй уялдах юм байгаа юм эд нар чинь бүгдээрээ. Ер нь зүгээр малчид тоогоо нэмэгдүүлээд байна гээд манай Ганбат, зарим гишүүд шүүмжлээд байгаа юм л даа. Малчид зайлуул юмны үнэ өсөөд байхаар гурил будааны үнэ өсөөд байхаар чинь тэгтэл орлого нь түүхий эдийнх нь үнэ өсдөггүй бага байгаад байхаар малынхаа тоо толгойг

нэмж байж л тэр худалдан авалт, хүүхдийн сургалтын төлбөрөө төлөхгүй бол болохгүй болоод, амьдралд шахагдаад малын тоо толгой өсөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр нийт малчдын 80 хувь нь 500 хүртэл толгой малтай. Дөнгөж 5-хан хувь нь 1000-аас дээш толгой малтай байдаг. Тийм учраас энийг бол их сайн эдийн засгийн скиллийнх нь хувьд, хэмжээнийх нь хувьд нэгтгэж томорч байж хоршоо болж байж л ерөөсөө хөгжих юм байна лээ гэсэн санааг л энэ хуульд суулгаад байгаа юм.

Ингээд Содномын Чинзориг. Сайд нар асуулт асуухгүй гэсэн. Засгийн газраас өргөн барьсан хууль дээр. Одонгийн Цогтгэрэл. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Ер нь бидний энэ ярьж байгааг одоо ч малчид хараад сууж байгаа. Тэр нөгөө зээлийн хүү, зээл хойшлуулах, зээлийн төлөлтийн асуудал дээр яг хэзээнээс эхлэх вэ гэдгийг тодорхой хэлж өгөхгүй бол энэ зудын асуудал яригдаж эхэлсэн цагаас хойш банк, банкны ажилтан, малчин 2 бол өнөөдрийг хүртэл муудсаар байгаа шүү. Уржигдар би Хэнтий аймгийн Батноров сумын Төрийн банк, Хаан банкаар ороход бас л ямар ч сураггүй, чимээгүй, ажиггүй байна. Сүхбаатар аймгийн зарим тооцооны төвүүд рүү утасдахад тиймэрхүү байдалтай байна. Тэгэхээр бол яг Монголбанкнаас энэ бичиг нь явсан юм уу, яваагүй юм уу. Яваагүй бол хэзээ явах юм. Энийгээ яг тодорхой болгохгүй бол одоо зээлийн энэ асуудал чинь бол бас тийм тоглоомын хүлээх аргагүй болоод байгаа юм байна лээ шүү. Олон малчид мессеж бичээд байгаа. Та нар ингээд зурагтаар яриад л байх юм, яриад л байх ю. Банк дээр очихоор өөдөөс загнаад байна гээд. Тэгэхээр энэ дээр бол бүр тодорхой хугацааг нь хэлээд, тэр банк нь байдаг уу, Монголбанк нь уу. Аль нь байх вэ, арилжааны банкууд нь байх уу энийгээ бас нэг яримаар байгаа юм.

Ерөнхийдөө бол энэ хуулийг бол дэмжиж байгаа юм. Үнэхээр бас сая олон малчинтай уулзлаа. Үнэхээр энэ мал аж ахуйг цаашидаа яаж авч явах вэ гэдгийг бодохгүй бол өнөөдөр маш хүнд байдалд байна. Ийм арга хэмжээ авахгүйгээр дахиад 2, 3 жил сайхан өнтэй болж байгаад, 4 дэх жил нь дахиад зуд болоод бүгдийг нь аваад явчихвал яах вэ гээд л олон зүйлүүдийн тайлал энэ хууль болж байна гэж харж байгаа. Харин энэ дээр би Байнгын хороо дээр ч бас хэлсэн. Тэр 5 га-г тэр хоршоонд өгнө гэдэг бол бас тийм зөв ч зүйл биш дээ. Харин багаараа байдаг юм уу, эсвэл 2, 3 хоршоо нийлээд байдаг юм уу, ер нь 50-аас дээш га дээр тарьж байж нэгж зардал нь багасна. Ашиг нь нэмэгдэнэ. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум дээр бол 120 өрх 200 га дээр тарьж, 45 мянган боодол өвс авч, ногоон тэжээл авч байгаа байхгүй юу. Тэгэхээр яг ингээд 5, 5-аар нь хуваана гэвэл наадах чинь зардал ч өндөртэй, үр ашиг гарахгүй байж магадгүй гэж би яг амьдрал дээр бол тийм юм байдаг учраас болгоомжлоод байгаа юм. Нэгд тэр.

2-т сая манай энэ Их Хурлын дарга яриад байна. Баян-Овоо сумын тэр жишиг бол сайн жишиг. Бид нарыг нэгдэж нягтраа ч гэсэн бид нар 10-т боллоо. Одоо энэ 10-т болсноороо бид нар хоршоо болоод ингээд энэ зээл хүү авъя гээд. Малчид өнөөдөр 20-22 хувийн хүүтэй зээл авч энэ мал аж ахуйг эрхэлж байгаа юм. Одоо энэ хууль гарснаараа жилийн 6 хувь гэдэг чинь хүүгийн дарамтаас бол 4 дахин багасах байхгүй юу. Тэгэхээр би бол харин ингэж харж байна. Харин нөгөө талдаа бүр эцсийг нь бид хөгжүүлбэ гэвэл энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтайгаа нийлүүлж тэр арьс ширний асуудлууд, махны экспортын асуудлыг нь хил залгаа боомтоор нь гаргах, малаа эрүүлжүүлэх, магадгүй энэ хоршоод 1 малын эмчтэй тэр нь бүх арчилгаа сувилгаа, тариа юугаа ч хийдэг байх юм бол өнөөдрийн мал эмнэлгийн тогтолцооноос даруй үсрэнгүй бас үр дүн гарч эхлэх болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ дээр

ажлын хэсгүүд ажиллаж байгаа байх. Энэ саяын миний хэлдэг 3 зүйл дээр бас анхаараад яваасай л гэж би бас хүсэх гээд байгаа юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Үг байхгүй. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжих, дэмжихгүй чинь нөгөө хэлэлцэх эсэх дээр хэлдэг юм. Энэ чинь анхны хэлэлцүүлэг. Байхгүй. Зармын зөрүүтэй саналыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Малчин” гэсний дараа “, мал бүхий иргэн /цаашид “малчин” гэх/” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Гонгорын Дамдинням, Ганзоригийн Тэмүүлэн, Одонгийн Цогтгэрэл, Цэдэндамбын Цэрэнпунцаг цаашид “ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон шүү. Үг хэлье гэсэн учраас. Энэ саналыг дэмжсэн, дэмжээгүй Батсуурь гишүүн үг хэлье гэсэн. Жамбын Батсуурь, Дашидондогийн Ганбат нарын гишүүдээр тасаллаа.

Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

Ж.Батсуурь: Асуудалд бол би ингэж хандаж болохгүй гэж бодож байна. Яагаад вэ гэхээр яг энэ асуудлыг 2015 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Мөнхбат гуай ярьж байсан. Өнөөдөр малын арьс ширний үнэ боодол бохь л авч байна гэж байна. Өнөөдөр арьс шир боодол бохь ч авч чадахгүй болчихсон 1 дүгээрт.

2 дугаарт 8 жил асуудлыг шийднэ, шийднэ гэхээд парламентын хугацаа дуусахад 2-хон сар дутуу байхад яаралтай горимоор асуудлыг оруулж ирж, ингэж асуудалд хандаж байгаа нь бол туйлын буруу. Туйлын буруу. Дээр нь энэ хууль санаачлагч нар ард иргэдтэйгээ очиж уулзахгүй байна. Яг малчин ард иргэдээс асуух юм бол та нарын энэ байр сууриас чинь эсрэг асуудал ярина.

2-т гэвэл би сүүлийн үед нэг зүйлийг ерөөсөө ойлгохоо байчихлаа. Хөдөө аж ахуйн сайд нь ингээд бомбойгоод суугаад байх юм. Тэгсэн мөртөө хөдөө аж ахуйн асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь оруулаад ирэх юм. Гурилын үнийн асуудал...

Г.Занданишатар: Батсуурь гишүүн ээ, зөвхөн энэ саналыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Та бүр ингээд хэлэлцэх хэсэг дээр ярьсан үг яриад байгаа юм биш үү. Ажлын хэсэгт Болорчулуун сайд байгаа.

Ж.Батсуурь: Байж байгаарай. Би үгээ хэлчихье.

Г.Занданишатар: Зөвхөн мал бүхий иргэн гэдэг дээр л дэмжсэн, дэмжээгүй санал хэлнэ.

Ж.Батсуурь: Үгүй ээ, миний үгийг бүтэн хэлүүлчих л дээ. Ер нь ийм байхгүй юу. Өөрсдийг нь магтаад байх юм уу, дэмжээд байх юм бол бид нарыг гаргаад л байна. Оройжин ч гаргаж магадгүй. Жаахан шүүмжлэлтэй хандангуут л үг хэлүүлэхгүй. Үгүй ээ, үгүй. Та нарын л ажилд хэрэгтэй шүү дээ. Тэгээд үнэнийг нь хэлэнгүүт тэгээд одоо ер нь үг хэлүүлэхгүй болох юм байна л даа. Одоо тэгвэл энэ зарчмын зөрүүтэй санал болгон дээр үг хэлнэ шүү. Харин угаасаа дэг байгаа. Тэгээд ингээд үг хэлүүлэхгүй хамаг цаг бараад хаячих юм.

Баян-Овоо сумын турилага, Баян-Овоо сумын турилага гээд байх юм. Баян-Овоо сумын чинь ихэнх мал нь

хорогдоод дуусчихсан юм байна лээ шүү дээ. Тэгвэл тэр.../минут дуусав/

Г.Занданшатар: Энэ саналтай огт холбоогүй санал байна. “Малчин” гэсний дараа “мал бүхий иргэн” гэж нэмэх гэсэн ийм санал байгаа. Энийг дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Энэ саналыг, тухайн саналын томъёоллыг. Тэгээд аймаг, орон нутаг руу хамаагүй дайрч хэрэггүй. Мал бүхий иргэн чинь сумын төвийн багш, төрийн албан хаагчид голцуу л малаа айлд тавьчихсан байдаг. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үгүй ээ, одоо энэ мал бүхий иргэд, малчин гэвэл бүгдээрээ л малчид шүү дээ. Малтай л бол малчин шүү дээ. За яах вэ, яах вэ. Тэгээд одоо энэ хууль маань тэгээд малтай хүнд л малчин гэдэг энэ нэр томъёонд л нийцсэн ийм хууль гэж ойлгоё. Тэгээд үүнээс гадна байна шүү дээ 600 малтай байж байж амьдрал ахуйд нь арай хүрнэ гэж байна шүү дээ малчин хүнд бол. Үгүй ээ, энэ жилийн өмнө 1 шуудай гурил 50 мянга л байсан шүү дээ. Тэгээд өнөөдөр 100 мянга гарчихлаа. Гэтэл энэ малчин хүний орлого ямар байна. Яг л хэвээрээ байгаа шүү дээ. Улам л унаад байгаа. Тэгээд энэ бүхнийг шийдэхгүйгээр, тэгээд улсын төсөвт энэ мөнгийг суулгахгүйгээр, төсвийн тодотгол хийхгүйгээр энэ бүгд чинь худлаа шүү дээ. Зүгээр л энд хий хоосон зүйл яриад л ингээд л, хөөрхөн аргалаад хэдэн санал авах гэж байгаа малчдаас ийм л байдалтай болчихоод байна. Тэр 10 хувийн унасан гэдэг нь үнэн. Эдийн засаг бол. Гэхдээ хүн амын 10 хувь нь малчин байгаа. Эдийн засгийн 10 хувь нь хөдөө аж ахуйгаас хамаарч байгаа. 20 хувь нь малчин байгаа гэдэг нь хамгийн ажил олголттой ийм 30 хувь байгаа гэдэг нь бол үнэн. 35 хувь гэдэг нь бол үнэн байгаа. Тийм. Гэхдээ бас энэ хүмүүсийн орлого ямар байна вэ малчдын маань. Тэгээд бэлчээрийн даац нь хэтэрчихсэн байна. Бэлчээр нь дийлэхгүй байна. Энэ уул уурхай чинь шахаад байна. Байгаль чинь шахаад байна цаанаасаа. Ийм нөхцөлд нь тааруулаад хуулиа хэлэлцэж,

ярих ёстой байтал зүгээр жижүүрийн өдөр өнгөрөөх маягаар хэдэн төгрөг өгчих гээд л, хэдэн төгрөг өгсөн ч яг хувь хүнд нь өг л дөө. Тэгээд заавал хүнд суртал гаргаад л хоршоолоод л арвуулаа бай гэнэ. Тэр 1000 малтай 10 хүн нэг дор цугларахаар тэр бэлчээр нь дийлэхгүй шүү дээ. Ийм амьдрал мэдэхгүй наад захын юм ойлгохгүй хүмүүс энд суучхаад л хууль яриад байж байхад энэ малчид бол ёстой хөх инээд нь хүрээд л харж байгаа шүү дээ. Үгүй ээ, арай ч дээ эд нар л гэж байгаа. Үгүй ээ, амьдрал тийм л байгаа шүү дээ. Бүхэл бүтэн Хөдөө аж ахуйн яам байж байдаг. Бэлчээр чинь дийлэхгүй байна шүү дээ. Даац нь хүрэхгүй байна. Цаанаасаа байгаль нь шахаж байна. Тэгэхээр энэ малчин, мал бүхий иргэд энэ тэр гэдэг юмаа бас сайн тодорхой болгоод, амьдралд нийцүүлээд юмаа ярьж байвал зүгээр байна. Тэгээд энэ мөнгө төгрөгийг нь шийдэж өгнө гээд яриад байдаг. Түрүүчээсээ очихгүй байна. Бас нэг худлаа, ээлжит нөгөө шилний цаанаас мөсөн чихэр билүү, мөхөөлдөс долоолгодог ажлаа л хийж байна л гэж байна шүү дээ. Тэгээд ийм байгаад байдаг. Тэгэхээр ийм юмнуудаа өшөө сайн хэлэлцье. Энэ хуулийн үг, үсэг дээр эх үүсвэрийг нь сайн тавья, тодотгоё. Ийм түргэн, түүхий юм хийгээд, түрүүчээсээ хэдхэн овтой, зальтай нөхдүүд дандаа л МАН-ын нөгөө толгой угаадаг хэдэн хүмүүстээ зээл өгөөд л, ард нь нийт малчдын тэр чигээрээ хохироод л үлдсэн. Татвар төлөгчдийн мөнгийг ээлжилж салхинд хийсгэсэн ийм байж болохгүй ээ. Тэгэхээр малчин болгонд нь өгөөд л явчих. Ахиад тийм хүнд суртал гаргаад энэ тэр бол хэрэггүй. Тэр гамшигийн бол давагдашгүй хүчин зүйл гэдэг нь үнэн. Дээр нь бол энэ банкнуудыг бас сонголттой болго. Ганцхан банк тулгаад байгаа шүү дээ бид нар чинь. Хаан банк. Тэрийгээ л хэн нь ард нь байдаг юм, яадаг юм. Мэдэхгүй. Бүгд л дэмжээд л тэтгээд байдаг. Тэгээд 30 жил энэ чинь 30, 40 хувийн хүүтэй, 20, 30 хувийн хүүтэй зээлээр малчдаас хувалз шиг сорлоо шүү дээ. Тэгээд ийм үед нийгмийнхээ хариуцлагын хэмжээнд даатгалын

хэмжээнд энэ бүх мөнгөө 1 удаа бол нолилуулчхаж болно. Эд нарын ашиг нь гэхэд 500.../минут дуусав/

Г.Занданишатар: Санал хураалт явуулъя. Үзнээс хойш дэгээрээ явна шүү. Ингээд та 2 барьцаад эхэлж байгаа биз. Одоо хоёуланг чинь үг хэлүүлэхгүй. Санал хураалт. Уначхаж л байгаа юм байна даа. Тэгвэл унаснаараа л явчихъя. Хоршоо байгуулахад малчид л мал аж ахуйн хоршоог байгуулна шүү дээ. Энэ санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “нөхцөлийг” гэснийг “бодлогын болон эрх зүйн орчныг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг. Санал хураалт.

Засгийн газраас өргөн барьсан саналаараа л явж байна шүү дээ. Санал дээрээ мал бүхий иргэн гэж оруулж ирээгүй юм байна.Тэгээд тэр бодлогыг нь л дэмжиж байна гэж ойлголоо. Ер нь хоршоог бол хэн ч байгуулж болно. Хоршооны хуулиар. 21 гишүүн дэмжиж 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.3.бэлчээрийг улирлын онцлогтой уялдуулан ашиглах, хамгаалах, доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх бодлогыг тодорхойлох.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ. Энэ саналаа дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ шүү.

Ж.Батсуурь: Таслахгүй шүү дарга аа, Та минийхийг таслаад Ганбат гишүүнийг болохоор нутгархаад яриулаад байна шүү та. Та нар хэзээ дэг барьдаг байсан юм. Ядаргаа. Энэ ийм учиртай юм. Угаасаа энэ хууль чинь явахгүй байна шүү дээ. Бүх хүн дургүй байна. Засгийн газрын гишүүд нь дэмжихгүй байна. Болохгүй ээ гэдэг нь нөхцөл байдлаар нотлогдоод байхад чинь

ингээд зүтгүүлээд яах гээд байгаа юм бэ дээ. 1 дүгээрт.

2-т гэвэл ингэж байгаа юм. Малчдын эрсдэлээс өнөөдөр 10-15 их наядын хохирол амсчхаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт малжуулах бодлогод 20 тэрбум төгрөг яриад байх юм. 20-хон тэрбум төгрөг чинь 40 мянган мал шүү дээ. Тэгээд одоо ингээд 6-10 сая мал үхчхээд байхад чинь нөгөө талд нь 40-80 мянган малаар малжуулна гээд ингээд бүх хүн тэрийг авах байх гээд ингээд горьдоод сууж байгаа байхгүй юу. Ийм худлаа хуурамч юм хэрэглэх хэрэг байгаа юм уу. 1 дүгээрт.

Энэ доторх байгаа заалтуудаас хэрэгжих заалт нэг ч байхгүй. Би мэргэн хүн шиг хэлье. Би өөрөө малчин хүний хүүхэд. Хөдөө өссөн. Би цэцэрлэгт ч явж байгаагүй, шууд би малын захаас сургуульд орсон. Та нар ер нь мал дээр очсон ч юм уу, үгүй ч юм уу. Мэдэх ч үгүй байх. Үгүй ээ, тэгээд мэдэж байгаа нь хаана байгаа юм. Мэдэж байгаа нь хаана байгаа юм. Тэгээд асуудалд ингэж хандаж болохгүй ээ. Энд байна аа Малчны эрх зүйн байдлыг дээрдүүлж байгаа зүйл ерөөсөө байхгүй байна. Заавал хүнийг хоршоонд хамрагдвал зээл өгнө. Хоршоонд хамрагдахгүй бол зээл өгөхгүй гэдэг чинь одоо яаж болох юм бэ. Өнөөдөр өөрөө 5, 10 сая төгрөгийн зээлтэй, 20, 30 сая төгрөгийн зээлээ яая гэж байхад чинь та хоорондоо бөөгнөчих юм бол, хоорондоо нийлчих юм бол 50 хүртэлх сая төгрөгийн зээл өгнө гэдэг чинь бол хүмүүсийг доромжилж байгаа асуудал шүү дээ.

2 дугаарт Баян-Овоо сумын турилагаар хоршоолуулах гэж байгаа юм гэнэ. Хэрвээ Баян-Овоо сум чинь сайн турилагатай байсан бол энэ жил мал нь хорогдохгүй юм байгаа биз дээ. Тэгэхэд чинь Баян-Овоо сумын чинь.../минут дуусав/

Г.Занданишатар: Санал хураалт явуулъя. Санал хураалт. Байгалийн гамшигийн асуудлыг ингэж улс

төржүүлж болохгүй. 64,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “гамшигийн эрсдэлийг урьдчилан тооцох,” гэсний дараа “эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үндэсний чадавхыг бэхжүүлэх,” гэж нэмж и, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг хасаж, 6.1.8 дахь заалтыг 7.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.6.тэжээлийн ургамлын тариалалт, тэжээлийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Танд сануулж байна. Хурал хурал үймүүлэхгүй байхыг хүсье. Сануулж байна. Дараагийн удаа бүр үг. Та дэгээ бариарай. 21 гишүүн дэмжиж, 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “төсөв хооронд” гэснийг хасаж, 6.2 дахь хэсгийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон” гэснийг хасаж, дугаарыг 6.3 дахь хэсэг болгон өөрчилж, төсөлд 6.2 дахь хэсэг нэмэх:

“6.2.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 61,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Танд дэг зөрчөөд байгааг сануулчихсан. Дэгийн дагуу та тухайн саналын талаар ганц ч удаа үг хэлсэнгүй. Тийм учраас дэг зөрчсөн учраас танд сануулах арга хэмжээ авч байна.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “малчдад таниулах, сурталчлах” гэснийг “боловсруулж, батлуулах” гэж, 7.1.4 дэх заалтын “малын үүлдрээр” гэснийг “бүс нутгийн онцлогт тохирсон, баталгаажсан

үүлдэр, омгийн малаар” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 61,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “нийтлэг стандартыг” гэснийг “талаар байгалийн бүс нутгийн онцлогт тохирсон стандарт” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг. Санал хураалт. 1 л стандарт байна. Бүс нутгийн стандарт гэж байдаггүй л юм л даа. 61,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын 9.1.4, 9.1.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.4.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах;

9.1.5.өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Та 8 дахь удаагаа чуулганы дэг зөрчиж, сануулах арга хэмжээ авсан байгаа. Дараагийн арга хэмжээ нь чуулганы хуралдаанаас гаргах арга хэмжээ. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “, хяналтыг” гэснийг хасаж, мөн зүйлд дор дурдсан агуулгатай 10.1.5, 10.1.6, 10.1.7 дахь заалт нэмэх:

“10.1.5.өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;

10.1.6.малын гаралтай түүхий эдийн анхан шатын ангилалт, тордолт хийж, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, стандарт техникийн

зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх;

10.1.7. малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталж, үе шаттай хэрэгжүүлэх;" Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Та удаа дараа дэг зөрчиж, холбогдолгүй асуудлаар бусад аймаг ялгаварлан гадуурхах, шүүмжлэлтэй хандах Үндсэн хууль зөрчсөн агуулгатай үг хэлж, байгалийн гамшигийг ч гэсэн хүний хүчин зүйлтэй холбож ингэж хамаагүй ярьж болохгүй л дээ. Тийм учраас би дэг зөрчсөн гэж үзэж байгаа юм.

10.Төслийн 13 дугаар зүйлийн Хууль хүчин төгөлдөр болох хугацааг “2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, шилэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

Төслийн 5 дугаар зүйлийн гарчгийн “Хурлын бүрэн эрх” гэснийг “Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж, 5.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “газрын бүрэн эрх” гэснийг “газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж, 6.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “үйл

ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 7.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 8.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Содномын Чинзориг сайд, Тогтохсүрэн дарга 2 дэмжсэн учраас та яг энэ найруулгын саналтайгаа холбоотой үг хэлнэ шүү. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Та одоо ингэж асуудалд хандаж болохгүй ээ. Та одоо өөрөө дэгээ зөрчихөөд. Нүдэн дээр энэ олон хүмүүсийн нүдэн дээр 10 удаа.../минут дуусаав/

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

2.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 9.1.4 дэх заалтын “малчинд” гэснийг “малчин, мал бүхий иргэнд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Эхний санал уначихсан учраас энийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Энэ санал уначихсан учраас энийг гүйцээн боловсруулах чиглэл өгч, ярилцах хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ мал бүхий иргэд байдаг байхгүй юу. Одоо Анужин, Болорчулуунаас авхуулаад бүгдээрээ. Ашиг сонирхлын зөрчилтэй хууль баталсан болж сүүлд нь хэлэгдэнэ. Тэгээд одоо баахан хөнгөлөлттэй зээл авчихна.

3.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “аж ахуйн нэгж, байгууллагад” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх” гэж, 33.5 дахь хэсэгт “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл” гэж тус тус нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд. Санал хураалт. 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд оръё.
“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа танилцуулна. Индэрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүнээс 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төслийн 1 дүгээр зүйлийн “автomaшины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэснийг “автomaшины нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “автомашинны нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэснийг “автомашинны нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн Энхамгалан сайд санал хураалт санал хураалт 25 гишүүн дэмжиж, 64,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зыарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

16.59 цаг.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын гишүүд 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2024 оны 4 сарын 4-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, Сандаг-Очир нараас цагаатгуулах гомдол гаргах, хүлээн авах хугацааг хүчингүй болгож, цагаатгуулах гомдлыг хэдийд ч гаргаж болгох талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллолтой

холбогдуулан цагаатгуулах гомдол гаргах, хүлээн авах хугацааг хүчингүй болгох үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтаа явуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг

хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Дамдины Цогтбаатар. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад Тэмүүлэн дарга аа, Бямбацогт гишүүн ээ суудалдаа суугаарай. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 65,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

17.03 цаг.

Дараагийн асуудалд орно. 7 дахь асуудал. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна.

Таныг дуудаад байхад чинь хуулийг чинь хэлэлцэх гээд байхад яагаад та гарч яваад байна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Их хуралд өргөн барьж, өчигдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээд, өнөөдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын иргэдийн дунд Д гепатит вирусийн халдвартай иргэдийн тоо өндөр байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан аргачлалаар 66 мянган иргэн Д вирусийн халдвартай

байх магадлалтай гэсэн ийм тооцоо байна. Д вирусийн халдвартай гэсэн иргэдийн төлөөллийн байгуулсан төрийн бус байгууллагын судалгаагаар 150 мянган иргэн байгаа гэсэн ийм бас тооцоо байгаа.

Монгол Улсын Засгийн газраас Д вируст иргэдийг эмчилгээнд хамруулах олон талын арга хэмжээ авч ажиллаж байна. Д вирусийг эмчилдэг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бүртгэсэн нэг л одоо төрлийн эмчилгээ байгаа. Энэ нь пег-интерферон /Peg-Interferon (**P-IFN**)/ эмээр Д вирусийг эмчилдэг гэсэн ийм нэг л эмчилгээ байгаа. Гэхдээ энэ нь бас Д вирустэй иргэдийн төлөөллийн төрийн бус байгууллагаас байгуулсан иргэдийн төлөөллийн байгууллагаас бас гэж нөлөө ихтэй учраас энэ эмчилгээг хийлгэхийг нэлээн эсэргүүцлээ бас илэрхийлдэг ийм асуудлуудтай байна. Одоогийн Д вирусийг эмчилдэг нэг л төрлийн эм байна. Энэ нь АНУ-ын **“GILEAD Sciences”** компанийн үйлдвэрлэсэн **“Булевиртид”** (Bulevirtide) гэдэг эм байна.

Гэхдээ энэ эмийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага одоогоор бүртгээгүй. Харин Европын холбооны улсууд бүртгэж, эмчилгээнд хэрэглэж байгаа болно. Энэ эмийнх нь 1 сарынх нь эмчилгээний зардал асар өндөр өртөгтэй тул энэ эмчилгээний зардлыг бууруулах зайлиггүй шаардлагатай байна.

Эрүүл мэндийн сайд АНУ-ын **“GILEAD Sciences”** компанийн удирдлагуудтай 2 удаа цахимаар уулзалт хийж, 1 удаа Азийн бүсийг хариуцсан захиралтай нь биечлэн уулзаж, энэ эмчилгээг Монгол Улсад эхлүүлэх, нөгөө талаасаа 1 сарын эмчилгээний зардлыг бууруулах талаар удаа дараагийн хэлэлцээрийг хийж байгаа.

Бид нар цаашидаа иргэддээ санхүүгийн дарамтаас чөлөөлөх, хөнгөлөх үүднээс АНУ-ын **“Булевиртид”** (Bulevirtide) эмийг Д вирусийн эмчилгээнд хэрэглэж эхлэх үед гаалийн татвараас

чөлөөлсөн байх нь иргэдийг бас санхүүгийн дарамтаас чөлөөлөх ийм нэг үндэслэл болно гэж үзэж Гаалийн татвараас чөлөөлөх хуулийн төслийг өргөн барьж, хэлэлцүүлж байна. Гишүүд та бүхнийг энэ асуудлыг судалж, үзэл баримтлалынх нь хувьд хэлэлцэх эсэхийг нь дэмжиж өгөхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдлаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатит Д вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамааруулахаар тусгасны дагуу уг вирусийн халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулах, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль батлагдсанаар гепатит Д вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, санхүүгийн дарамт буурахад эергээр нөлөөлнө гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их

Хурлын гишүүн Батжаргал “Элэг бүтэн Монгол” арга хэмжээнд тусгагдсан Д вирустэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд баталсан төсвийн зарцуулалт болон энэхүү эм нь дэлхийн хэдэн улс орны эмчилгээнд ашиглагдаж байгаа үр дүнгийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна. Дараа нь Мөнхөөгийн Оюунчимэг. Дараа нь санал хураалттай. Гишүүд анхааралтай.

Ц.Сандаг-Очир: Энэ элэгний В, Д вирустэй иргэдэд эмчилгээний энэ **Булевиртид** (Bulevirtide) эмийн гаалийн албан татварыг хөнгөлөх хуулийн заалт орж ирж байгаа юм байна. Яаралтай ингэж орж ирж байгаад бас талархалтай байна. Яагаад гэхээр сая өнгөрсөн 3 хоногийн хугацаанд эмийн түр хороо эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг тогтоох нээлттэй сонсгол хийсэн. Энэ сонсгол дээр энэ хүмүүсээс төлөөлөл орж ирж санал, хүсэлтээ хэлж байсан. Энэ эм нь өөрөө их үнэтэй эм юм байна. 1 сард хэрэглэх эмийнх нь үнэ гэхэд 8, 9 саяар хэмжигдэх. Тэгээд 1 жил, 2 жил тасралтгүй тариулж байж үр дүн нь

гардаг. Ингээд бодохоор 1 хүн жилдээ гэхэд бараг дунджаар 100 гаруй сая төгрөг ОХУ-д очиж эмчлүүлэх ийм хэрэгцээ шаардлага гардаг юм байна. Гаалийн албан татвараас чөлөөлснөөр 1 хүнд ноогдох төсвийн дарамт яаж буурч байна. Зөвхөн гаалийн албан татвараас хөнгөлснөөс гадна Чинзориг сайд бас өөр ямар хөнгөлөлтийн асуудлууд байж болох вэ. Үнийг бууруулах өөр ямар гэрээ хэлцэл, яриа хэлцлүүдийг хийж байгаа вэ гэдэг ямар арга хэмжээ авч байна гэдэг. Тэгэхгүй бол энэ чинь яам бол бб мянга, холбоо нь бол 150 мянга гаруй иргэд бол энэ өвчнөөр өвчилсөн байх. Зарим иргэд нь бол өвчилснөөс ч мэдээгүй байгаа ийм тооцоо судалгаа байдаг юм байна. Тийм учраас энэ бол олон иргэдийн амь нас, эрүүл мэнд, эдийн засагтай холбоотой асуудал байгаа. Тийм учраас өөр цаашидаа эмчилгээний энэ эмийн үнийг бууруулах, тарианы үнийг бууруулах энэ бололцоо боломж яриа хэлцлүүд хийгдэж байна уу. Хэзээнээс хийгдэх вэ.

Цаашидаа Монголдоо оруулж ирэх бололцоо боломж, энд эмчлээд явах энэ ОХУ чинь зөвхөн АНУ, Европын улсуудад л худалдаална гэсэн ийм гэрээ хэлцэлтэй байдаг юм гэсэн. Тэгээд энэ чиглэлээр та хариулт өгөөч ээ.

Г.Занданишатар: Содномын Чинзориг сайд, хууль санаачлагч хариулъя.

С.Чинзориг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ элэгний Д вирусийн эмчилгээ нь асар их одоо өндөр өртөгтэй юм байна лээ. Одоо бидний энэ татвараас чөлөөлөх тухай асуудал ярьж байгаа **Булевиртид** (Bulevirtide) эм бол Европын холбоо бол бүртгэсэн. Европын холбоонд надад байгаа мэдээллээр сарын эмчилгээнийх нь зардал нь 10 мянган евро байна гэсэн ийм мэдээлэл байгаа юм. Би АНУ-ын тэр “GILEAD Sciences” компанитай цахимаар 2 удаа уулзалт хийж ярилцсан. 1 удаа Азийн бүс хариуцсан захиралтай нь Улаанбаатар хотод биечлэн уулзаж ярилцсан. Энэ улсууд бол бид нарт манай

нөхцөл байдлыг ойлгоод, үнийн хэлцэл бол явагдаж байна. Үргэлжилж явагдаж байна. Урьдчилсан байдлаар бол Европын холбооны орнуудад зарагдаж байгаа үнээс 5 дахин бага үнээр танай улс оронд нийлүүлэх ийм боломж байна гэдгээ бол урьдчилсан байдлаар мэдэгдсэн. Одоо бид нар энэ буулгасан үнийг нь дахиад бас 50 орчим хувиар бууруулах ийм боломж байна гэдгээ манайд бол мэдэгдсэн байгаа. Тэгээд би ирэх 7 хоногийн 4 дэх өдөр энэ АНУ-ын “GILEAD Sciences” компанитай дахиж бас Их Хурлаас, Засгийн газраас бас ийм арга хэмжээ авч байна. Тэгээд та бүхэн бас дахиж үнээ бууруулаач гэдэг ийм чиглэлээр дахиж цахимаар уулзалт хийхээр төлөвлөж байгаа. Гэсэн ч гэсэн энэ тодорхой хэмжээгээр 1 мянга орчим доллар дотор орох болов уу гэж би баримжаалж байна. Мянга орчим доллар дотор орж ирлээ ч гэсэн сарын эмчилгээний зардал учраас өндөр байх юм байна. Тэгээд ядаж нөгөө иргэдээ санхүүгийн дарамтаас бас чөлөөлөх үүднээс бас энэ татвараас чөлөөлөх зайлшгүй шаардлагатай байна гэж бол үзэж байгаа. Татвараас чөлөөлөгдсөнөөр НӨАТ, гаалийн албан татвараас чөлөөлбөл нийтдээ нийлээд 30 орчим хувийн татварын хөнгөлөлт эдлэх болов уу гэж бодож байна. ОХУ-тай бид нар ОХУ-ын Эрүүл мэндийн сайдтай уулзсан. ОХУ анх элэгний Д вирус эмчилгээний эмийг гаргаад, тэгээд патент АНУ зарсан юм байна лээ. Надад өгч байгаа мэдээллээр бол бусад улс орнуудад худалдан борлуулахгүй нөхцөлгүйгээр зөвхөн өөрийнхөө улс орнуудад эмчилгээнд хэрэглэнэ гэсэн ийм нөхцөлтэйгөөр худалдсан гэдэг асуудлууд ярьж байгаа.

Хэрвээ ОХУ-аас эмчилгээг авна гэвэл зөвхөн иргэдийн эмчилгээ хийж байгаа тэр Улаан-Үүд хотод очуулж эмчилгээ хийлгэх ийм нэлээн тийм бас явдал ихтэй, чирэгдэл ихтэй, зардал ихтэй ийм нөхцөл байдал үүсэх гээд байгаа юм. Тийм учраас энэ АНУ-ын үйлдвэрийн эмийг нь авах нь зүйтэй байх. Бид нар хавар төрийн болон орон

нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, зарим эмийг шууд үйлдвэрлэгчээс нь авч болох ийм хуулийн зохицуулалт орсон. Тэгээд энэ хуулийн зохицуулалтыг ашиглаад шууд худалдан авалт хийж иргэдийн эмчилгээнд хамруулъя гэсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Энэ гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлчихвөл наад зах нь 30 хувиар бууруулах боломжтой гэж байна. 30 хувь гэдэг ч гэсэн ямар ч байсан бас энэ өндөр өртөгтэй эмийн ачааллаас жсоохон ч гэсэн бууруулах ийм ач холбогдолтой. Энийг бас Нийгмийн бодлогын байнгын хороо дээр бид нар бас ярьж, тогтоолын төсөл бас гаргасан. Тэгээд Чинзориг сайд өөрөө бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байсан хүний хувьд иргэдийнхээ асуудлыг маш шуурхай барьж авч, энэ асуудлыг шийдэх гэж асуудалд бас ингээд нухацтай бас хандаж байгаад би баярлаж байна.

Саяхан энэ асуудал яригдаад л бөөн юм болж байсан. Уржигдар яг энэ В, Д вирусийн өвчлөлтэй хүмүүс сонсголд хүрч ирж байр сууриа илэрхийлсэн. Байдал үнэхээр хүнд байна. Одоо ямар ч санхүүжилт байхгүй. Дээрээс нь нөгөө үнэтэй эмээ авах гэдэг бол хүлээлтийн байдалтай байна. Энэ хэзээ шийдэгдэх бол гэсэн ийм горьдлого тээсэн. Энэ нь өөрөө хавдар болоод амь насанд нь бүр ноцтой болчих вий гэдэг асуудал өөрөө маш тийм эрсдэлтэй зүйл. Тэгэхээр та сая хэлж байна. 1000 орчим доллар болох байх гээд. Уг нь бол 740, 750 доллар болтол нь бууруулахаар яриа хэлцлийг хийж байгаа гээд та хэлж байсан. Тэгэхдээ энэ нь нөгөө хүн ам, хэрэглэгчийн тоо цаашидаа хэр удаан хугацаанд гэрээ хэлэлцээр хийхээс шалтгаалж, АНУ-ын энэ үйлдвэр **Булевиртид”** (Bulevirtide) эмийн тал дээр асуудлыг хөндөж байна гээд хэлж байна лээ. Бид бас 2024 оны улсын төсөв дээр 14 тэрбум төгрөгийг төсөвлөж

өгсөн. Энэ төсөв хөрөнгө бол байгаа. Эхний ээлжид эм орж иртэл энэ санхүүжилт дээрээ тулгуурлаад тодорхой арга хэмжээ авахаар бас ажиллаж байгаа тухай та хэлж байсан. Энэ ажил ямархуу явж байна. Одоо яг өөрийн төсөвлөгдсөн 14 тэрбум төгрөгийн хэмжээнд ямар арга хэмжээ авч энэ нь өөрөө В, Д гепатит вирустэй хүмүүст бас тодорхой хэмжээгээр эм нь тасалчихгүй, эмчилгээгээ үргэлжлүүлээд яваад байх энэ бололцоод хэр хангагдаж ажиллаж байгаа болоо гэсэн нэг асуулт байна.

2 дахь нь. Та бас их чухал мэдээ хүргэсэн шүү дээ. Энэ асуудлуудыг шийдэхэд бид бас зүгээр байхгүй байгаа. ХБНГУ-даа тэр зээл тусламжийн 2 улсын хооронд 2 байгууллагуудын хоорондын зээл тусламжийн хүрээнд энийг бас шийдэх талаар яриа хэлэлцээ өрнүүлж байгаа тухай мэдээ бид нарт хэлсэн. Тэгэхээр энэ асуудлууд яаж байгаа бол. Энэ дээр танаас нэг мэдээлэл авахыг хүсэж байна.

Г.Занданишатар: Содномын Чинзориг сайд, хууль санаачлагч хариулья.

С.Чинзориг: Оюунчимэг гишүүний асуултад хариулья. Өнгөрсөн жил 2023 онд Улсын Их Хурал төсөв батлахдаа “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 13 тэрбум төгрөг баталж өгсөн. Энэ 13 тэрбум төгрөгийг нь бид нар 9 тэрбум төгрөгт нь багтааж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бүртгэлтэй байгаа /Peg-Interferon (P-IFN)/ эмчилгээг хийж эхлүүлбэ гээд худалдан авалт зарласан. 4 тэрбум төгрөгөөр нь орон нутгийн нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжиж, орон нутагтаа Д вирусийн оношилгоо шинжилгээ хийх чадавх бэхжүүлэх, нөгөө талаасаа ХӨСҮТ дээр оношилгоо шинжилгээ хийх, ялангуяа Д вирусийг тоолдог тоног төхөөрөмж манайд бол байхгүй юм байна лээ. Тийм учраас 2 орчим тэрбум төгрөгөөр нь ХӨСҮТ дээр Д вирусийн оношилгоо шинжилгээ хийх,

вирусийг тоолдог ийм орчин үеийн тоног төхөөрөмж бол авч өгсөн. Ингээд энэ өнгөрсөн 7 хоногт би очиж танилцсан. Тохируулга нь Германы мэргэжилтнүүд ирээд тохируулгыг нь хийгээд хүлээлгэж өгч байгаа. Ийм явцтай байна. Энэ жилийн төсөв дээр 7 тэрбум төгрөг баталж өгсөн. Ингээд энэ 2 жилийн нийтдээ 7, 7 гээд 14 орчим тэрбум төгрөгт нь бид нар энэ **“Булевиртид”** (Bulevirtide) эмийг худалдан аваад дэмжлэгийг эхлүүлж болох юм болов уу гэсэн ийм бодолтой бол байна. Ний нуугүй гишүүдэд хэлэхэд Америкийн талтай үнийн хэлцэл явагдаж байгаа учраас би бол яг тэд болчихно гэж хэлж чадахгүй. Ямар ч байсан урьдчилсан байдлаар 1 мянган доллар дотор орчих ийм бас боломж байгаа гэдгийг хэлбэ. Цаашидаа ч гэсэн бас бууруулах ийм нөхцөл бас бид нар тавьж бас ярьж байгаа. Тэр Германтай холбоотой асуудал бол ХБНГУ-аас Монгол Улсын зээлсэн Засгийн газрын зээл 29 сая еврогийн зээл байгаа юм байна лээ. Герман Улсын Засгийн газар энэ Монгол Улсын зээлсэн энэ 29 сая еврогийн зээлийг тэглэж өгөх ийм санал бол гаргаж байгаа. Харин энэ зээлээ тэглээд Герман улс өөрөө “Глобал” сангийн гол санхүүжүүлэгч орон. Тийм учраас Монголын зээлийг тэглээд тэр хэмжээгээр нь “Глобал” санд Герман Улсаас Засгийн газраас оруулах санхүүжилтийн хэмжээгээ нэмэгдүүлбэ гэж ярьж байгаа. Энэ хөрөнгөөр нь бид нар энэ “Глобал” сантай хамтран хэрэгжүүлж байгаа Дох, БЗХӨ, сүрьеэтэй тэмцэх чиглэлээр зарцуулдаг хөрөнгөдөө энэ хөрөнгийг нь зарцуулья. Харин энэ үйлчилгээ дээр нэмээд гепатитын эмчилгээ вакцинжуулалтыг оруулья гэдэг асуудлыг ярьж байгаа. “Глобал” санд би ийм саналаа бас урьдчилсан байдлаар хүргүүлсэн. 2 өдрийн өмнө надад захидал “Глобал” сангаас ирсэн. Ямар ч байсан “Глобал” сангаас өгч байгаа санхүүжилтээр гепатитын вакцинжуулалт эмчилгээнд бас зарцуулах хүрээг нь өргөжүүлэх ийм боломжтой гэсэн урьдчилсан байдлаар манайд санал бол ирүүлсэн. Тэгээд энэ 2

орны Засгийн газрын хоорондын зээл тэглэх хэлэлцээр явагдаад, одоо 5 сарын эхээр Германы Засгийн газрын төлөөлөл ирнэ. Ингээд энэ зээлийг тэглэх асуудал шийдэгдчих юм бол тэр “Глобал” сан дээр хөрөнгө нь нэмэгдээд ингээд энэ гепатитын эмчилгээ зарцуулах.../минут дуусав/

Г.Занданишатар: Оюунчимэг гишүүн тодруулж асууя. 1 минут.

М.Оюунчимэг: Энэ бол одоо яг өнөөдрийн сая Чинзориг сайдын мэдээллийг сонсоод яг энэ өвчнөөр өвчилж, зовж байгаа хүмүүсийн хувьд яаралтай энэ шийдэгдээсэй гэж хүсэж байгаа. Тэгэхээр 29 сая еврог тэглэх асуудлыг Улсын Их Хурлын түвшинд шийдэгдэх үү, Засгийн газрын түвшинд байх уу. Энэ дээр Чинзориг сайд бас бидэнд хэлээд, бид энэ дээр бол нэн шуурхай ажиллаж, дэмжиж ажиллахад бэлэн байна. Тэгээд манай Их Хурлын гишүүд маань ч мэдэж байгаа. Энэ 150 мянга гэж яриад байгаа шүү үнэнийг хэлэхэд ийм хүмүүс маань цаашидаа хавдраар өвчлөөд явчихвал юу болох вэ. Тэгэхээр бүгдээрээ энэ гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлөх асуудлыг бол шуурхай шийдээд, цаашидаа саяын яриад байгаа 2 улсын хоорондын холбооны бүгд найрамдах Герман Улсын тэр “Глобал” сантай холбоотой болон тэр 29 сая еврог тэглэх энэ дээр нь ч гэсэн шуурхай дэмжлэг үзүүлээд ажиллачих хэрэгтэй байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Үг хэллээ. Одоо санал хураалт явуулна.

Ер нь Чинзориг сайд, бид санаачлаад мөрийн хөтөлбөрт оруулаад “Элэг бүтэн Монгол” гэж үндэсний хөтөлбөрийг зарлаад, үүний үр дүнд бол элэгний өвчлөлтэй тэмцэх, тэр дотроо Б, С вирус маш их амжилтад хүрсэн. С вирус дээр гол амжилтад хүрсэн. Энэтэйгээ уялдуулаад энэ Д вирус тэй болон элэгний хорт хавдартай тэмцэх энэ ажлыг бол уялдуулж хэрэгжүүлбэл

байна шүү дээ Эрүүл мэндийн даатгалын сангаасаа санхүүжүүлчихдэг байхгүй юу. Энэ чинь нийтийн халдварт өвчин шүү дээ. Нийгмийн өвчинд тооцогдоно.

Ингээд санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

17.23 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна. Индэрт урьж байна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан хэлэлцүүлж байна. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл нь өмнөх хуультай адилхан элэгний Д вирусийг эмчилгээнд хэрэглэх, эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулах ийм хуулийн төсөл байгаа юм. Тийм учраас та бүхнийг өмнөх хуулийг дэмжсэнтэйгээ адилхан энэ хуулийн төслийг дэмжиж, үзэл баримтлалыг нь

хэлэлцэх эсэхийг нь дэмжихийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Энэ Чинзориг гишүүн яагаад ингээд ийм товчхон танилцуулчав. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатит Д вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамааруулахаар тусгагдсаны дагуу уг вирусийн халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулах, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль батлагдсанаар гепатит Д вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, санхүүгийн дарамт буурахад эергээр нөлөөлнө гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлсэнгүй ээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхонд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийг ямар ч байсан танилцуулчихъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Аюурзанын Өнөржаргал Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга.

Ингээд санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Ингээд санал хураалт явуулна.

Хэлэлцэхийн өмнө Чинзориг гишүүн болон Эрүүл мэндийн яамныхнаас 1 ам авна. Ингээд “Элэг бүтэн Монгол” гээд их сайн хөтөлбөр хэрэгжиж байсан. Тэгээд 1 сайд нь гарч ирэхээрээ өмнөх юмнуудыг үүсгэчихдэг, байхгүй болгочихдог. Тэр бас олон Монголчуудыг элэгний өвчлөл С вирусээс ангижруулсан. Тэгээд бас Д вирус энэ тэр гээд үргэлжлэх ёстой байсан. Тэгээд Монгол хүний өвчлөлийн нас баралтын нэг үндсэн шалтгаан бол хорт хавдар. Тэр дотроо элэгний хорт хавдар, ходоодны хорт хавдар давамгайлдаг. Тэгээд энийг бас үргэлжлүүлж хэрэгжүүлмээр байгаа юм. Энэ бол яг нөгөө зөвхөн татварынх нь асуудал.

Байнгын хорооны саналаар, Нэмэгдсэн өртгийн албан татвараас

чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Чинзориг сайд тэгээд өөрийнхөө хуулийг батлуулчихаад гараад явчхаж болохгүй шүү дээ.

17.30 цаг.

Дараагийн хуульд оръё.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын бэлэн хувцасны зах зээл дунджаар 1,2 их наяд төгрөг эргэлддэг боловч дотооддоо зөвхөн 8 орчим хувийг үл үйлдвэрлэж байна. Оёдлын салбар нь 2007 оныг хүртэл ДНБ-ий 30 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг, 30 мянга гаруй ажилтантай байсан бол өнөөдөр 10 хүрэхгүй хувь хүртэл буурч 3000 гаруй ажиллагсад хүртэл буурсан байна. Хөнгөн үйлдвэрлэлийн салбар тэр дундаа оёдлын салбарыг дэмжих бодлогын хүрээнд 2005 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг баталж, мөн хуулиар оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортлож байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах

материалыг гаалийн албан татвараас чөлөөлж, салбарын аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжиж байсан туршилагатай.

Уг хуулийг 2016 онд хүчингүй болгосноор салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд татвар, санхүүгийн дарамт нэмэгдсэн төдийгүй үүнийг дагасан бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байрны тоо, зах зээлд эзлэх хувь хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Эдгээр болон олон шалтгаануудын улмаас Монгол Улсад үйлдвэрлэсэн бэлэн хувцас, оёмол бүтээгдэхүүний үнэ өндөр, экспортын хэмжээ нэмэгдэхгүй, дотоодын үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчид эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох, цалингийн сан хумигдах, ажлын байрны тоо буурах, бүтээгдэхүүний нэр төрөл цөөрөх аж ахуйн нэгжүүд ашиггүй ажиллах, зах зээлийн хэмжээ нэмэгдэхгүй байх зэрэг нөхцөл байдал тулгамдаж байна.

Оёдлын хууль санаачлагчдын зүгээс хүлээж байгаа бас нэгэн чухал үр дүн бол ажлын байрыг эрс нэмэгдүүлэн ядуурлын бууруулах хөшүүрэг болно гэж үзэж байна. Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт гэсэн 38 дугаар зүйлд дараах заалтыг нэмж, оёмол бүтээгдэхүүний түүхий эд, үндсэн болон туслах материалыг дотоодод үйлдвэрлэдгээс бусад гаалийн албан татвараас чөлөөлөх гэж заасан байна.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсад хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн төлөө, Монгол Улсад ядуурлын бууруулахын төлөө уг хуулийн төслийг дэмжинэ гэдэгт итгэж байна.

Г.Занданишатар: Төслийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 10 гишүүн 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч оёдлын салбарын аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн татварын дарамт, санхүүгийн хүндрэлийг бууруулах, бизнесийн орлогыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, ажлын байрыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг сайжруулах, иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг болно гэж үзэж, уг хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн оёдол бүтээгдэхүүний түүхий эдийн материалыг гаалийн татвараас чөлөөлөх нь үйлдвэрлэгчдийн татварын ачааллыг бууруулахгүй, харин импортоор түүхий эдийг нийлүүлж байгаа нь дундын зуучлагч нарт илүү ашигтай байдлыг бий болгох эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, цаашид үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судлах, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа түүхий

эд, үндсэн болон туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн бизнес эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийг үнийн өрсөлдөөнөөс хамгаалах тул хуулийн төслийг дэмжиж байна. Цаашид дотоодоос хангаж болох зарим бүтээгдэхүүнд төрийн худалдан авалт хийж, хөнгөн үйлдвэрүүдийг дэмжих нь зүйтэй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлснээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ өсөх, цаашидаа иргэдийнхээ өдөр тутмын хэрэглээг дотооддоо хангах нөхцөлийг бүрдүүлж, дотоодын үйлдвэрүүдээ зөв бодлогоор дэмжих нь зүйтэй тул хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Харин хэлэлцүүлгийн шатад зарим нэг бодлогын өөрчлөлтүүдийг тусгах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Ерөнхий агуулгаар нь дэмжиж байгаа. Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бас Монголд өөрсдөө үйлдвэрлэдэг гаднаас бэлэн

бүтээгдэхүүн худалдаж авч валютаа урсгадаггүй байх, ажлын байр бий болгох, бас төсвийн орлого нэмэгдэх, татвар төлөгч, баялаг бүтээгчид бий болгох гэдэг агуулгаар дэмжиж байгаа. Гэхдээ энд нэг жоохон ялгавар байж болох уу. Бид нар чинь дотооддоо бас ноосоороо даавуу, ноолуураар бас даавуу хийдэг болчихлоо. Ялангуяа ноосоор хийж байгаа даавуунуудтай ижил төрлийн бүтээгдэхүүн гаднаас орж ирэх юм бол түүнд нь татвартай, ноолууран бүтээгдэхүүн, ноолуураар хийсэн даавуу орж ирэх юм бол түүнд нь татвартай байх гэдэг юм уу иймэрхүү байдлаар дотооддоо үйлдвэрлэж чадаж байгаа үйлдвэрүүдийн ижил төстэй бүтээгдэхүүнүүдийг хязгаарлалттай. Дотооддоо үйлдвэрлэж чаддаггүй ийм бүтээгдэхүүн, түүхий эд, даавуун бүтээгдэхүүн, түүхий эдийг оруулж ирэх юм татваргүй туслах материалуудыг ийм бас ялгавартай байж болох уу. Энийг I дүгээрт нь хариулж өгөөч.

Тоног төхөөрөмжийн хувьд ойлгомжтой. Тоног төхөөрөмж бол гарцаа байхгүй бид нар Монголдоо үйлдвэрлэж чадахгүй байгаа учраас энэ ерөөсөө л үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж орж ирж байвал дэмжиж л баймаар байгаа юм. Дэмжиж байх ёстой. Тэгэхгүй ерөөсөө тэгээд л бүх юман дээр л татвар авна гээд л, ерөөсөө л татвар гэдэг юмыг л авах ёстой гэдэг тийм нэг улайрсан, улангассан нүдтэй баймааргүй байгаа юм. Таны одоо яг энийг өөрчлөх гэж байгаа бас дэмжиж байгаа юм.

Тэгэхгүй бид нар татвар авахгүй байж байгаад аль болох одоо юу гэдэг юм төсөв бүрдүүлэгч нар, татвар төлөгч нар, баялаг бүтээгч нар, үйлдвэрлэгч нараа бүх боломжоор нь дэмжээд олон үйлдвэрүүдтэй болчихоод ингэх юм бол олон ажлын байр бий болно. Ингэх юм бол нэмүү өртөг бий болно. Ингэх юм бол дотооддоо бас түүхий эдээ экспортод гаргадгаа болино. Малын гаралтай түүхий эд маань үнэ цэнтэй болно. Энэ бодлогыг бас дэмжсэн, энэ рүү чиглэсэн л юм хэрэгтэй байгаа юм л

даа. Гэтэл ерөөсөө л татвар авна гэхээр ерөөсөө л нөгөө үйлдвэрлэгч нь ч босож чаддаггүй, нөгөө малын гаралтай түүхий эд нь ч хямдхан хог болон хаягдаж байдаг. Иргэд нь ч ажилгүй, орлогогүй, халамж тусламж хүсээд байж байдаг. Ийм л болчихоод байгаа юм тэр. Тэгэхээр одоо ерөөсөө гол юм бол үйлдвэрлэгч нараа яаж дэмжих вэ. Ялангуяа одоо Монголдоо энэ түүхий эд нь байж байна. Ноос нь байж байна, ноолуур нь байж байна, арьс шир нь байж байна. Үүнийгээ одоо аль болох хагас боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг дэмжмээр байна. Ингэхийн тулд тоног төхөөрөмж болон бусад юм бол гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлмөөр байна. Ингээд үйлдвэрүүд бий болчих юм бол аяндаа нэмүү өртөг бий болно. Нэмүү өртөг бий болох юм бол татварын бааз суурь нэмэгдэнэ. Олон ажлын байр бий болно. Олон асуудлууд шийдэгдэнэ. Энэ өнцгөөс л бас манай Сангийн яам, мөн татвар хураагч нар маань бас анхаармаар байгаа юм л даа. Тэгэхгүй ерөөсөө л татвар авах ёстой гэдгийг бас I дүгээрт нь биш, эхлээд эдийн засгийн бааз суурийг томруулъя, үйлдвэрлэлээ дэмжье, үүний дараа аяндаа татварын бааз суурь томроод, эдийн засаг маань томорчихоор тэрийг дагаад татвар маань төлөлт нь нэмэгдэнэ гэдгийг л бас нэлээн сайн бодож бид ярих ёстой байх. Энэ тал дээр та бас ямар байр суурьтай байна вэ.

Г.Занданшатар: Хууль санаачлагч Салдангийн Одонтуяа гишүүн хариулна.

С.Одонтуяа: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хуулийн төслийг манай Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хороо гол санаачлаад, 2 жилийн хугацаанд бүх судалгаа тооцоог гаргасан байгаа. Тэгэхээр таны тэр болгоомжилж байгаа дотоодод үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүд бол эндээс бол чөлөөлөгдөхгүй, ялангуяа ноос, ноолуур, малын гаралтай бүтээгдэхүүнүүд, түүхий эд бол

чөлөөлөгдөхгүй. Зөвхөн одоо Монголд үйлдвэрлэдэггүй оёмол бүтээгдэхүүний зориулалтаар, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа түүхий эд үндсэн болон туслах материал. Тэгээд бүр хаалт дотор дотоодод үйлдвэрлэдэггүй гээд орчихсон байгаа. Тэгэхээр энэ дээр бол таны санаа зовж байгаа асуудал бол огт хамаарахгүй ээ. Ер нь бол зүгээр бид нар энэ 2005 онд бол ДНБ-ийхээ 30 хувийг дангаараа энэ оёдлын үйлдвэрүүд хангаж байсан юм билээ. Үйлдвэрлэж байсан. Тэгэхээр одоо бол бүр ингэж ухарна ухарна гэхэд арай ийм бас ухарчихсан байж болохгүй байгаа учраас энэ хуулийг манай 10 гишүүн санаачилсан байгаа.

Нөгөөтээгүүр энэ хууль бас ядуурлыг бууруулахад их чухал үүрэгтэй болчихоод байгаа юм. Ядуурлыг бууруулахад. Яагаад гэхээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүс дийлэнх нь оёдлын салбар. Одоо урд хөршөөс бол хямдхан бүтээгдэхүүн орж ирдэг байсан үе бас өнгөрөөд байна. Одоо урд хөршид эрчим хүч, цалин өссөн учраас бүтээгдэхүүнүүд үнэтэй болж ирж байгаа учраас энэ бол манайд нөгөө талаараа бас тааламжтай. Дотооддоо өөрсдөө юмаа оёё, үйлдвэрлэе, ажилтай орлоготой байя гэсэн энэ гол бас зорилготой байгаа. Тэгээд ер нь манай энэ оёдлын салбар бол бас ингээд нөгөө татвараар дэмжихгүй байгаад байхаар бүр улам доошоо ороод, одоо бүр материалаа ганзагынхнаас авдаг хүртэл хэмжээнд оччихоод байгаа байхгүй юу. Энэ чинь том том үйлдвэрүүд татвараас нь чөлөөлчих юм бол өөрсдөө иүүд бүтээгдэхүүнээ оруулж ирнэ, ажиллагсдын тоо нэмэгдэнэ гээд олон чухал ач холбогдолтой байгаа. Тэгээд энийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай бол нэлээд ярилцсан. Маши олон үйлдвэрүүдтэй уулзсан. Ер нь оёдлын үйлдвэрүүд гол тавьж байгаа хүсэлт нь л ерөөсөө энэ байгаа юм. Гаалийн татвараас хөнгөлж, чөлөөлж өгөөч ээ гээд. Тэгэхээр энд бол цахилгаан, оёдлын бүтээгдэхүүнд хэрэглэдэг товч гээд бүгд татвараас чөлөөлөгдөхөөр

бүтээгдэхүүний үнэ буурна. Экспортод гаргахад бас чухал ач холбогдолтой болно.

Тийм учраас хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн тохиолдолд бид нар ажлын хэсэг дээр таны ярьсан асуудлуудыг бас нарийвчлаад бүр нэг бүрчлэн нарийвчлаад тусгах боломжтой байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Энэ сөрөг хүчин байхдаа ингэж байгаа юм чинь юу явал балрах юм байна. Санал хураалт. Ингээд төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Сая санал хураалт 69,2 хувийн саналаар санал дэмжигдсэн.

17.42 цаг.

Дараагийн асуудалд орёё.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа

хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 2 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ганболд ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг, Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж дараах санал, дүгнэлтийг та бүхэндээ танилцуулж байна.

Ажлын хэсгийн дэмжсэн тогтоолын төслийн 2 дахь заалт буюу дагаж мөрдөх хугацааг хасаж, тогтоол ердийн журмаар хүчин төгөлдөр болох, нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичигт тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нөхцөл байдлыг тусгасан байхаар тодруулах, нэгжийн өөрчлөлт хийснээр иргэдэд зориулсан төрийн болон орон нутгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх түвшинээс дээшилсэн байх, төслийг боловсруулах ажлын хэсэг тухайн нэгжийн төлөөлөл болон өөрчлөлтөд хамрагдах нэгжийн Засаг даргын Тамгын газрын төлөөллийг оролцуулах. Сум, дүүргийн хувьд 3 сар, аймгийн хувьд 6 сарын хугацаанд багтаан иргэдэд мэдээлэх, танилцуулах, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн шинжилгээ хийх, иргэдээс санал авах дүнг нэгтгэн мэдээлэх ажлыг зохион байгуулах, аймгийг өөрчлөх

асуудлаар санал хураалт явуулах өдөр цагийг Засгийн газар, сум, дүүргийг өөрчлөх асуудлаар санал хураалт явуулах өдөр цагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал товлон зарлах, саналыг нууцаар авах, өөрчлөлтөд 1 эсвэл 2 ба түүнээс олон нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонхонд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх нь дэмжсэн саналыг хүчинтэйд тооцох зэрэг 22 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Байнгын хороо нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Юуны өмнө ажлын хэсгийг танилцуулчихъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Ургамлын Бямбасүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутаг хариуцсан газрын референт Пүүжийн

Энхсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Ганбатын Дөлгөөн.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Манай МоАХ-ноос газар нутгаа тоолъё гэдэг аяныг өрнүүлээд бас энэ орон нутагт ялангуяа ашигт малтмалын лицензийг хэрхэн олгосон талаар бас тодорхой ажлуудыг хийж байгаа. Энэ ажил хийх гол үндсэн шалтгаан бол 2020 оны 12 сарын 6-ны өдөр батлагдаж, 2021 оноос хэрэгжсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон түүнийг дагалдаж орж ирсэн Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуулиас болж энэ газар нутгаа тоолох аян өрнөөд байгаа юм. Энэ хуулиар яасан бэ гэхээр урьд нь жишээ нь Дорноговь аймгийн Мандах сумын аль нэг баг дээр газрын лиценз авлаа гэхэд урд талын хуулиар нь тухайн багийн ард иргэд нь олонх нь оролцоод тэрний олонх нь дэмжсэн тохиолдолд тэр газар дээр лиценз олгох асуудлыг шийдвэрлэдэг байсан. Хэрвээ тэр иргэд нь зөвшөөрөхгүй бол дахиад бичгээ аваад, дахиад нөгөө компани очоод учир байдлаа тайлбарлаад зөвшөөрүүлж байсан, аль эсвэл татгалзуулж байсан ийм тохиолдлууд байдаг байсан. Гэтэл энэ 2020 оны 12 сарын 6-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтөөр энэ одоо иргэдийн эрхийг бүгдийг нь авч хаясан. Дээрээс нь багийн иргэдийн хурал, багийн иргэдийн эрхүүдийг бүгдийг нь байхгүй болгосон. Сумын иргэдийн хурал, сумын Засаг дарга нарын эрхийг бүгдийг нь авч хаясан.

Өөрөөр хэлбэл энэ албан тушаалтнууд бүгдээрээ тодорхой хэмжээгээр өөрийнхөө нутаг дэвсгэр дээр явж байгаа тэр газрын ашигт малтмалын уул уурхайтай холбоотой тэр арга хэмжээг зогсоох хүртэл арга хэмжээг авдаг байсан бол энэ эрхийг нь бүгдийг нь байхгүй болгож, зөвхөн сум

дээр ганцхан эрх мэдэлтэй, үүрэгтэй хүн үлдээсэн. Тэр нь юу юу вэ гэхээр сумын Засаг дарга тухайн уул уурхайн лицензтэй газрын Байгаль орчны нөлөөллийн менежментийн төлөвлөгөөг баталж өгөх үүрэгтэй л болсон байгаа юм. Тийм учраас энэ асуудал иргэдээсээ холдож байхгүй болсон. Одоо яадаг болсон бэ гэхээр Мандах сум дээр нэг аятайхан газар байна. Энийг авмаар байна гэхэд л тэр иргэдээс асуух шаардлагагүй. Ашигт малтмалын ерөнхий газрын I албан тушаалтнаас асуугаад, энэ газар авмаар байна гэхээр би доор нь зохицуулна шүү дээ. Тухайн Мандах сум руу I албан бичиг явуулчихдаг юм. Тэд нар тэртээ тэргүй үгүй гэдэг юм. Тэгэхээр нь би энд гарын үсэг зураад л өгчихдөг байхгүй юу. Юмаа надаа өгчих гээд. Ийм байдлаар газар олголтын асуудал, Ашигт малтмалын газар олголтын асуудал хэрээс хэтэрсэн учраас сүүлийн үед бол энэ ашигт малтмалын лицензтэй холбоотой иргэдийн уур бухимдал дээд цэгтээ хүрээд байгаа байхгүй юу даа. Тийм учраас энэ иргэдийн бухимдлыг хүргээд байгаа асуудлыг тэр ашигт малтмалтай холбоотой асуудал хэтэрхий үнээр цохиж нэг улсын харьяалалтай хүмүүс олноороо авч байгаа энэ үйлдлийг бас тодорхой хэмжээгээр хязгаарлах ийм шаардлага тэртээ тэргүй гарна. Тэгэхээр энэ асуудалтай холбоотойгоор тэр ялангуяа нэгжийн тухай хуулийг хэлэлцэхэд тэр иргэдийн эрхийг нэмэгдүүлэх талаар, иргэдийн тэр өөрийнхөө олон мянган жилийн туршид өвлөж авчирсан тэр өвөг дээдсийнх нь өвөлжөө, хаваржаа, намаржааны тэр зуслангийн газруудыг хэн нэг нь мөнгөө төлсөн иргэд ирээд эзэмшдэг энэ нөхцөл байдлыг буцааж зохицуулж өгөхгүй бол энэ чинь цаашидаа бол ер нь бол тэгээд ийм газрын төлөөх асар том асуудал бий болно шүү. Тийм учраас энэ хууль дээр бас тодорхой хэмжээгээр авч.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ерөнхийдөө санал хэлчихлээ. Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар

иргэдээс санал авах л журам шүү дээ. Хуулийн төсөл нь бол өмнө нь хэлэлцэгдээд батлагдсан байж байгаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт асуултаа асууна. Дараа нь санал хураалт явагдана. Гишүүд байр эзэлье.

С.Бямбацогт: Энэ маш чухал асуудал орж ирж байгаа юм. Олон жил иргэдийн ялангуяа хөдөөд 2 сумын иргэд газар нутгаа, бэлчээрээ, сумынхаа хилийн цэсээ булаацалдаж маргалдаж ирсэн асуудлыг цэгцлэх маш чухал асуудал. Ерөөсөө шийдэх гээд шийдэж чадахгүй сүүлийн 30 жил явчихсан. Энэ асуудлыг шийдэх гээд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршил, харгалзан тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газар өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан байгаа. Тэр тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн гэхээр урьд нь яадаг байсан гэхээр 2 сумын иргэдийн Хурал хуралдаад 1 нь хилийн цэс өөрчлөхийг дэмжиж байна. Нөгөөдөх нь дэмжихгүй гэгчидэг. Тэгэнгүүт мухардчихдаг. 2 аймгийн иргэдийн хурал хуралдаад, түүнийг нь дээшээ уламжлахдаа 1 нь дэмжиж байна гээд, нөгөөдөх нь дэмжихгүй гээд аймгийн иргэдийн Хурлууд нь уламжлахаар гагцхихдаг. Ийм л байсан л даа. Ингээд үндсэндээ бол 1 аймаг дотор 2 сум ч хилийн цэсээ шийдэж чаддаггүй, нутаг дэвсгэрийнхээ маргааныг шийдэж чаддаггүй. 2 аймгийн хил залгаа 2 сум тухайлах юм бол манай Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Толбо сум. Мөнхийн хилийн цэсийн хэрүүлтэй. Бэлчээрээ булаацалдаж, маргалддаг. Энийг шийдье гэхээр Эрдэнэбүрэн сумынхан хилийн цэсээ өөрчилье гэдэг. Толбо сумынхан өөрчлөхгүй гэдэг. Ингээд л үүнээс бол олон жил гагцсан. Яг үүнийг шийдэх асуудал орж ирж байна гэж ойлгож байгаа. Энэ миний бас ойлголт зөв байна уу, буруу байна уу. Энэ дээр хариулаад

өгөөч ээ. Үүнийг шийдэхдээ бол үндсэндээ тэр 2 аймгийн иргэд, 2 сумын иргэд, Толбо сумын иргэд санал хургаад, хамтарч тийм үү, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын иргэд нийлээд хамтдаа саналаа хураагаад, тэгээд энэ асуудлыг хилийн цэсийг өөрчлөх үү, өөрчлөхгүй юу гэдгийг олонхын саналаар шийдэх юм байна гэж би ойлгож байна. Энэ ойлгож байгаа ойлголт зөв үү. Ийм байдлаар шийдэгдэх үү. Ингэж бас маргааныг нэг тийш нь болгож таслахгүй бол үндсэндээ бэлчээрээ булаалцалддаг, нутаг дэвсгэрээ булаацалдаг асуудал шийдэгдэхгүй байна.

2 дугаарт нь аймаг, сум, сумдыг бас нэгтгэх асуудал байгаа. Аймагтайгаа ойрхон 10-хан километр, 5-хан километр, 20-хон километр аймгууд байдаг сумууд. Хүүхэд нь сумд нь Завхан аймагт байж байна. 100-хан хүүхэд сургуульд явдаг. 100 хүүхэдтэй. 1 анги нь 6, 7 хүүхэдтэй. Ийм сумууд байх уу, байхгүй юу. Энэ жижиг сумуудыг бас нэгтгээд арай жосохон том сум болгох энэ асуудлыг бас иргэд нь хамгийн гол нь иргэдийн саналаар. Иргэд нь бид нар ийм байж байж байхаар нэгдье гэх юм бол саналаа өгөөд, олонх нь дэмжиж байвал нэгдчихдэг. Үгүй ээ, бид нар бие даасан тусдаа сум байж байя гэж байвал нэгдэхгүй байх ийм байдлаар шийдэхээр болж байгаа юу. Гэтэл хүчээр юу гэдэг юм аймгийн ойрхон сум гээд 1 сумыг нэгтгэе гэж санал хураадаг. Аймгийн төвийнхөн бас аймгийн төвийн сум бол олон хүн амтай шүү дээ. Одоо жишээ нь Говь-Алтай аймгийн Алтай сум гэх юм уу, Алтай чинь одоо Есөнбулаг сум. Есөнбулаг сум, Тайшир сумтай нэгдье гэхэд Есөнбулагийнхан окэй нэгдье гэгчидэг. Тайширынх нь цөөхөн хүн амтай учраас нэгдэхгүй гээд 1000 хашираад ч нэмэргүй болчихдог. Иймэрхүү байдлуудыг хэрхэн яаж шийдэхээр энэ журамд тусгаж байгаа вэ. Гэхдээ энэ асуудал бол гарцаа байхгүй иргэдийн, ялангуяа хөдөө, сумд амьдарч байгаа иргэдийн, малчдын маш том хүсэн хүлээж байгаа, шийдвэрлэх ёстой тулгамдсан асуудал болоод байгаа. Энэ

асуудлыг шийдэх гэж одоо орж ирж байгаа нь зөв.

Л.Мөнхбаатар: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд хариулъя.

Н.Энхболд: Би товч хариулъя. Энэ дээр ажилласан ажлын хэсгийг манай Ганболд гишүүн ахалсан. Тэгээд өнөөдөр томилолттой учраас би оронд нь хариулчихъя. Байнгын хороо дээр. Бямбацогт гишүүний ярьж байгаа яг зөв байна. Яг таны ойлгож байгаагаар энэ байгаа. Би гуравхан зүйлийг хэлчихье.

1 дүгээрт энэ Засгийн газраас орж ирсэн санал. Энийг бид нар хэлэлцээд, зарим асуудлуудыг нь ихэнх нь ерөнхийдөө жоохон жоохон засвартай. Тэгээд тэрийг яагаад хэлж байна гэхээр одоо ингээд санал хураах явцад нэг их асуугаад бариад байх шаардлага бараг байхгүй.

2 дугаарт Бямбацогт гишүүний хэлсэн яг орон нутгийн иргэдийн саналаар шийдэж байхаар болж байгаа гэдэг нь зөв. Таны асуусан ойлголт зөв байгаа юм байна.

3 дугаарт жишээ нь 2, 3 газар нийлээд яахад тэр нийт санал хураалтад оролцож байгаа нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа иргэдийн олонх нь ороод тэрнийхээ олонхын саналаар шийдээд л явчхаж гэж байгаа юм. Яг таны ойлгож байгаагаар. Тэгээд тэр тухай заалтууд нь энэ журмын 5.5 дээр, 5.6 дээр, 5.7 дээр байж байгаа. Яг таны сая ярьж хэлж ойлгож байгаа зүйлүүд зөв байна гэж хэлье.

Л.Мөнхбаатар: Одоо санал хураалт явагдана. Гишүүд суудлаа эзэлье. Гишүүд суудлаа эзлээрэй. 22 санал хураалт явагдана. Харин илүү зарчмын шинжтэй хэд хэдэн асуудлууд байгаа. Найруулгын тодорхой саналууд байж байгаа юм. Гишүүд суудлаа эзэлье. Байнгын хороо дээр байгаа гишүүдийг

бас чуулган танхим руу оруулъя. Хурал зохион байгуулах хэлтсийнхэн зохион байгуулаарай. Гишүүдийг орж ирж байх хооронд нэг зүйлийг бас тодруулаад хэлчихье гэж бодож байна.

Энэ сая манай гишүүд бас асуулаа. Их чухал журам байгаа юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх талаар иргэдийн оролцоог хэрхэн хангах вэ гэсэн энэ асуудлаар тодорхой журам гаргахаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд бол заасан. Энэ журам нь бол гараагүй байж байгаад одоо өнөөдөр ийнхүү журам гарах гэж байна. Энэ бол тодорхой засаг захиргааны нэгжүүд, түүний дотор тосгоныг сум болгох асуудлууд бас энэ асуудлаар шийдэгдэх юм. Тухайлбал Хөвсгөл аймгийн Хатгал тосгон гэхэд Алаг-Эрдэнэ сумын 1 баг байж байдаг. Алаг-Эрдэнэ сум нийтдээ 6993 хүн амтай байгаа. Ингээд 5 баг нь нийлээд 3349 хүн амтай байхад Хатгал тосгон бол дангаараа 3644 ийм хүн амтай байгаа юм. Ийм учраас энэ өөрөө сум болох ийм хүсэлтэй иргэдэд маань Хатгал тосгоны иргэд тавьдаг. Үүнийг шийдвэрлэх энэ механизм нь бас энэ өмнөх хууль, эрх зүйн орчноор хязгаарлагдмал байгаад байсан юм. Яагаад гэвэл сумын иргэдийн хурал нь энэ асуудлыг шийдвэрлэхээр ингээд заачихдаг. Гэтэл сумын иргэдийн Хурал Алаг-Эрдэнэ сумын иргэдийн хурал бол 27 гишүүнтэй, тэрний 3 нь л Хатгалаас байгаа. Тэгэхээр энэ 3 хүний санал бол саналаар хэзээ ч шийдэгдэхгүй байгаад байдаг. Ийм зүйлүүд байгаад байсан учраас энийг журамлаж байгаа ийм зохицуулалт байгаад байгаа юм. Ийм учраас Засгийн газар үүнийг санаачилна. Үүний дотор журмын 5.4, 5.5, 5.6-д иргэдийн оролцоог хэрхэн хангаж, иргэд өөрсдийнхөө санал өгснөөр энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудал энэ журмаар бас шийдэгдэж байгаа юм. Их чухал журам байгаа юм. Энэ чиглэлээр бас манай Хатгал тосгоны иргэн Дүйжий гуай бичгээр санал ирүүлсэн. Чулуунбаатар гуай. Ням-Очир гуай гээд их олон хүмүүс бас энэ дээр саналаа

ирүүлсэн байгаа юм. Эдгээр саналуудыг нь бас Төрийн байгуулалтын байнгын хороонд уламжилж өгсөн. Нямаагийн Энхболд дарга энэ саналууд бүгд туссан тийм ээ. Туссан байгаа. Энэ саналуудыг бол нэгтгэсэн байна. Ингээд гишүүд байраа эзлээрэй. Энэ чухал журам одоо батлагдах гэж байна. Гишүүд суучихъя. Энэ саналаа хураачихъя. Гишүүд орж ирж байна шүү дээ. Саранчимэг гишүүн ороод ирлээ. Наранбаатар гишүүн суудлаа эзэлье.

Одоо Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан их чухал журам байгаа шүү. Энд бол одоо их олон тосгодын асуудал байдаг шүү дээ. Аймаг болгонд л одоо нэг тодорхой тосгонтой. Тэгээд тэр тосгоныхоо эрх зүйн байдлыг бүрэн шийдвэрлэж байгаа энэ журам гарч байхад энд бол гишүүд жаахан идэвхтэй оролцох нь зүйтэй шүү. Санал хураалт явуулъя.

Ямар ач холбогдолтой юм бэ гэхээр ингээд тосгон гэхээрээ ингээд сум биш учраас төрийн үйлчилгээг авахад их бэрхшээлтэй байгаа юм. Тухайн сум руугаа 30, 40 км явж зарим нь төрийн үйлчилгээг авдаг болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас энэ сум болчих юм бол сумд байх ёстой бүхий л төрийн үйлчилгээнүүд нэг дороос авах боломжтой болно. Одоо Хэнтий аймаг байна. Олон тосгонтой. Булган аймаг гээд олон тосгонтой байж байна. Эдгээр сумдын тосгод чинь сум болох эрх зүйн үндэс нь бүрдэх гээд байна шүү дээ. Сэлэнгэ аймагт бас олон тосгон байгаа. Танайх чинь 6 тосгонтой тийм ээ Дамдинням гишүүн ээ. Тэдгээр чинь сум болох эрх зүйн үндэс нь энд байна шүү Дамдинням гишүүн ээ. Яг үнэн. Алслагдсан 3 дүүрэг бол хот болох эрх зүйн боломж чинь бас үүгээр бүрдэнэ. Гишүүд та бүгдэд хамааралтай, та бүгдийг итгэж сонгосон тэр сонгогчдын чинь л тавиад байгаа асуудлыг л шийдвэрлэж байгаа энэ чухал журам батлагдаж байгаа шүү. Болсон байна. Гишүүд байраа эзэлье.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Баатарбилэг, Сүхбаатар /цаашид “ажлын хэсэг” гэнэ/. Санал хураалт гишүүд ээ. Улсын Их Хурлын гишүүн Болорчулуун горимын санал гаргая.

Х.Болорчулуун: Энэ кноп ажиллахгүй болчихлоо. Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулъя.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулууны гаргасан саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүйд тооцогдлоо.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн хавсралтын 1.1, 1.3 дахь заалтыг нэгтгэн 1.1 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөх:

“1.1 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3 дахь хэсэгт заасан аймаг, сум, дүүрэг, /цаашид “нэгж” гэх/-ийг өөрчлөх асуудлыг санаачлах, нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах, иргэдийн санал авах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд суугаарай. Бямбацогт гишүүн суу. Дамдинням гишүүн суу.

Санал хураалт. Санал хураалтын хонх яагаад дуугарсангүй вэ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Та нар бас шуугилдаад байхаар чинь бүдэг сонсогдоод байгаа шүү. Санал хураалт. 56,8 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн хавсралтын 2.1.6 дахь дэд заалтын “тухайн орон нутгийн нутаг дэвсгэр (газар, хилийн цэс), хүн ам зүй” гэснийг “өөрчлөлтөд хамрагдах нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нутаг дэвсгэр, хилийн цэс, хүн ам” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн хавсралтын 2.1.5 дахь дэд заалтын “зогсоож, өөр нэгжид (аймаг, сум, дүүрэг), нутаг дэвсгэр, захиргааны хувьд харьяалуулахыг” гэснийг “зогсоохыг” гэж өөрчлөх. Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн хавсралтын 2.1.1 дэх дэд заалтын “хуваах” гэсний дараа “, шилжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.5 дахь дэд заалт нэмэх:

“2.1.5. “нэгжийг шилжүүлэх” гэж тухайн нэгжийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөхийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн хавсралтын 3.1.1 дэх дэд заалтын “газар зүй” гэснийг “газар зүйн онцлог, орон зайн байршил,” гэж, 3.1.2 дахь заалтын “дэвсгэрийн хувьд” гэснийг “дэвсгэр” гэж, 3.1.4 дэх дэд заалтын “нутгийн” гэснийг “орон нутгийн” гэж, 3.1.5 дахь дэд заалтын “угсаатан зүй” гэснийг “угсаатны онцлог” гэж, 3.1.6 дахь дэд заалтын “ашиг, өгөөжтэй” гэснийг “ашигтай” гэж тус тус өөрчилж, 3.1.6 дахь дэд заалтын “эдийн засгийн” гэсний өмнө “нийгэм” гэж

нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ганибал гишүүн суудалдаа сууж саналаа өгөөрэй. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн хавсралтын 3.1.3 дахь дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,8 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн хавсралтад доош дурдсан агуулгатай 4.1, 4.2 дахь заалт нэмэх:

“4.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.2-т заасны дагуу аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна.

4.2.Нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага өөрчлөлтөд хамрагдах нэгжид нэгжийн Засаг даргын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг боловсруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн хавсралтын 4.2 дахь заалтыг доош дурдсаар өөрчлөн найруулж, 4.4 дэх заалт болох:

“4.4.Ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдээллийг тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,8 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн хавсралтын 4.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн хавсралтын 4.1.3 дахь дэд заалтын “хөдөлгөөнийг” гэснийг “хөдөлгөөний хандлагыг” гэж, 4.1.5 дахь дэд заалтын “төрийн” гэснийг “иргэдэд зориулсан төрийн” гэж, мөн дэд заалтын “үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй” гэснийг “үйлчилгээний

чанар, хүртээмж өмнөх түвшинээс дээшилсэн” гэж тус тус өөрчилж, 4.1 дэх хэсгийн “Засгийн газар, түүний харьяа яам, агентлаг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хэн саналаа өгсөнгүй. Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулуун горимын санал гаргая.

Х.Болорчулуун: Энэ кноп гацаад байна. Дахин санал хураалт явуулъя.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулууны гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт 56,8 хувиар санал дэмжигдлээ. Одоо үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ. 56,8 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн хавсралтын 5.1 дэх заалтын “үнэлгээ” гэснийг “шинжилгээ” гэж, 5.3 дахь заалтын “дүүргийн хувьд” гэснийг “дүүргийг” гэж, мөн заалтын “аймгийн хувьд” гэснийг “аймгийг” гэж, 5.4 дэх заалтын “асуудлын талаар иргэдээс өөрчлөлтийг “дэмжиж байна”, “дэмжихгүй гэсэн томъёоллоор санал” гэснийг “асуудлаар иргэдийн саналыг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан саналын хуудсаар” гэж, 5.5 дахь заалтын “сонгуулийн насны иргэдийн олонх оролцсон бол санал авах ажлын дүнг” гэснийг “сонгуулийн эрх бүхий иргэд оролцох бөгөөд олонх нь оролцсон бол санал хураалтыг” гэж, 5.10 дахь заалтын “санал хураалтын нэгдсэн дүнг санал хураалтаас хойш” гэснийг “санал хураалт дууссаны дараа саналын хуудсыг тоолж, дүнг” гэж, 5.11 дэх заалтын “5” гэснийг “3” гэж тус тус өөрчилж, 5.10 дахь заалтын “нэгдсэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд саналаа өгөөрэй. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 5.4, 5.5 дахь заалт нэмэх:

“5.4.Аймгийг өөрчлөх асуудлаар Засгийн газар, сум, дүүргийг өөрчлөх асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.

5.5.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгжийг өөрчлөх асуудлаар урьдчилан тогтоосон байранд битүүмжилсэн саналын хайрцаг ашиглан нууц санал хураалт явуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн хавсралтын 5.3 дахь заалтын “арга хэмжээг” гэсний дараа “энэ журмын 4.2-т заасан ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулан хүлээлгэн өгснөөс хойш” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

18 цаг өнгөрсөн байна. Ингээд хэлэлцэх асуудал дуусаагүй байгаа тул чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэн хуралдуулахаар шийдвэрлэлээ.

16.Төслийн хавсралтын 5.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Өөрчлөлтөд хоёр ба түүнээс олон нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт 56,8 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн хавсралтын 5.8 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт санал хураалт 59,5 хувиар санал дэмжигдлээ.

18.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын 1.4 дэх мөрний “асуудал” гэсний дараа “/өөрчлөх болсон үндэслэл, шалтгаан/” гэж, 1.5 дахь мөрний “хуваах” гэсний дараа “шилжүүлэх” гэж, 3.1 дэх мөрний “Хучилттай” гэсний өмнө “Хатуу” гэж, 4.2 дахь мөрний “Боловсрол” гэсний дараа “Мэргэжлийн сургалтын байгууллагын тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,8 хувиар санал дэмжигдлээ.

19.Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийн “ТАЛААРХ” гэснийг “ТӨСЛИЙН” гэж, 1.1 дэх мөрний “Харьяалал /аймаг, сум, нийслэл, дүүрэг/” гэснийг “Нэгжийн харьяалал /аймаг, дүүрэг/ гэж, 1.2 дахь мөрний “Тухайн нэгж” гэснийг “Нэгжийн нэр” гэж тус тус өөрчилж, 2.1 дэх мөрний “/2010, 2020 он/” гэснийг, тайлбар хэсгийн “агентлаг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

20.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын “...аймгийн ... сумыг /дүүрэг/” гэснийг “... засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,1 хувиар санал дэмжигдлээ.

21.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын “хуваах” гэсний дараа “шилжүүлэх” гэж тохиолдол бүрд нэмж, “татан буулгах” гэснийг тохиолдол бүрд хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,4 хувиар санал дэмжигдлээ.

Байгаль орчин хүнс, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал дарга дэмжсэнийг протоколд тусгаарай.

22.Тогтоолын төслийн болон хавсралтын талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалт, дэд заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулгыг алдагдуулахгүйгээр хүснэгтийн загварыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлье. Одоо 2 Байнгын хороо хуралдана. Гишүүд байнгын хорооныхоо хуралд оролцоорой.

18.23 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ